

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
НОМЫН САН
THE NATIONAL LIBRARY OF MONGOLIA

# НИЙТИЙН НОМЫН САНГУУДЫН ТАЙЛАН 2024(2)

УЛААНБААТАР ХОТ

2025 он

# НИЙТИЙН НОМЫН САНГУУДЫН ТАЙЛАН 2024(2)

*(Тайлангийн эмхэтгэл)*

УЛААНБААТАР ХОТ

2025 он

ННА 78
DDC 020
Н 615

# Нийтийн номын сангуудын тайлан 2024(2)

Эмхэтгэсэн: Б.Сарандэлгэр /Арга зүйч/

Хянасан: Т.Хайдав /МАЗЭШХ-ийн дарга/

**ISBN 978-9919-9114-7-8**

## ГАРЧИГ

ГАРЧИГ.......................................................................................................................04

ӨМНӨХ ҮГ  ...................................................................................................................05

АРХАНГАЙ АЙМГИЙН С.ЖАМЬЯНГАРАВЫН НЭРЭМЖИТ НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН.............................................06

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН Б. АХТАНЫ НЭРЭМЖИТ ТӨВ НОМЫН САНГИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН ...........................................................................57

БАЯНХОНГОР АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН ...........................................................................................115

БУЛГАН АЙМГИЙН С.УДВАЛЫН НЭРЭМЖИТ ТӨВ НОМЫН САНГИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН ..........................................................................130

ХАВСРАЛТ...................................................................................................................187

ДҮГНЭЛТ...................................................................................................................... 205

# ӨМНӨХ ҮГ

Технологийн хөгжилт, мэдээллийн хязгааргүй өсөлтийн энэ үед ард иргэдийг соён гэгээрүүлэгч, номын сан, мэдээллийн байгууллагын хэрэгцээ шаардлага улам ихээр бий болж байна. Дээрх өсөлтүүд нь номын сангуудыг соёл, боловсролын шинэлэг хэлбэрээр үйлчилгээ үзүүлэхийг зүй ёсоор шаардаж байна. Энэ шаардлагад нийцэх, хүрч ажиллахын тулд аймаг, нийслэлийн номын сангууд бүхий л талаараа хичээнгүйлэн ажиллаж ирсний илрэл, ул мөрийг энэхүү тайлангаас үзэх болно. Өмнөх жилүүдэд тус тайлан 300-600 хуудас болдог байсан бол энэ жил 800 гаруй хуудастай болж байгаа нь үүнийг илтгэх нэгэн сэжим болно. Өдий хэмжээний хуудастай номыг цахим файлд хөрвүүлэн уншихад ачаалал өгөх тул 200 хуудсаар нь салган 4 боть болгон нийтлүүллээ.

Өнгөрөгч 2024 он Монголын номын сангийн салбарт олон чухал, түүхэн үйл явдал болж өнгөрсний нэг нь Монгол Улсын Үндэсний номын сангийн салбар шинэ салбар ашиглалтад орж, номын санч- мэдээллийн ажилтнуудын сүүлийн 30 гаруй жилийн мөрөөдөл биелж, Монгол Улсын Соёлын яам, Монгол Улсын Үндэсний номын сан хамтран номын сангийн нэгдсэн системийг хөгжүүлэн, ашиглалтад хүлээн авснаар, аймаг орон нутгийн номын сангуудыг нэгдсэн системд холбон, албан хаагчдыг чадавхжуулах сургалтыг 21 аймгийн 216 номын санч мэдээллийн ажилтнуудад зохион байгууллаа. Энэ нь ном зүйн мэдээллийг автоматжуулж, үйл ажиллагаандаа орчин үеийн техник, технологийг нэвтрүүлж, электрон мэдээллийн нэгдсэн санг бий болгох, хүртээмж нэмэгдүүлэхэд бодит хувь нэмрийг оруулсан явдал мөн.

Эмхэтгэлийн төгсгөлд уламжлал ёсоор аймаг, нийслэлийн нийтийн номын сангуудын үйл ажиллагааны статистикийн зарим үзүүлэлтүүдийг хүснэгтээр хавсаргалаа.

Эдгээр мэдээллүүд номын сангуудыг үйл ажиллагааг эрчимжүүлэх, сайжруулахад нэмэр болно гэдэгт итгэлтэй байна. Тайлантай холбоотой санал, хүсэлтээ манай номын сангийн lavlagaanomzui@gmail.com хаягаар болон 70188882 утсаар ирүүлнэ үү.

**МЭДЭЭЛЭЛ, АРГА ЗҮЙ, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС**

**ЭРДЭНЭ МЭРГЭН БАНДИДА, ХАНЧИН ХАМБА СҮРЭНХОРЫН ЖАМЪЯНГАРАВЫН НЭРЭМЖИТ АРХАНГАЙ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ БА ТОВЧ АГУУЛГА


**НЭГ:** НОМЫН САНГИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1. Эрхэм зорилго

1.2. Номын сангийн танилцуулга

**ХОЁР:** НОМЫН САНГИЙН САН ХӨМРӨГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ

2.1. Сан хөмрөгийн өнөөгийн байдал

2.2. Сан хөмрөгийн хадгалалт хамгаалалт

2.3. Каталоги зохион байгуулалт

**ГУРАВ:** НОМЫН САНГИЙН УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

3.1. Уншлага үйлчилгээ

3.2. Нүүдлийн номын сангийн үйлчилгээ

3.3. “Их мэдэх” танхим

3.4. “Эко” танхим

3.5. Ангийн уншлага

3.6. “Үлгэрээс үлгэрлэе” үлгэрийн цаг

3.7. Номын үзэсгэлэн

3.8. Лавлагаа, номзүйн ажил

3.9. Цахим үйлчилгээ

3.10. Мэргэжил, арга зүйн ажил

**ДӨРӨВ:** СОЁЛ ОЛОН НИЙТИЙН АЖИЛ

**ТАВ:** ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ

**ЗУРГАА:** ТӨСӨВ, САНХҮҮ

**ДОЛОО:** СУРГАЛТ, СЕМИНАР

**НАЙМ:** БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА


Тайлбар: Архангай аймгийн  нийтийн номын сангийн 2024 оны жилийн эцсийн үйл ажиллагааны тайланг 8 бүлэгт хуваан тайлагналаа.

## **НЭГ:** НОМЫН САНГИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1. Эрхэм зорилго: Аймгийн нийт иргэдийг мэдээллээр хангах, соёлын үнэт өв болох ном хэвлэлийг хадгалах, хамгаалах, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, дэлхийн жишигт нийцсэн орчин үеийн мэдээллийн төв бий болгох, мэдээллийн чөлөөт урсгалыг хөгжүүлэх, ном хэвлэлийн бүтээгдэхүүн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, номын сангийн стандартыг хангаж ажиллахад оршино.

1.2. Номын сангийн танилцуулга: Аймгийн нийтийн номын сан 1945 онд, Хүүхдийн номын ордон 1987 онд байгуулагдсан. 648 $м^2$ талбайтай хүүхдийн номын ордны шинэ барилга 2013 онд, 348 $м^2$ талбайтай нийтийн номын сангийн шинэ барилга 2017 онд тус тус ашиглалтанд орсон. Орон тооны нийт 11 ажиллагсадтай үйл ажиллагаагаа явуулж байна.

Нийтийн номын сан:

- ✓ Захирлын өрөө
- ✓ VIP өрөө
- ✓ Үндсэн фонд
- ✓ Тогтмол хэвлэлийн фонд
- ✓ Лавлагаа номзүйн фонд
- ✓ Нийтийн уншлагын танхим /Ойрын фонд/
- ✓ Үзэсгэлэнгийн танхим /Номын фонд/
- ✓ Зөөврийн номын санчийн өрөө
- ✓ Цайны өрөө
- ✓ Жижүүрийн өрөө

Хүүхдийн номын ордон:

- ✓ Хүүхдийн уншлагын танхим
- ✓ Мэдээлэл технологийн ажилтны өрөө
- ✓ Хүүхдийн уншлагын танхимын фонд
- ✓ Гадаад номын фонд
- ✓ “Их мэдэх” танхим
- ✓ Монгол бичиг, Англи номын фонд
- ✓ Эко танхим
- ✓ Нягтлан бодогчийн өрөө

- ✓ Архивын өрөө

Цахим хаяг: “Архангай – Нийтийн номын сан” пэйж хуудас, Е – Мэйл хаяг Library.arkh@gmail.com.

Цагийн хуваарь: Даваа - Баасан гаригт 9:00 - 13:00, 14:00 - 18:00 цаг, /13:00 – 14:00 цайны цаг/

Номын сангийн захирал: О. Мөнхтуяа

Байгуулагын утас: 70333248, 70332353

## **ХОЁР:** НОМЫН САНГИЙН САН ХӨМРӨГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ

2.1. Сан хөмрөгийн өнөөгийн байдал: Уншигчдын эрэлт хэрэгцээг үндэслэн татгалзлалын дэвтэр хөтөлж, тухайн жилийн батлагдсан төсвөөс сан хөмрөгийн баяжилтаа хийж ирсэн. 2024 оны жилийн эцсийн байдлаар 3.420.800 төгрөгийн 71 ширхэг ном, 1.038.600 төгрөгийн 11 нэр төрлийн сонин сэтгүүлээр сан хөмрөгийн баяжилт хийсэн байна.

2.2. Сан хөмрөгийн хадгалалт хамгаалалт: Номын сангийн чухал зүйлийн нэг бол сан хөмрөгийн хадгалалт хамгаалалт байдаг. Иймээс 2024 оны жилийн эцсийн байдлаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Сан хөмрөгт хадгалагдаж байгаа урагдаж, гэмтсэн 1154 ширхэг номыг сэлбэн засаж уншлагад гаргахад бэлэн болгосон.

2. Сан хөмрөгт хадгалагдаж байгаа нийт ном, хэвлэл болон тавиурын тоосыг арчиж цэвэрлэсэн.

3. Номын сангийн фондын өрөөнүүдийн дулаан, чийгшилд өдөр бүр хяналт тавьж ажилладаг.

4. Байгууллагын өрөө тасалгаануудад улирал бүр их цэвэрлэгээ, ариутгал хийлгэдэг.

5. Шинээр ирсэн 71 ширхэг номонд техник ажиллагаа хийж ШУ – ны салбараар ангилж үндсэн фонд, нийтийн уншлагын танхим, хүүхдийн уншлагын танхимуудад хувиарлалаа.

6. 2024 онд өдөр тутмын, чөлөөт давтамжтай, орон нутгийн 11 нэр төрлийн сонин, сэтгүүлийг улирал бүр захиалж уншлагад гаргасан. Мөн стандартын дагуу

үдэж хавтаслан, хаягжуулж сонин сэтгүүлийн нэг бүрчилсэн бүртгэлд дансалж, тогтмол хэвлэлийн фондод шилжүүллээ.

7. Нийтийн уншлагын танхимын ойрын фонд болон үндсэн фондын А танхимын бүх тавиурын хаяг ялгагчийг шинэчилсэн.

8. 2024 оны жилийн эцсийн байдлаар Архангайн амьдрал, Архангайн толь сонины 1947 оноос 2021 оны хооронд хэвлэгдсэн 3175 нүүр мэдээллийг Үндэсний тогтмол хэвлэлийн цахим нэгдсэн санд байршуулсан.

2.3. Каталоги зохион байгуулалт: Үүлэн технологид суурилсан электрон каталогийн коха программыг үйлчилгээндээ нэвтрүүлсэн бөгөөд хүүхдийн уншлагын танхимын фонд, нийтийн уншлагын танхимын фонд, тогтмол хэвлэлийн фонд, үндсэн сан хөмрөгт хадгалагдаж байгаа монгол хэл дээр хэвлэгдсэн нийт 16989 нэр төрлийн 58000 ширхэг номын мэдээллийг шивж оруулж ном бүрийн бар кодыг наасан. 2024 оны жилийн эцсийн байдлаар шинээр ирсэн 71 ширхэг номын мэдээллийг нэмж оруулсан ба 1658 ширхэг номын дутуу мэдээллийг засаж оруулсан.

## **ГУРАВ:** НОМЫН САНГИЙН УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Нийтийн номын сан нь төрөлжсөн 12 танхимаар иргэд, уншигчдад үйлчилгээ үзүүлдэг. 2024 онд үндсэн фонд, нийтийн болон хүүхдийн уншлагын танхимаар, гэрээр, зөөврийн номын сангийн үйлчилгээ, нүүдлийн номын сангийн үйлчилгээ, Автобустай уншлага арга хэмжээгээр нийт 3942 уншигч шинээр бүртгэж, давхардсан тоогоор 20412 ирэгсдэд 55209 ширхэг ном, 2540 ширхэг сонин, сэтгүүлээр үйлчилгээ үзүүлсэн.

3.1. Уншлага үйлчилгээ: Уншлага үйлчилгээг дараах байдлаар тус тус хүргэсэн байна.

1. Нийтийн уншлагын танхим: 2024 онд 1250 уншигч шинээр бүртгэж, 7280 ирэгсдэд давхардсан тоогоор 18250 ширхэг ном, 2540 ширхэг сонин, сэтгүүл танхимаар болон гэрээр, СОНА – аар дамжуулан олгосон байна.




2. Үндсэн фонд: 720 уншигч шинээр бүртгэж 4286 ирэгсдэд 6819 ширхэг ном гэрээр олгосон.

3. Хүүхдийн уншлагын танхим: 1470 уншигч шинээр бүртгэж 8846 ирэгсдэд 21930 ширхэг номыг танхимаар болон гэрээр олгосон.

4. Зөөврийн номын сангийн үйлчилгээ: Уншигчдад номын сангийн үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх, номын сангийн уншигчдын тоог нэмэгдүүлэх, үйлчлүүлэгчдийн хүрээг өргөжүүлэх зорилгоор зөөврийн номын сангийн үйлчилгээг гэрээний дагуу аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Зэвсэгт хүчний 342 – р анги, Дотоодын цэргийн 331 – р тусгай салбарын 502 уншигчдад 8210 ширхэг ном олгосон. Зөөврийн номын сангийн үйлчилгээний тайлан мэдээг хагас, бүтэн жилээр маягтын дагуу гаргаж Үндэсний номын санд тайлагнадаг.

3.2. Нүүдлийн номын сангийн үйлчилгээ: Нүүдлийн номын сангийн үйлчилгээг иргэдэд байгаа газарт нь хүргэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, ном уншлага, номын сангийн үйлчилгээг түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулах зорилгоор жил бүр уламжлал болгон алслагдсан баг, сум, сууринд хүргэдэг.

2024 онд Булган уулын урд талбай, Бор толгойд байрлах тоглоомын талбай, орон сууцнуудын тоглоомын талбайд байрлаж 400 гаруй оршин суугчдад номын сангийн танилцуулга хийж, карт нээж, ном уншууллаа.









3.3. “Их мэдэх” танхим: Цэцэрлэгийн насны хүүхдүүд болон ЕБС – ийн бага ангийн сурагчдад зориулан тохижуулсан “Их мэдэх” танхимаар 2024 онд бие даалтын 7 хоногийн хүрээнд 145 багш, эцэг эхчүүд, 1700 орчим хүүхэд, багачууд үйлчлүүлж нийт 4150 ном олгосон байна. Мөн хүүхдийн номын ордон, нийтийн номын сантай танилцаж үйл ажиллагаа, СОНА, үйлчилгээний талаар мэдээлэл авлаа.
















3.4. “Эко” уншлагын танхим: Уншигчдад байгаль орчноо танин мэдэх, хайрлан





хамгаалах сэдэл төрүүлэх зорилгоор “Эко” танхимыг ажиллуулдаг. Уг танхимд 2024 оны хагас жилийн байдлаар 1500 орчим иргэсэд үйлчлүүлж 3800 ширхэг ном олгосон. “Миний Архангай” сэдвийн хүрээнд хийсэн сурагч, эцэг эхчүүдийн бүтээл, номын баярын хүрээнд зохион байгуулсан “Номын ертөнц” гар зургийн уралдаанд шалгарсан бүтээлүүдийн үзэсгэлэнг үзэж сонирхлоо.

3.5. Ангийн уншлага: Эрдэнэбулган сумын I, II, III, IV,  V сургуулийн бага, дунд бүлгүүд ангийн уншлага тогтмол хийдэг. 2024 оны жилийн эцсийн байдлаар бие даалтын 7 хоногоор 3500 гаруй иргэсдэд 7420 номоор үйлчилгээ үзүүлж үлгэр, өгүүллэг уншиж өгч, ном унших ач тусын талаар мэдээлэл хийсэн байна.

3.6. “Үлгэрээс үлгэрлэе” арга хэмжээ: “Үлгэрээс үлгэрлэе” чанга уншлагыг хүүхдийн уншлагын танхим, эко танхим, их мэдэх танхимаар үйлчлүүлсэн уншигчдад болон ЭБ сумын 1 – 15 – р цэцэрлэгийн ахлах бүлгийн хүүхдүүд, бага ангийн сурагчдад зориулж 2024 онд 45 удаа нийт 1830 хүүхэд багачуудад хүргэлээ.










3.7. Номын үзэсгэлэн: 2024 оны жилийн эцсийн байдлаар шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 2400 номоор гаргаж 4500 орчим иргэд уншигчдад сурталчилан таниуллаа.









3.8. Лавлагаа, номзүйн ажил: 2024 онд 150 иргэд, уншигчдад Өдрийн сонин, Хөдөлмөр сонин, Монголын үйлдвэрчний эвлэл сэтгүүл, Цог сэтгүүл, Хүмүүн бичиг, Архангайн амьдрал, Монголын үнэн, Утга зохиол урлаг, Улирал ба зохиолч, Зууны мэдээ, Архангайн үнэн, Пионерийн үнэн, Хүүхдийн хүмүүжил, Намын үнэн, Анагаах арга билэг, Төрийн мэдээлэл, Архангайн толь, Утга зохиол урлаг, Өнөөдөр сонин зэрэг 19 нэр төрлийн 357 нэгж тогтмол хэвлэлээс лавлагаа, мэдээлэл хүргэлээ.






- Төрийн шагналт, Соёлын гавьяат зүтгэлтэн, Д. Нацагдоржийн нэрэмжит шагналт зохиолч Цэндийн Доржготовын зохиол бүтээлээр санамж өгөх номзүйг эхлүүлээд байна. Үүнд: Зохиолч Ц. Доржготовын бие даасан 26 ширхэг ном, бүтээл бусад хянан засварласан, оролцсон 24 ном, товхимол. Утга зохиол сонины 1970 – 1995 оны 67 нийтлэл, өгүүлэл, шог зураг, Цог сэтгүүлийн 1970 – 2010 оны 27 нийтлэл, Тоншуул сэтгүүлийн 1970 – 2010 оны 230 гаруй өгүүллэг, нийтлэл, шог зургийг түүвэрлэн эмхэтгэж, номзүйн бичилтийг хийж байна.

3.9. Цахим үйлчилгээ: “Архангай – Нийтийн номын сан” пэйж хуудас, и-мэйл хаягаар 450 иргэд, уншигч холбогдож ном, тогтмол хэвлэлийн бүтээгдэхүүнээс мэдээлэл шүүлгэж, СОНА – д оролцож, бүртгүүлж, лавлагаа үйлчилгээ авлаа.

3.10. Мэргэжил, арга зүйн ажил: МСҮТ, Гурван тамир, ЭБ сумын 4, 1 – р сургуулийн номын санч, Цэнхэр, Жаргалант, Цахир, Чулуут, Төвшрүүлэх, Булган,






Хотонт, Эрдэнэмандал, Цэцэрлэг, Өлзийт, Их тамир, Хайрхан сумын Соёлын

төвийн номын санчдад 29 удаа цахимаар, танхимаар, утсаар мэргэжил аргазүйн зөвлөгөө өгсөн. Сумын Соёлын төвүүдийн номын санчдын группээр мэдээлэл солилцож, мэргэжлийн болон бусад сургалтанд хамруулах, мэдээ мэдээллээр хангаж ажилладаг.

Сумдын номын санчдыг чадавхжуулах сургалтыг "Номын сангийн фонд, түүний бүрдүүлэлт, зохион байгуулалт, хадгалалт хамгаалалт"; "Хүүхдийн уншлага - үйлчилгээний онцлог түүнийг дэмжих арга замууд"; "Номын сангаас зохион байгуулах СОНА - ын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага"; "Номын сангийн автоматжуулалт, цахим үйлчилгээний тухай ерөнхий ойлголт" сэдвүүдээр 2024.03.20 - ны өдөр зохион байгуулж туршлага солилцлоо.







**ДӨРӨВ:** СОЁЛ ОЛОН НИЙТИЙН АЖИЛ

2024 оны жилийн эцсийн байдлаар 32 төрлийн СОНА зохион байгуулж 6755 иргэд уншигч оролцож, нийт 9697 иргэн хамрагдлаа. Үүнээс хүүхэд давхардсан тоогоор 6347, насанд хүрэгч 3350 байлаа. Цахим орчинд зохион байгуулсан СОНА – аа сурталчлах зорилгоор “Архангай – Нийтийн номын сан” пэйж хуудсанд 109 удаа мэдээлэл байршуулж давхардсан тоогоор 427000 гаруй хүн үзэж мэдээлэл авсан байна.

4.1. "Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр" - ийг тохиолдуулан жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "ЭЭЖДЭЭ ЗАХИДАЛ БИЧЭЭРЭЙ" захидлын уралдааны шалгаруулалтын арга хэмжээ боллоо. Захидлын уралдааныг насанд хүрэгч, ЕБС – ийн дунд анги /6 – 9/, ахлах анги /10 – 12/ гэсэн 3 насны ангиллаар зохион байгууллаа. 325 захидал ирсэн ба 375 хүн хамрагдсан.



4.2. Монгол улсад Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсч хөгжсөний 102 жилийн ой, “Монгол цэргийн өдөр” - ийг тохиолдуулан Нийтийн номын сан, Аймгийн цэргийн штаб хамтран 2024 оны 03 дугаар сарын 18 – нд “Аавдаа захидал бичээрэй” уралдааныг насанд хүрэгч, ЕБС – ийн дунд анги /6 – 9/, ахлах анги /10 – 12/ гэсэн 3 насны ангиллаар зохион байгууллаа. Захидлын уралдаанд Судан улс, Оросын холбооны улс, Улаанбаатар хот болон Эрдэнэбулган, Хайрхан, Чулуут, Цэнхэр, Эрдэнэмандал, Цэцэрлэг, Тариат, Өлзийт, Өгийнуур зэрэг сумдаас нийт 280 захидал ирсэн. 430 иргэд, уншигчид хамрагдлаа.









1967 оноос эхлэн жил бүрийн 4 - р сарын 2 - ны өдрийг "Дэлхийн хүүхдийн номын өдөр" болгон тэмдэглэсээр ирсэн. 2024 оны 04 дүгээр сарын 02 – нд “Дэлхийн





хүүхдийн номын өдөр" - ийг тохиолдуулан "Номын ертөнцөөр" арга хэмжээг хөтөлбөрийн дагуу аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эцэг эхийн зөвлөлийн гишүүд, хүүхдүүдийг номтой нөхөрлүүлэх, гэр бүлийн уншлагыг дэмжих, бүтээлчээр унших аргад сургах зорилгоор зохион байгууллаа.

4.3. 2024 оны 05 дугаар сарын 04 – нд Монгол улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлигийг хэрэгжүүлэх, ном хэвлэл, ёс заншил, өв соёл, монгол хэл бичгийн хэрэглээг түгээн дэлгэрүүлэх зорилгоор жил бүр уламжлал болгон "Үндэсний бичиг үсгийн баяр" – ыг зохион байгуулдаг. 2024 онд "Үндэсний бичиг үсгийн баяр" – ын арга хэмжээг Нийтийн номын сангаас 21 дэх жилдээ зохион байгууллаа. 2024 оныг "Үндэсний бичиг, соёлын жил" болгон зарласан нь илүү онцлогтой ба өргөн дэлгэр тэмдэглэн өнгөрүүллээ. "Зөв сайхан бичигтэн", "Түргэн уншлага" уралдааныг дунд анги, ахлах анги, насанд хүрэгсэд гэсэн 3 насны ангиллаар, "Уран бичлэг" уралдааныг сурагч, насанд хүрэгч гэсэн 2 ангиллаар танхимаар зохион байгуулж нийт 650 гаруй иргэд, уншигчид оролцлоо.






4.4. 2024 оныг ҮНДЭСНИЙ БИЧИГ, СОЁЛЫН ЖИЛ болгон зарласантай холбогдуулан "Үндэсний бичиг үсгийн баяр - 2024" арга хэмжээний хүрээнд аймгийн төрийн байгууллагуудын албан хаагчдын дунд анх удаа "МӨНХ ТЭНГЭРИЙН БИЧИГ" монгол хэл, бичгийн тэмцээнийг санаачлан зохион байгууллаа. Нийт 14 багийн 42 албан хаагч хамрагдлаа.










Сумдын Соёлын төвийн номын санчдын дунд "Миний мэргэжил сайхан" - мэргэжил ур чадвар, танин мэдэхүйн тэмцээнийг амжилттай зохион байгууллаа. 18 сумын номын










санчид хамрагдаж багаар ажиллалаа.

4.5. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль, Монгол улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлигийг хэрэгжүүлэх, бүх нийтийн уншлагыг дэмжих, хүүхэд залуусыг номтой нөхөрлүүлэх, ном эрдмийг түгээн дэлгэрүүлэх зорилго дэвшүүлэн Архангай аймгийн нийтийн номын сангаас “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд - 2024” буюу “Илүү их уншъя” уриатай 35 дахь














удаагийн хаврын номын баярын арга хэмжээг 2024.05.17 - 19 - ний өдрүүдэд зохион байгууллаа. Номын баяр орон даяар нэг өдөр, нэг цагт эхэлдэг. Уг арга хэмжээний хүрээнд дараах ажлуудыг зохион байгууллаа. Үүнд:

- Нээлтэд СУГ - ын захиргаа удирдлагын хэлтсийн дарга Д. Аварзад, СУГ - ын хэлтсийн дарга Ш. Нямдаваа, Эрдэнэ мэргэн бандида, ханчин хамба Сүрэнхорын Жамъянгаравын бага охин Дэнсмаагийн үр хүүхдүүд, Зоонозын өвчин судлалын төвийн дарга Б. Эрдэнэчимэг, "Ар Арвис" ХХК - ний захирал Б. Пүрэвдорж, ахмад уншигчид, “Тайхар таталбар” сургалтын төвийн уран бичлэгийн үзэсгэлэн, сэдэвчилсэн номын үзэсгэлэн, “Миний Архангай” сэдэвт бүтээлийн үзэсгэлэн, ЭБ сумын 1 - р сургуулийн 11 - р ангийн сурагчдын “Star light” хамтлаг, Морин хуурч ЭБ сумын 3 - р сургуулийн 10 - р ангийн сурагч Ш. Цэрэндаваа, Б. Мягмардорж, "Хос шигтгээ" хамтлагийн гишүүн ЭБ сумын 1 - р сургуулийн сурагч Номин - Эрдэнэ, Ундрал нарын цэнгээнт бүжиг, 2 - 12 - р ангийн сурагч, эцэг эхчүүд оролцлоо.

- Жил бүрийн номын баярын өдрөөр Нийтийн номын сангийн тэргүүний уншигчдыг шалгаруулж Соёлын яамны шагнал болох “Тэргүүний уншигч Д. Нацагдорж” тэмдэгтэн шагналаар шагнадаг. 35 дахь удаагийн үндэсний номын баяраар

1. О. Есөн - Эрдэнэ /1 - р сургуулийн 12е ангийн сурагч/
2. Б. Ереөлт - Од /4 - р сургуулийн 11б ангийн сурагч, номын сангийн дэргэдэх “Оюуны мэлмий” номын клубын гишүүн/
3. Б. Амараа /1 - р сургуулийн 11б ангийн сурагч/
4. Б. Намуунаа /3 - р сургуулийн 11а ангийн сурагч/
5. М. Хулан /1 - р сургуулийн 6б ангийн сурагч/ нар шагнагдлаа.




- Номын сангаас зохион байгуулдаг олон талт соёл, олон нийтийн ажил, уншлага, үйлчилгээнд идэвхтэй оролцож номын соёлыг түгээн дэлгэрүүлдэг идэвхтэн анги, хамт олныг шалгаруулж шагнаж урамшуулав.

ЭБ сумын 1 - р сургуулийн Ц. Цэрэнбалжид багштай 11в анги, С. Энхцэцэг багштай 2а анги шалгарч талархал, мөнгөн шагналаар шагнагдлаа. Эрдэнэ мэргэн бандида, ханчин хамба Сүрэнхорын Жамъянгаравын бага охин Дэнсмаагийн үр






хүүхдүүд шагналын санг ивээн тэтгэж, номын сангийн гадна хаягийг орчин үеийн гэрэлтдэг хаягаар сольж, номын баярын үйл ажиллагааг дэмжиж ажиллалаа.

Номын баярын хүрээнд аймгийн нийт ЕБС – иудын дунд зохион байгуулсан “НОМОНД БИЧСЭН ЗАХИДАЛ” - ын уралдаанд 200 орчим захидал ирсэн. Үүнээс:

I байр: Б. Уртнасан /1 - р сургуулийн 12а ангийн сурагч/

II байр: Ж. Ганжалам /Чулуут сумын ЕБС - ийн 10б ангийн сурагч/

III байр: М. Болорцэцэг /1 - р сургуулийн 11в ангийн сурагч/

Тусгай байр: Ж. Намуундэлгэр /2 - р сургуулийн 11в ангийн сурагч, номын сангийн дэргэдэх “Оюуны мэлмий” номын клубын гишүүн/ нар тус тус шалгарлаа.









- Номын баярын хүрээнд “Оюунлаг гэр бүл” өдөрлөгийг ЭБ сумын 3 - р сургуулийн 6 - р ангийн 4 бүлгийн сурагч, эцэг эхчүүдийн дунд зохион байгууллаа. Өдөрлөгийн хүрээнд “Миний Архангай” танин мэдэхүйн номыг гэр бүлээрээ уншиж аймаг, орон нутгийн түүх, түүхэн газар нутаг, эмийн ургамал, рашаан булаг, түүхэн хүмүүсийн талаар мэдээлэлтэй болж энэ агуулгын хүрээнд “АХА" танин мэдэхүйн тэмцээн, “Миний Архангай” сэдэвт бүтээлийн үзэсгэлэнг зохион байгууллаа. Танин мэдэхүйн “АХА” тэмцээнд:

I байр: 6в ангийн сурагч Б. Энхбилэг гэр бүлийн хамт

II байр: 6г ангийн сурагч Н. Тулга гэр бүлийн хамт

III байр: 6г ангийн сурагч С. Халиунаа гэр бүлийн хамт шалгарлаа.

"Миний Архангай” сэдэвт бүтээлийн уралдаанд:

I байр: 6а ангийн сурагч Г. Жавхлантөгс

II байр: 6г ангийн сурагч С. Халиунаа

III байр: 6а ангийн сурагч А. Буянжаргал нар тус тус шалгарлаа.






“Оюунлаг гэр бүл” өдөрлөгийн шагналын санг 3 дахь жилдээ ивээн тэтгэсэн “Ар Арвис” ХХК - ын захирал Б. Пүрэвдоржид номын сангийн зүгээс талархал, дурсгалын зүйл гардууллаа.

- Өдөрлөгийн үеэр “Хүүхдийн уншлагад эцэг эхийн оролцоо” сэдэвт сургалт мэдээллийг хийлээ.












4.6. Номын баярын 2 дахь өдөр буюу 2024.05.18 - нд Архангай аймгаас Улаанбаатар, Улаанбаатар хотоос Архангай чиглэлийн хот хоорондын автобусанд зорчиж буй иргэдийн дунд номын сангийн үйл ажиллагааг хүртээмжтэй, шинэлэг хэлбэрээр хүргэх, бүх нийтийн уншлагыг дэмжих, нутаг орны түүх, соёл, түүхэн хүмүүс, түүхэн газар нутгийн талаарх мэдээллийг сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор "Автобустай уншлага" арга хэмжээг зохион байгууллаа.

"АВТОБУСТАЙ УНШЛАГА" арга хэмжээнд:

I байр: Д. Хонгор

II байр: О. Бямбадорж

III байр: Д. Номинчулуун нар тус тус шалгарлаа.

"Автобустай уншлага" арга хэмжээг Архангай аймгийн Авто тээврийн төвийн удирдлага, хамт олон дэмжиж ажиллалаа.













4.7. Номын баярын 3 дахь өдөр буюу 2024.05.19 - нд ЭБ сумын хүүхдийн цэцэрлэгүүдийн бяцхан уншигчдадаа номын сангийн үйл ажиллагааг хүртээмжтэй хүргэх, бүх нийтийн уншлагыг дэмжих зорилгоор "ҮЛГЭРЭЭС ҮЛГЭРЛЭЕ" чанга уншлагыг зохион байгууллаа.





4.8. "ҮЛГЭРЭЭС ҮЛГЭРЛЭЕ" арга хэмжээнд: ЭБ сумын хүүхдийн 1, 4, 6, 8 - р цэцэрлэгийн бэлтгэл, дунд, ахлах бүлгийн 250 гаруй хүүхэд багачууд хамрагдлаа.

4.9. Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан аймгийн Хүүхдийн нэгдсэн Зөвлөлийн сурагчидтай хамтран зохион байгуулсан “Хүүхдийн нэг өдөр” арга хэмжээний хүрээнд ЭБ сумын 1 - р сургуулийн 11г ангийн сурагч Б. Эрдэнэцэцэг, 4 - р сургуулийн 10а ангийн сурагч Б. Мөнхцолмон нар Нийтийн номын сангийн үйл ажиллагаатай танилцаж, мэргэжлийн чиг баримжаа авах, бусад хүүхдүүдэд мэдээлэл өгөх зорилгоор нэг өдрийг номын санд өнгөрүүллээ.







4.10. "АВТОБУСТАЙ УНШЛАГА - 2024" арга хэмжээнд Булган сумын 9 жилийн сургалттай ЕБС - ийн сурагчид хөтөлбөрийн дагуу хамрагдлаа. Булган сумын Соёлын төвийн номын сан Номын баяраа энэ өдөр тэмдэглэж "Шилдэг номын сантай анги" шалгаруулж аймгийн Нийтийн номын сангаас шагналыг гардууллаа.

Хөтөлбөр

1. Архангай аймгийн Нийтийн номын сангаас Булган сумын чиглэлд

/Эрдэнэбулган сумын I, II, III, IV сургуулийн 9, 11, 12 - р ангийн сурагчид/

2. Булган суманд номын баярын нээлтэнд оролцох

3. Булган сумын ЕБС - ийн сурагчид Архангай аймгийн чиглэлд солилцоогоор хөдлөх

4. Нийтийн номын сан, Хүүхдийн номын ордны үйл ажиллагаатай танилцах

5. Цайны завсарлага

6. Хүүхдийн номын санч А. Ундармаа ярилцлага, мэдээлэл өгөх

7. Аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн сургагч багш С. Пүрэвсүрэн "Цаг төлөвлөлт ба тууштай байдал" сургалт

8. Аймгийн ЗДТГ - ын үйл ажиллагаатай танилцах, уулзалт хийх

9. Аймгийн Музей үзэх

10. Дурсгалын зураг татуулах

11. Булган сум руу буцах

12. Булган сумаас Архангай аймаг руу ирэх













4.11. "АВТОБУСТАЙ УНШЛАГА" арга хэмжээнд Эрдэнэбулган сумын I, II, III, IV сургуулийн 9, 11, 12 - р ангийн сурагчид хөтөлбөрийн дагуу хамрагдлаа.

1. Нийтийн номын сангаас Булган сум руу хөдлөх
2. Булган сумын сурагчид аймаг руу солилцоогоор хөдлөх
3. Сурагчид замдаа танилцах
4. "Миний Архангай" танин мэдэхүйн ном унших
5. Булган сумын Номын баярын нээлтэд оролцох /"Шилдэг номын сантай анги" уралдаанд шалгарсан Булган сумын ЕБС - ийн 7а ангийн шагналыг Нийтийн номын сангаас гардуулах/
6. Монгол бүжиг /ЭБ сумын I сургуулийн 11в ангийн сурагч Номин - Эрдэнэ/Монгол туургатны "Миний монгол бичиг" улсын уралдааны бүтээлийн

төрөлд тэргүүн байр эзэлсэн бүтээлийн үзэсгэлэн /ЭБ сумын I сургуулийн 11в ангийн сурагч Хүслэн/

7. Хулсан үзгээр бичих /ЭБ сумын I сургуулийн 11в ангийн сурагч Солонго, Болорцэцэг, Хүслэн/

8. Мөрөөдлийн жигүүртэй хүүхэд нас /ЭБ сумын I сургуулийн 11в ангийн сурагч Уянга, Булганцэцэг/

9. Ятгын гурвал Монгол ардын дуу "Хадат ухаа" /ЭБ сумын III сургуулийн 11а ангийн сурагч Амин - Эрдэнэ, Одмаа, Дэлгэрзаяа/

10. Булган сумын ЕБС, цэцэрлэгт хүрээлэн, Соёлын төв, Номын сан, ятгын дугуйлан, ОНСТ - тай танилцах

11. Өвлөн уламжлагч Отгонбаярын урласан модон эдлэл, тоног төхөөрөмжтэй танилцах

12. Булган сумын сурагчидтай танилцах

13. Соёлын төвийн ОНСТ - с зохион байгуулсан "Түргэн хэллэг хэн сайн хэлэх вэ" тэмцээн /I байр ЭБ сумын III сургуулийн 11б ангийн сурагч Сайханбилэг, II байр ЭБ сумын IV сургуулийн 11б ангийн сурагч, "Оюуны мэлмий" номын клубын гишүүн Ерөөлт - од, III байр ЭБ сумын IV сургуулийн 11б ангийн сурагч Булгантөгс/

14. Соёлын төвийн Номын сангаас зохион байгуулсан танин мэдэхүйн "АХА" тэмцээн /I байр ЭБ сумын IV сургуулийн 11б ангийн сурагч, "Оюуны мэлмий" номын клубын гишүүн Ерөөлт - од, II байр ЭБ сумын I сургуулийн 12в ангийн сурагч Энхмэнд, III байр ЭБ сумын IV сургуулийн 11б ангийн сурагч Сумъяа/

15. Өлзий pixel gallery номын дэлгүүрийн худалдаа

16. Хөгжөөнт тоглоом

17. Сурагчдын "Open mic"

18. Булган сумаас Нийтийн номын сан руу хөдлөх

19. Замын асуулт, хариулт /Зөв хариулт өгсөн сурагчид ЭБ сумын II сургуулийн 11в ангийн сурагч, "Оюуны мэлмий" номын клубын гишүүн Энхжаргал, ЭБ сумын IV сургуулийн 11а ангийн сурагч Батжаргал/

20. Оройн тойрог






















4.13 Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн нэгдсэн арга хэмжээний үеэр Г. Дэмид жанжны талбайд өөрсдийн асрыг барьж өртөө байгуулан “Ээжтэйгээ хамт уншъя” арга хэмжээг уламжлал болгон хөтөлбөрийн дагуу зохион байгууллаа.

4.14 “Төрийн тахилгат Суварга хайрхан уулд холбогдох түүх, шашин, соёлын судалгаа” хэмээх 3 боть номын нээлт боллоо. Ерөнхийлөгчийн тамгын газар, МУИС - ийн Филисофи, шашин судлалын тэнхимийн багш, судлаачдын баг, Архангай аймгийн ЗДТГ, Архангай аймгийн музей болон Цэнхэр сумын ЗДТГ хамтран 2022.09.23 - ны өдөр “Төрийн тахилгат Суварга хайрхан уулд холбогдох түүх, шашин, соёлын судалгаа” сэдэвт эрдэм шинжилгээний хурал зохион байгуулсан билээ. Уг гурван боть бүтээлд 17 илтгэгчийн сонирхолтой илтгэлүүдээс гадна Суварга хайрхан уулын тахилгад холбогдох судар ном, Суварга хайрхан уулд зориулсан дуу шүлэг, магтаал, домог, Суварга хайрхан уулд холбогдох аман эх сурвалж, ярилцлага, баримт материалууд багтсан байна.

  



4.15 "Үндэсний бичиг соёл, номын өдрүүд - 2024" буюу "Илүү их уншъя" уриатай 36 дахь удаагийн Номын баярын арга хэмжээг 2024.09.20 - 22- ний өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүллээ. Нээлтийн арга хэмжээний үеэр "Тэргүүний уншигч Д. Нацагдорж тэмдэгтэн" шагналаар ЭБ сумын I сургуулийн 10в ангийн сурагч,

"Оюуны мэлмий" номын клубийн гишүүн Л. ЭНХЖИН, ЭБ сумын I сургуулийн 10а ангийн сурагч, "Оюуны мэлмий" номын клубийн гишүүн Д. УЯНГА нар шагнагдлаа. "Номын ертөнц" гар зургийн уралдааны ахлах ангийн төрөлд тэргүүн байр ЭБ сумын I сургуулийн 12в ангийн сурагч Б. Гүенбаатар, О. Рэвгийжалбуу, дунд ангийн төрөлд тэргүүн байр ЭБ сумын I сургуулийн 7а ангийн сурагч Б. Булганчимэг, ЭБ сумын I











сургуулийн 9а ангийн сурагч Х. Цэрэнлхам, ЭБ сумын I сургуулийн 9а ангийн сурагч Эгшиглэн, бага ангийн төрөлд тэргүүн байр ЭБ сумын II сургуулийн 4а ангийн сурагч тус тус шалгарлаа.

4.16 "Номын баяр" - ын хүрээнд "Автобустай уншлага" арга хэмжээг ЭБ сумаас Тариат сум, Тариат сумаас ЭБ сум чиглэлд хийлээ.

Уг арга хэмжээний үеэр "Миний Архангай" сэдэвт танин мэдэхүйн тэмцээнийг Тариат сумын Соёлын төвөөс зохион байгуулж ЭБ сумын II сургуулийн 12в ангийн сурагч У. Энхжаргал ахлагчтай "Оюуны мэлмий" номын клубийн гишүүдээс бүрдсэн I баг тэргүүн байр, ЭБ сумын 12б ангийн сурагч Б. Амараа ахлагчтай III баг дэд байранд шалгарлаа.

Тариат сумын ЕБС, Соёлын төвөөс хамтран зохион байгуулсан "Аян замын тэмдэглэл" эссэ бичлэгийн уралдааны тэргүүн байр ЭБ сумын II сургуулийн 12в ангийн сурагч, "Оюуны мэлмий" номын клубийн гишүүн Ж. Намуундэлгэр, дэд байр









Тариат сумын ЕБС - ийн 12а ангийн сурагч Б. Даваажаргал, гутгаар байр ЭБ сумын 12б ангийн сурагч  М. Мөнгөнцэцэг нар шалгарлаа.

Хөтөлбөрийн дагуу Хоргын тогоо, Шар нохойн там, Мөсөн агуй, Ганц хүний агуй, Өвгөн хад, Тэрхийн цагаан нуур, ЕБС - ийн номын сан, Дотуур байр, Соёлын төвтэй танилцаж оюунлаг, танин мэдэхүйн хөгжөөнт буухиа тэмцээнд оролцлоо.

Тариат сумын Соёлын төвийн хамт олон, ЕБС - ийн хамт олон, 12 - р ангийн сурагчдадаа сайн сайхан бүхнийг хүсье.



4.17  "Номын баяр" - 2024 арга хэмжээний хүрээнд "Угийн бичгээ хөтөлцгөөе" сургалтыг Архангай аймгийн Их тамир сумын ахмад багш, БТА, соёлын биет бус өвийн өвлөн тээгч Б. Цэвэгмид, Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын мэргэжилтэн Ш. Гомбосүрэн нар зохион байгууллаа.






4.18 Хүүхэд хамгаалал, хөгжлийн жилийн хүрээнд номын сангийн дэргэдэх номын клуб ажиллуулж эхлэх арга хэмжээг байгууллагын гүйцэтгэлийййн төлөвлөгөөнд тусгасан бөгөөд “ОЮУНЫ МЭЛМИЙ” номын клубийг анх 2024.03.25 – ны өдрөөс 10 гишүүний бүрэлдэхүүнтэй эхлүүлсэн. Одоогоор 16 гишүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байна.

Анхны номын хэлэлцүүлэг: Яруу найрагч, зохиолч Л. Өлзийтөгсийн “Үзэхийн хязгаар” намтарчилсан эсээний энэ ном өөрт тохиолдсон явдлуудаас ургуулан хувь чанарынхаа төлөвшил, уран зохиолыг хэрхэн ойлгож авснаа уншигчидтай





хуваалцсан бүтээл юм. Уншаад олж авсан мэдээлэл, өөрт хэрэгтэй хэрэгжүүлэх зүйлээ баталгаажуулах, ярих бичих чадварыг нэмэгдүүлэх зорилгоор ярилцлага өрнүүлэх, асуулт хариултын тэмцээн, клубын гишүүдийг дотно танилцуулах зорилгоор хөгжөөнт тэмцээн, жүжгэлсэн тоглолт хийх гэсэн 4 хэсгээр номын хэлэлцүүлэгээ явууллаа. “Номын цаг” нэвтрүүлэг: Ном уншлагыг сурталчилах, сэдэлжүүлэх, номын сан, номын клубийн үйл ажиллагааг таниулах зорилгоор





зохион байгуулдаг номын цаг нэвтрүүлэгийн 4 дугаарыг Тамир телевизтэй хамтран хийсэн. Клубын гишүүн Н. Номин – Эрдэнэ хөтлөн хүргэлээ.

Номын хэлэлцүүлэг: Сэтгэл гэх эрхтэн гарт баригдаж нүдэнд харагдахгүй ч хүмүүн бидний хамгийн хүнд ачааг үүрч явдаг эрхтэн. Хайр, Дурсамж, Гэр бүлийн хүчирхийлэл ба нийгмийг харуулсан Архангай аймгийн Жаргалант сумын зохиолч С. Баатарцогтын “Цасан хуй” номоор хэлэлцүүлэг хийлээ. Номын хэлэлцүүлэгийг 4 хэсгээр зохион байгуулж уншсан мэдээлэлээ бататгалаа. 20 – р зууны шилдэг роман С. Пүрэв зохиолчийн “Усны гудамж” номоор дараагийн хэлэлцүүлэгээ хийхээр төлөвлөөд байна.








Номтой уулзалт: Клубын үйл ажиллагаа, хэрэгжүүлэх ажил, төлөвлөгөө, шинэ гишүүд нэмэх зэрэг дотоод асуудлаа ярилцах, сонирхолтой кейс ажиллах, тэмцээн уралдаан зохион байгуулах, өөрсдийн сонгосон сэдвийн хүрээнд илтгэл бичиж тавих, ном болон зохиолын дүр, зохиогчид захидал бичих зэрэг өөрсдийгөө хөгжүүлэх ажлуудыг явуулж клубын гишүүд ээлжлэн сард 2 удаа зохион байгуулдаг.






“Мини номын сан” аялуулах: Сард нэг гэр бүлийг сонгон унших номын захиалгыг авч клубын гишүүд ном болон уншсан номын тэмдэглэл, сэтгэгдэл бичих дэвтэрийг хүргэж үйлчилдэг. Сарын хугацаанд тухайн гэр бүлийн ухаалаг утасны хэрэглээг багасгах, халуун дотно уур амьсгал, амьд харилцааг бий болгох, ном унших сэдэл төрүүлэх зорилгоор аялуулж байна. Мини номын сан хүлээн авсан гэр бүл маань “Оюуны мэлмий” номын клубт ямар нэгэн ном хандивладагаараа онцлогтой. Мини номын сангийн үйлчилгээ 4 гэр бүлд хүрээд байна.






Видео контент: Сошиал орчинд ном уншлагыг сурталчилан түгээх, сэдэлжүүлэх, мессеж илгээх, номын сан болон номын клубын үйл ажиллагааг олонд таниулах, цахим орчинд эерэг хандлага үүсгэх, клубын гишүүд нэгнээсээ суралцах, чавдараа нээн хөгжүүлэх зорилгоор

сард 2 удаа хийдэг. “Хошин асуултад хариулаад ном хож”, “Ном уншаач парт – 1” гэх мэт контентыг бэлтгэн “Оюуны мэлмий” номын клубын пэйж хуудсаараа дамжуулан уншигчдад хүргэж байна.

Хаврын номын баярын хүрээнд Номын сангаас зохион байгуулсан Булган сум руу аялах “Автобустай уншлага арга хэмжээнд клубын нийт гишүүд оролцсон. Булган сумын Соёлын төвөөс зохион байгуулсан түргэн хэллэг хэн сайн хэлэх вэ? тэмцээнд клубийн гишүүн Б. Ерөөлт – Од түрүүллээ, танин мэдэхүйн АХА тэмцээнд Б. Ерөөлт – Од 2 – р байр, замын турш автобусанд зохион байгуулсан танин мэдэхүйн тэмцээнд клубын гишүүн У. Энхжаргал тус тус тэргүүллээ.



Намрын номын баярын хүрээнд зохион байгуулсан “Автобустай уншлага” арга хэмжээ - Тариат сум руу. Уг арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан буухиа тэмцээний үеэр клубын гишүүн Г. Энхзул хамгийн сүүлд уншсан номоо ярьж өгөв. Тариат сумаас зохион байгуулсан “Миний Архангай” сэдэвт тэмцээнд клубийн







гишүүдээс бүрдсэн баг тэргүүн байранд шалгарлаа, “Аян замын тэмдэглэл” бичих уралдаанд клубийн гишүүн Ж. Намуундэлгэр тэргүүллээ. Замд зохион байгуулсан АХА тэмцээнд клубын гишүүд амжилттай оролцлоо.

“Соёлын бүтээлч сар – 2024” аяны хүрээнд зохион байгуулсан Хотонт, Хашаат сум, Хөшөө цайдам музей рүү аялсан “Автобустай уншлага” арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан “Аян замын тэмдэглэл” – ийн уралдаанд клубын гишүүн

Ж. Намуундэлгэр тэргүүн байр, клубын гишүүн Э. Дулмаа дэд байранд шалгарлаа. Замд автобусанд зохион байгуулсан арга хэмжээнд клубын гишүүн Л. Энхжин, Б. Гэрэлчимэг, Б. Ерөөлт – Од, Д. Уянга нар амжилттай оролцож шагнагдлаа.













“Соёлын бүтээлч сар – 2024” аяны хүрээнд зохион байгуулсан “Оюуны өртөө” танин мэдэхүйн тэмцээнд “ОЮУНЫ МЭЛМИЙ” номын клубын гишүүд 2 баг бүрдүүлж оролцсон ба дэд байр, 4 – р байрт шалгарлаа.

“Соёлын бүтээлч сар – 2024” аяны хүрээнд зохион байгуулсан Зохиолч уншигчдын уулзалтад клубын гишүүд оролцож СГЗ, зохиолч, сэтгүүлч Г. Жамцын Бүтээлийн дээжис 8 боть номыг уншиж асуулт боловсруулан асууж ярилцлаа.






Нийтийн номын сангаас зохион байгуулсан СОНА – д клубын гишүүд тогтмол





амжилттай оролцдог. Хаврын номын баяраар Б. Ерөөлт – Од “Тэргүүний уншигч Д. Нацагдорж” тэмдэгтэн шагналаар шагнагдлаа.

Намрын номын баяраар Д. Уянга, Л. Энхжин нар “Тэргүүний уншигч Д. Нацагдорж” тэмдэгтэн шагналаар шагнагдлаа.

2024.11.20 – нд "ДЭЛХИЙН ХҮҮХДИЙН ӨДӨР" - Оюуны Мэлмий номын клуб - ийн гишүүд хүүхдийн эрхийн талаар ярилцаж. Хүүхдийн эрхээс зөрчигдөж буй эрхүүдийг уншигчдад хүргэж, сургалтад хамрагдлаа. Дэлхийн Хүүхдийн Өдөр. Энэ өдөр НҮБ - ын Хүүхдийн эрхийн конвенц батлагдсан өдөр бөгөөд 2017 эхлэн

Дэлхийн Хүүхдийн Өдөр болгон тэмдэглэж байхаар НҮБ - ын Хүүхдийн Сангаас уриалсны дагуу дэлхийн 130 гаруй орон нэгджээ.
























“Оюуны мэлмий” номын клуб гэсэн пэйж хуудсаараа дамжуулан уншигчдад мэдээлэл хүргэж байна.

4.19 “Илүү их уншъя” уриатай “Үндэсний бичиг, соёл номын өдрүүд – 2024” арга хэмжээ буюу “Номын баяр” - ын хүрээнд Эрдэнэбулган сумын хүүхдийн 1, 2, 3, 4, 5, 6 - р цэцэрлэгийн ахлах бүлгийн 500 орчим хүүхдүүдэд "Үлгэрээс үлгэрлэе" уншлага хийлээ.





4.20 Ангийн уншлага хуваарийн дагуу явагдаж байна. Цэцэрлэгийн хүүхдүүд, бага ангийн сурагчдад зориулан тохижуулсан "Их мэдэх" танхим, байгаль орчинд ээлтэй "Эко" танхим, уншигчдын бүтээлийн үзэсгэлэнг танилцуулж, сонирхолтой, сургамжтай үлгэр, өгүүллэг уншиж өглөө.






4.21 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод “Алсын хараа - 2050”, Монгол Улсын Засгийн газрын 2020 - 2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны “Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл, арга хэмжээ батлах тухай” 314 дүгээр тогтоол, Соёлын тухай хууль, Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн ... дахь заалтыг тус тус үндэслэн “Соёлын бүтээлч сар - 2024” аяныг 11 - р сарын 01 - ээс 30 - ны хооронд зохион байгууллаа.

"Соёлын бүтээлч сар" аяны нээлт 2024.11.01 – нд "Миний Архангай" сэдэвт номын үзэсгэлэн, номын худалдаа, шатар, даам, шоо, дүрс эвлүүлэх тоглоом,

буддаг ном, дартс явуулж нийт 350 орчим иргэд, уншигч хамрагдаж шилдэгүүдэд шагнал, бэлэг дурсгалын зүйлээр урамшуулав.





4.22 "Түүхэн хүмүүнээс суралцахуй" уриатай Соёлын бүтээлч сар аяны 1 - р долоо хоног “Соёлын өв” сэдвийн хүрээнд "АВТОБУСТАЙ УНШЛАГА" арга хэмжээг дараах хөтөлбөрийн дагуу зохион байгууллаа.

Эрдэнэбулган сумын ЕБС - ийн 10 - 12 - р ангийн 20 сурагч, Нийтийн номын сангийн 3 номын санч Хотонт сум руу хөдөлсөн бөгөөд Хотонт сумаас 20 сурагч, Соёлын төвийн номын санч нэмэгдэж Хашаат сумын зүг хөдлөв.

Хашаат сумын Соёлын төв, номын сан, ОНСТ, сурагчидтай танилцаж, урлагийн тоглолт, Соёлын өв болон номын сангийн сургалтад хамрагдлаа.

Мөн хөгжөөнт буухиа тэмцээн, шүлгийн "open mic" хийж шилдэгүүд шалгарлаа.

Үдийн 1, 2 - р хоолондоо орсноор "Хөшөө цайдам музей" - г зорьлоо.

"Хөшөө цайдам музей" - гээс Хотонт сумын зүг хөдлөв. Замын турш "Миний Архангай" номыг уншиж асуулт хариултын тэмцээн зохион байгууллаа.

Хотонт сумын Соёлын төв, ОНСТ, номын сантай танилцаж "Аян замын тэмдэглэл" - ийн уралдаан зохион байгуулав.

1 - р байр: "Оюуны мэлмий" номын клубийн гишүүн, ЭБ сумын 2 - р сургуулийн 12в ангийн сурагч Ж. Намуундэлгэр,

2 - р байр: "Оюуны мэлмий" номын клубийн гишүүн, ЭБ сумын 1 - р сургуулийн 11д ангийн сурагч Э. Дулмаа,

3 - р байр: Хотонт сумын ЕБС - ийн 11б ангийн сурагч Б. Энхцацрал нар шалгарлаа.

Оройн тойргоо хийж, шагналаа гардуулан Хотонт сумаас Нийтийн номын сангийн зүг хөдлөв.










4.23 “Соёлын бүтээлч сар" аяны хүрээнд Эрдэнэбулган сумын ЕБ – ын 1, 2, 3, 4 – р сургуулийн 10, 11, 12 – р ангийн сурагчдын дунд мэдлэг, оюуныг сорьсон “Оюуны өртөө” тэмцээнийг амжилттай зохион байгууллаа. Уг



тэмцээнд:

I байр: ЭБ сумын 4 - р сургуулийн “Hard nuts” баг,

II байр: ЭБ сумын 2 - р сургуулийн “Super nova” баг,

III байр: ЭБ сумын 3 - р сургуулийн "Одод” баг тус тус шалгарлаа.






4.24 Дотоодын цэргийн 331 дүгээр тусгай салбарын албан хаагчид номын сангийн үйл ажиллагаатай танилцаж, зөөврийн номын сангийн гэрээ байгууллаа.





4.25 “Соёлын бүтээлч сар - 2024” аяны 3 дахь долоо хоног “Зохиолч уншигчдын уулзалт”. СГЗ, сэтгүүлч, зохиолч Г. Жамц гуайтай уулзалт зохион байгууллаа. Уулзалтад СГЗ сэтгүүлч, зохиолч С. Бараннасан, МУ - ын гавъяат багш М. Шагдарсүрэн, М. Нацаг - Юм, Ахмад багш Очирпүрэв, ЭБ сумын 1 - р сургуулийн МХУЗ - ын багш Ц. Цэрэнбалжид, Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын төлөөлөл, МУБИС - ийн харъяа Архангай аймаг дахь Багшийн сургуулийн МХУЗ - ын ангийн оюутнууд, ЕБС - ийн сурагчид оролцож уран бүтээлийн халуун дотно яриа өрнүүллээ. Нийтийн номын сангаас СГЗ, сэтгүүлч, зохиолч Г. Жамц гуайд хүндэтгэл үзүүлж дурсгалын зүйл гардууллаа.





4.26 “Соёлын бүтээлч сар” аяны хүрээнд Архангай аймгийн “Шагайн харвааны холбоо” - ноос улсын хошой мэргэн Б. Дашдондов, аймгийн гоц мэргэн Б. Базаррагчаа нар ЕБС - ийн ахлах ангийн сурагчдад шагайн харвааны сургалт







хийлээ. Шагайн харвааг хэн сайн сурсан бэ тэмцээнийг зохион байгуулж ЭБ сумын 4 - р сургуулийн 12а ангийн сурагч Н. Эрдэнэхүү шалгарлаа.

**ТАВ.** ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ

1. Электрон каталоги: Үүлэн технологид суурилсан коха программд 16989 нэр төрлийн 58000 ширхэг номын мэдээллийг оруулсан. 2024 оны жилийн эцсийн байдлаар шинээр ирсэн 71 номын мэдээллийг коха программд нэмж оруулсан ба 2828 номын дутуу мэдээллийг засаж шинэчлэн бар код нааж шинжлэх ухааны салбараар тавиурт байрлуулсан.

2. “Архангай - Нийтийн номын сан” пэйж хуудсанд үндсэн үйл ажиллагаа, СОНА – ын талаарх мэдээллийг тогтмол байршуулдаг. 2024 оны жилийн эцсийн байдлаар 109 удаагийн мэдээлэл байршуулж цахим орчинд давхардсан тоогоор 427000 хүнд хүргэсэн байна. Мөн “Номын сангийн тухай хууль”, байгууллагын үйл ажиллагааны танилцуулга зэргийг олон нийтэд хүртээмжтэй хүргэх зорилгоор хоолойн бичлэг, шторк, мэдээлэл, лайв, видео бичлэг бэлтгэн цахим орчинд нийтэлж, уншигчдад сурталчлан танилцуулж, мэдээлэл хүргэдэг.



3. 24 цагийн харуул хамгаалалт, галын дохиолол, гадна ба дотор хяналтын камер, хөдөлгөөн мэдрэгч бүхий дохиолол, гадна талбайн гэрэлтүүлэг зэргийг хийж аюулгүй байдлыг хангасан.

4. Нийтийн уншлагын танхим, хүүхдийн уншлагын танхимд соронзон долгионоор мэдрэгч дохиолол бүхий хамгаалалтын төхөөрөмж байрлуулж чөлөөт сонголтоор ном олгодог ба алдагдахаас сэргийлдэг.

**ЗУРГАА.** ТӨСӨВ, ОРЛОГО, ЗАРДАЛ:

2024 оны жилийн эцсийн байдлаар орон нутгийн төсвөөс 88,703,800 төгрөг, улсын төсвөөс 315,779,000 төгрөгөөр тус тус санхүүжиж тайлант хугацаанд батлагдсан төсвийн хүрээнд үр ашигтай зарцуулж өр авлагагүй ажилласан.

**ДОЛОО.** СУРГАЛТ, СЕМИНАР

- ✓ Аймгийн татварын хэлтсээс зохион байгуулсан “ХХОАТ – ын хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаар” хийсэн сургалт;
- ✓ Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсээс зохион байгуулсан сайтын шинэчлэлтийн талаарх сургалт, мэдээлэлд холбогдох албан тушаалтан цахимаар;
- ✓ Архивын ерөнхий газраас зохион байгуулсан “Баримт бичгийн стандарт” сэдэвт сургалт;
- ✓ E-mongolia нэгдсэн системд орон нутгийн номын сангуудын бүртгэл үүсгэх, үйлчилгээнд оруулах талаар санал, сургалт;
- ✓ Сумдын номын санчдыг чадавхжуулах сургалтыг 2024.03.20 - ны өдөр дараах агуулгын хүрээнд Нийтийн номын сангийн номын санчид, мэдээллийн ажилтан зохион байгууллаа: /“Номын сангийн фонд, түүний бүрдүүлэлт, зохион байгуулалт, хадгалалт хамгаалалт”; “Хүүхдийн уншлага - үйлчилгээний онцлог түүнийг дэмжих арга замууд”; “Номын сангаас зохион байгуулах СОНА - ын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага”; “Номын сангийн автоматжуулалт, цахим үйлчилгээний тухай ерөнхий ойлголт”;
- ✓ 2024.03.21 - нд СУГ - ын мэргэжилтэн Т. Хонгорзул “Статистик мэдээний анхаарах асуудлууд, MS - EXCEL программын хэрэглээ”;
- ✓ Төрийн албаны салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Ж. Эрдэнэтуяа “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай”;

- ✓ Насан туршийн суралцахуйн төвийн багш Б. Гүнчиншарав “Цахим хуудас хөтлөлт ба эрэлттэй программууд”;
- ✓ СУГ - ын архив, бичиг хэргийн эрхлэгч Д. Сарангэрэл “Архив, албан хэрэг хөтлөлт”;
- ✓ ТЕГ - ын Архангай аймаг дахь салбар Тагнуулийн хэлтсээс “Төрийн болон албаны нууц” сэдвүүдээр сумдын номын санч, ОНСТ - ын ажилчдыг чадавхжуулах сургалт;
- ✓ Архангай аймгийн Аудитын газраас төсвийн захирагч нарын дунд зохион байгуулсан сургалт;
- ✓ Төрийн албаны зөвлөлийн сургалт;
- ✓ Парламентийн судалгаа, сургалтын хүрээлэнгийн Ахлах зөвлөх Б. Үүрцайх, профессор Н. Наранчимэг, лектор, англи хэлний багш Э. Дөлгөөн нарын “Цахим засаглал ба онлайн соёл”, “Нийгмийн бодлого ба боловсролын хүртээмж”, “Орчин үеийн боловсрол ба англи хэлний үр нөлөө” зэрэг сэдэвт сургалт;
- ✓ “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэлхийн өдөр” – ийг угтан “Уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд эрүүл, аюулгүй хөдөлмөр эрхэлцгээе” уриан дор сарын аяны нээлтийн арга хэмжээ, сургалт;
- ✓ 2024.04.10 – ны өдөр Хүүхдийн төлөө зөвлөлийн гишүүн, ХЭҮК – ын ИЗН – ийн гишүүн, хүүхэд хүчирхийлэлийн эсрэг үндэсний хөдөлгөөний ерөнхий зохицуулагч, “Хүүхдийн эрх хамгаалал – Үжин төвийн үүсгэн байгуулагч, хүүхэд хамгаалал, хамтарсан багийн үндэсний сургагч, зөвлөх Д. Ундраагийн “Гэр бүл – Монгол соёлын анхдагч орчин” сэдэвт сургалт;
- ✓ Сонгуулийн ерөнхий хорооноос зохион байгуулсан цахим сургалтад хамрагдсан байна.
- ✓ 2024.07.01 – нд Монголын үндэсний номын сангийн арга зүйн хэлтэсээс Цахим номын сангийн сургалт зохион байгуулж хамт олноороо хамрагдлаа.
- ✓ МУ – ын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдах “Орон нутаг дахь үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын удирдах ажилтны зөвлөгөөн” – нд захирал О. Мөнхтуяа;

- ✓ Номын санч – мээдээллийн ажилтнуудын улсын 11 – р зөвлөгөөн буюу Library update – 2024 арга хэмжээ Улаанбаатар хотод 3 өдрийн сургалтад номын санч А. Ундармаа;
- ✓ Кибэр аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилт хэрхэн хангаж буй талаар сургалт, хэлэлцүүлэгт мэдээлэл технологийн ажилтан Э. Батбаяр;
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдрийг угтан зохион байгуулсан саргалт, үзлэг оношлогоонд байгууллагын ажилтан Г. Нарангэрэл нар тус тус хамрагдлаа.
- ✓ ОУ – ын ХБИ – ийн эрхийг хамгаалах өдрийн “Бидний оролцоо, бидний боломж – 2024” арга хэмжээ.
- ✓ СУАЖЗ газраас зохион байгуулсан санхүүгийн аудит, дотоод хяналт
- ✓ Татварын ерөнхий газраас зохион байгуулсан Татварын нэгдсэн систем
- ✓ Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан E close программын сургалтад тус тус хамрагдлаа.

## **НАЙМ.** БУСАД АЖИЛ:

1. Өдөр бүр хлораминтай усаар цэвэрлэгээний батлагдсан хуваарийн дагуу чийгтэй цэвэрлэгээ хийж, ажлын байрны ариун цэвэр, халдваргүйжүүлэлтийн дэглэмийг сахин ажиллаж байна.
2. Байгууллагын гадна талбайн хог хаягдлыг өдөр бүр цэвэрлэж, ажилтан, албан хаагч, уншигчдад тав тухтай, аюулгүй орчин бүрдүүлж ажилладаг.
3. Улирал бүр хүүхдийн номын ордон, нийтийн номын санд их цэвэрлэгээ хийдэг.
4. Бүх нийтийн хог цэвэрлэгээний ажлын хүрээнд манай байгууллага өөрийн эзэмшлийн талбай, зогсоол болон хуваарьт газраа 2024.04.19 - ний өдөр цэвэрлэж хогийн цэгт төвлөрүүллээ.





5. Байгууллагын гадна талбайд найман төрлийн цэцгийн үрсэлгээг суулгаж, төмөр хайсыг сэлбэн засаж, будсан.

6. "ТЭРБУМ МОД" үндэсний хөдөлгөөн. Бүх нийтээр мод тарих үндэсний өдрөөр манай хамт олон улиас тарьлаа. Тарьсан модоо услаж арчлан ургуулж байна.









7. Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт нь баримт бичгийн стандартын дагуу хийгддэг ба ЗД – ын захирамж, албан даалгавар, Гүйцэтгэлийн тайлан, Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн тайлан, Үйл ажиллагааны бичмэл тайлан, Өргөдөл гомдлын мэдээ тайлан, Зөөврийн номын сангийн тайлан, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайлан, Номын сангийн захирлын аймгийн аймгийн ЗД -тай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтийн тайлан, Шуурхай зөвлөгөөний тайлан, Сарын мэдээ гэх мэт тайлан, мэдээг сар, улирал, хагас, бүтэн жилээр хуулийн хугацаанд тайлагнадаг.

8. Шуурхай хуралдаан болон бусад сургалт, семинар, зөвлөгөөн, форумд тогтмол сууж хэвшсэн ба тэндээс гарсан шийдвэрийн биелэлтийг тухай бүрд стандартын дагуу гаргаж холбогдох газарт хүргүүлдэг.

9. Соёлын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Номын сангийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Шилэн дансны хууль, Соёлын өвийн тухай хууль, Төрийн албан хаагчийн Ёс зүйн тухай хууль, байгууллагын дотоод журам, номын сангийн үлгэрчилсэн дүрэм болон бусад холбогдох хууль, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж номын сангийн үйлчилгээг чирэгдэлгүйгээр чанартай, хүртээмжтэй, түргэн шуурхай, соёлтой хүргэж ажилладаг.

10. Төсвийн мэдээ тайлан болон өдөр тутмын үйл ажиллагааны мэдээллийг ил тод нээлттэй байлгах зорилгоор тогтмол гаргаж www. Shilendans.mn сайт, мэдээллийн самбар болон пэйж хуудсанд байршуулдаг.

11. Байгууллагын дотоод хяналт үнэлгээ хариуцсан ажилтан батлагдсан төлөвлөгөөний дагуу улирал тутамд хяналт тавьж ажилладаг.

12. Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 22 - ны өдрийн 258 дугаар тогтоолыг байгууллагын ажилтан бүр мөрдөж зөрчил дутагдалгүй ажиллалаа.

13. Нийтийн номын сангийн дэргэдэх “Оюуны мэлмий” номын клуб батлагдсан төлөвлөгөөний дагуу уулзалт, хэлэлцүүлэг хийж үйл ажиллагаагаа явуулж байна.

14. Нийтийн номын сангийн захирлын 2024 оны 02 дугаар сарын 28 – ны өдрийн А/01 тоот тушаалаар байгууллагын Ёс зүйн хороог 3 хүний бүрэлдэхүүнтэй томилон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавин, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллаж байна.

15. Соёлын сайдын 2023 оны 10 дугаар сарын 09 – ний өдрийн А/390 дугаар тушаалаар “Соёлын байгууллагуудын үр дүнд суурилсан санхүүжилтийн аргачлал” – ыг баталсан. Энэ аргачлалын дагуу 2023 оны Соёлын байгууллагуудын гүйцэтгэлийн үр дүнг үнэлснээс манай байгууллага орон нутгийн 21 номын сангаас 3 – р байрт үнэлэгдлээ.

16. Нийтийн уншлагын танхим болон хүүхдийн уншлагын танхимын суудлын бүрээсийг шинэчиллээ.





17. Хүүхдийн номын ордон, нийтийн номын сангийн өрөө, танхимуудад ариутгал хийгдлээ.





18. Эрдэнэбулган сумын ЗД - ын захирамжаар бүх нийтээр мод тарих өдрийг 2024.10.18, 19 - ний өдрүүдэд зохион байгуулж байна. Энэ өдрүүдэд манай байгууллага 18 ширхэг "Улиас" мод цагаан давааны постын ойролцоо тарьлаа.




19. Үр дүнд суурилсан санхүүжилтээрээ Захиралын өрөө, VIP өрөө, Их мэдэх танхим, Цайны өрөө, Эко танхим, Нягтлан бодогчийн өрөөнд тохижилт хийж ажилчдын сандал, ширээг шинэчилж ажиллах тав тухтай орчин бүрдүүллээ.







20. Нийтийн номын сангийн “Үзэсгэлэнгийн танхим” - д засвар хийж, өнгө үзэмжийг нэмэгдүүлж арга хэмжээ, үйл ажиллагаа зохион байгуулахад бэлэн болголоо.





---oOo---

## БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН Б. АХТАНЫ НЭРЭМЖИТ ТӨВ НОМЫН САНГИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

### 1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

### 1.1. ЭРХЭМ ЗОРИЛГО:

Номын сангийн уламжлалт үйлчилгээг орчин үеийн техник технологитой хослуулан цахим номын сангийн үйлчилгээг өргөжүүлэн, түүх соёлын үнэт өв, ном товхимолыг өсвөр хойч үедээ өвлүүлэн үлдээх, нийгэмд мэдээлэлд тулгуурласан мэдлэгтэй иргэнийг төлөвшүүлэх **“Мэдээллийн нээлттэй төв ”** болох.

### 1.2. НОМЫН САНГИЙН ТАЛААРХ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Тус номын сан 1949 онд байгуулагдсан. 2014 онд шинэ байранд орж, нэг ээлжинд 180 хүнийг хүлээн авч ном уншуулах чадвартай 5 уншлагын танхимтай. Насанд хүрэгчдийн танхим, Гэрээр ном олгох танхим, Хүүхдийн уншлагын 1-р танхим /1-3 анги, бяцхан уншигчдын/, Хүүхдийн уншлагын 2-р танхим /4-8 анги/, болон оройн номын сангийн танхимтай. Танхимууд бүгд чөлөөт сонголттой. Нийт 17 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна.

Цахим хаяг: Б.Ахтаны нэрэмжит Баян-Өлгий аймгийн төв номын сан
Бэв сайт: www.gov.mn/BULibrary
Өвлийн цагийн хуваарь: Даваа-Баасан гарагт, Өглөө 8:00-12:00, үдээс хойш 13:00-17:00 цаг, орой 17:00-21:00
Зуны цагийн хуваарь: Даваа-Баасан гарагт, Өглөө 9:00-12:00, Орой 13:00-18:00 цаг
Бямба гарагт: Өглөө 10:00-13:00
Байгууллагын утасны дугаар: 70422504, 95425353
Номын сангийн захирал Д.Алтынгүл

## 2. НОМЫН САНГИЙН САН ХӨМРӨГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТ

### 2.1. Номын сангийн сан хөмрөгийн бүрдүүлэлт, бүтэц зохион байгуулалт, боловсруулалт

2024 оны байдлаар худалдаагаар 224ш номыг 4528500 төгрөгөөр, хандиваар 275ш номыг 5561000 төгрөгөөр нийт 499ш номыг 10089500 төгрөгөөр авч электрон каталогт оруулсан. Бүрдүүлэлтээр авсан бүх номыг нэгдсэн болон нэгбүрчилсэн бүртгэлд авч, уншлагын танхимуудад хүлээлгэн өгч уншлаганд шилжүүлж, 8 төрлийн 871500 төгрөгийн тогтмол хэвлэл захиалан уншигчдад үйлчилж байна.










БНКУ-ын зохиолч Ж.Ержибекийн “Китап ал” номын клубтай хамтарч ажиллаж 1250000 төгрөгний 50ш номыг хандиваар авч фондоо баяжуулан уншигчдын хүртээл болгосон.



Уншигчдын эрэлт хэрэгцээг хангах, мөн орчин үеийн бестселлер бүтээлүүдийг цаг тухайд нь уншигчдад хүргэх зорилтын хүрээнд “INTERNOM” номын дэлгүүртэй хамтран ажиллах гэрээг шинэчлэн байгуулав.

Номын сангийн барилга, байгууламж нь гал, усны гэнэтийн аюул, хулгайн гэмт халдлгаас хамгаалах зориулалтын уншлагын танхимууд болон номын сангийн каридор, үүдний өөрөө, хувцасны өлгүүрийн өрөөнүүдэд 11ш, гадна талд 4ш телекамер нийт 15ш телекамер, 24ш дохиоллын хэрэгсэл бүрэн бүтэн ажиллаж байна.

2024 оны байдлаар ГНОТанхим-1028 Хүүхдийн 1-р танхим-56, Хүүхдийн 2-р танхим-94, Үндсэн фондын-98 нийт 350ш номыг сэлбэн засаж, номын аюулгүй байдал, хадгалалтыг сайжруулав.

Гэрээр олгогдсон номыг буцааж авахад ариутгаж авах зориулалт бүхийн 36 литрийн багтаамжтай ном ариутгагч төхөөрөмжөөр ариутгаж авч байна.

Гэрээр ном олгох танхим болон Хүүхдийн 1-р танхимын тооллогын комисс байгуулж, Фондын ном тоолсон тухай акт, ном хүлээлцсэн тухай акт, алдагдсан номын жагсаалт зэрэг материалуудыг үйлдэж, тооллогын дүнг гаргаж ажиллав.





## 3. УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭ

2024 онд Өлгий сумын ЕБС-ийн сурагчид болон цэцэрлэгийн хүүхдүүдийг номын санд хамруулах 5 өдрийн хуваарь, "Бяцхан уншигчдын танхим", "Оройн номын сан", "Гадны чөлөөт номын сан" "Зуны уншлага" "Зөөврийн номын сан" тогтмол ажиллуулан, 131 төрлийн соёлын олон талт ажил зохион байгуулж, 9031 ард иргэд, хүүхэд багачуудыг хамруулсанаар номын сангийн уншигчдын тоо жилээс жилд нэмэгдэж **13764** уншигчдад шинээр карт нээж, **32100** иргэсдэд нийт **57400** ном уншуулж, уншигчдын эрэлт хэрэгцээг хангаан үйлчилгээ үзүүлсэн.

| Танхимууд / Үзүүлэлт | Уншлагын танхим | ГНОТ | ХУТ-1 | ХУТ-2 | Зөөврөөр | Цахимаар | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|
| Уншигч | 2035 | 1850 | 3200 | 5429 | 1250 | | **13764** |
| Байнгын уншигч | 2655 | 2100 | 5800 | 6726 | 1520 | | **18801** |
| Иргэсэд | 5690 | 2500 | 8421 | 11985 | 1970 | 1534 | **32100** |
| Ном олголт | 14050 | 5050 | 15850 | 16920 | 4900 | 630 | **57400** |



## 3.1.“БЯЦХАН УНШИГЧДЫН ТАНХИМ”

Өлгий сумын нийт 15 цэцэрлэгийн бэлтгэл, дунд бүлгийн бяцхан уншигчид “Бяцхан уншигчдын танхим”-д ирж, ярьдаг ном /даналық әліппесі/, хөдөлгөөнт ном үзэж, номын санчийн уншиж өгсөн үлгэрээс ойлгосоноо хуваалцаж, дасгал хөдөлгөөн хийж, үлгэрийн баатарын дүрийг зурж, хэл яриагаа хөгжүүлсэн арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулдаг.









МУСГЗүтгэлтэн, доктор, профессор, зохиолч, сэтгүүлч Хавшийн Исламын нэрэмжит хүүхдийн 2-р танхимыг эко танхим болгож хүүхдүүдийг чөлөөтэй ном






унших орчин боломжийг бүрдүүлэн хувиарын дагуу нэг ээлжинд 40 гаруй хүүхдийг хамруулан үйлчилж байна.

### 3.2. ГАДНЫ НОМЫН САН "ЗУНЫ УНШЛАГА"

Зуны улиралд "ГАДНЫ ЧӨЛӨӨТ УНШЛАГА"-ыг байна ажиллууж, талбайг ногоон зүлэг болон гадна талын гэрэлтүүлэгтэй болгож тохижуулан ажлын цаг завсараа, болон оройн цагаар бяцхан уншигчдыг салхилуулан эцэг эх, асран хамгаалагч нар болон хүүхэд залуучуудад номын үзэсгэлэн гаргаж сурталчилан ном уншуулж, үйлчилгээ үзүүлэв.






Бүх нийтийн уншлагыг дэмжих, үндэсний бичиг соёлыг сурталчлах, хүүхэд багачууд, өсвөр үе, залуучуудын зуны амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор **"НОМЫН АЯЛАЛД ГАРЦГААЯ"** уриан дор **"ЗУНЫ УНШЛАГА"**-ын хөтөлбөрийг 2 дахь жилдээ амжилттай зохион байгуулсан. "ЗУНЫ УНШЛАГА" хөтөлбөрийн хүрээнд аймгийн төв номын сангийн хамт олон 2024 оны 07 дугаар сарын 26,28-ны 8-р сарын 02, 08 өдрүүдэд "Зост" хүүхдийн зусланд ажиллав.

Тус үйл ажиллагааны үеэр "Зост" хүүхдийн зусланд амралтаа өнгөрөөж буй хүүхэд багачуудад болон амрагч нарт шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн гаргаж, хүүхдүүдийн дунд уншсан номын тухай мэтгэлцээн, "Сэтгэ, бод" сэдэвт






хөгжөөнт тэмцээн болон “Байгаль ба ном” сэдэвт гар зургийн уралдаан зохион явуулав. Арга хэмжээнд 350 гаруй хүүхдүүд, багш, амрагчид оролцов.













### 3.3. ЗӨӨВРИЙН НОМЫН САНГААР ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛСЭН БАЙДАЛ.

Номын сангийн үйлчилгээг хүртэж чадахгүй байгаа алслагдсан сум, баг, байгууллагуудын ажилтан албан хаагчдад номын сангийн үйлчилгээг хүргэх, сурталчлах, хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор Булган, Бугат, Дэлүүн, Сагсай, Алтай, Алтанцөгц, Улаанхус, Ногооннуур, Баяннуур сум, 1-р ЕБС,, 4-р ЕБС, 5-р ЕБС, 2-р ЕБС, МСҮТ, Цагдагийн газар, Ус цаг уурын газар, Хыдыр ата-Нур ана мешит, Цэргийн 165р-340р анги, ШШГА, Прокурор, ШША, Шүүх, ОБГ, Татварын хэлтэс, Сагсай сумын “Зост” хүүхдийн амралтын газруудад зөөврийн номын сан ажиллуулах гэрээг шинэчлэн байгуулж нийт 1970 уншигчдад 4900 ном уншуулсан.









## 3.4. НОМЫН БУЛАН

Аймгийн ЗД-ын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.6.3.3 дээр тусгагдсан “Байгууллага болгон номын булантай болно” хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Бугат сумын “ИАС-Бугат холхабыс сан”-тай хамтран Бугат сумын төвд үйл ажиллагаа явуулдаг хөвгүүдийн дотуур байранд номын санчид өөрсдийн хандивлахаар бэлтгэсэн 110ш үлгэрийн болон уран зохиолын номуудаар номын булан байгуулан хүлээлгэж өглөө.








Аймгийн “Ахмадын хороо”-ны ахмадуудын хүсэтээр 150ш номоор номын булан байгуулав.





Номын сангийн ажилтан албан хаагч нарын хувийн хандиваар А.Ахжархын захиралтай "НУРЛЫ" эмнэлэгийн хамт олонд номын булан байгуулан 85ш номыг хүлээлгэж өгч ажиллаа.






## 3.5. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД ҮЗҮҮЛСЭН ҮЙЛЧИЛГЭЭ

Дэлхийн номын өдрийг тохиолдуулан Өлгий сумын 8, 13-р багийн иргэн аутизмтай хүүхдүүд Б.Ахжол, Н.Ерасыл, хөлний бэрхшээлтэй иргэн Х.Гүлжазира нарын гэрт нь очиж, ном болон гарын бэлэг гардуулан сэтгэлийн урам хайрлах зорилготой ажиллав.

Хүүхдийн баярын өдрөөр хөгжлийн бэрхшээлтэй 4 хүүхдийн гэрт нь очиж, гарын бэлэг гардуулах арга хэмжээ зохион байгуулж Өлгий сумын 12 багийн засаг даргатай хамтран ажиллав.

Номын сангийн үйлчилгээг хүүхэд багачуудад тэгш хүртээмжтэй хүргэх зорилгоор “Номтой нөхөрлөхүй” өдөрлөгийг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбооны БӨ аймаг дахь салбартай хамтарч үлгэрийн номын үзэсгэлэн, номын санчдын өөрсдийн бэлтгэсэн “ Баавгай ба шумуул ” нэртэй дүрийн тоглолт хийж, ярьдаг ном, хөдөлгөөнт ном, үзэгээр уншуулдаг номуудыг үзүүлж сонирхуулан, гарын бэлэг өгч урамшуулав.






### Цахимаар үзүүлсэн үйлчилгээ

Түүхт ойн баяр шинэ номын мэдээ, үзэсгэлэнг уншигдад видио бичлэгээр сурталчилав.”Үлгэрийн ертөнц”-ийн булан Fase хуудсыг тогтмол ажиллуулж,

үлгэрийн нийт 25 төрлийн үлгэр байршуулсанаар 7000 хүн үзэж, 480 лайк дарж, 110 комент бичсэн байна.







## 3.6. НОМЫН КЛУБ, НОМ СОНИРХОГЧДЫН УУЛЗАЛТ

Номын сангийн дэргэдэх 10 сурагчдын бүрэлдэхүүнтэй "Уншигчийн клуб"-ыг шинээр байгуулж , уншигчдын булан гарган, номын санд карт нээлгэж, унших номуудыг сонгон авч, зорилгоо тодорхойлон цаашдаа хийх үйл ажиллагааны талаар хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулав








**"БИЕ ДААЛТЫН 7 ХОНОГ"**

Боловсролын сайдын 2024 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн “Хичээлийн жилийн бүтэц шинэчлэн батлах тухай” А/01 дүгээр тушаалаар аймаг, сум, багийн болон нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн жилийн бүтцийг баталсан бөгөөд 2024-2025 оны хичээлийн жилийн бүтцэд I улирлын 9 дэх долоо хоног буюу X/28-XI/01 өдрүүдэд "Бие даалтын 7 хоног" байхаар тусгасан.
Хичээлийн жилийн бие даалтын 7 хоногт суралцагчдад бие даан суралцах, хувь хүний хөгжил, бүтээлч сэтгэлгээ, ур чадварыг хөгжүүлэх, бүх нийтийн уншлагыг дэмжих, номын өв санг арвижуулах, хүүхэд залууст ном эрдмийг түгээн дэлгэрүүлэхэд зорилгоор аймгийн төвийн ЕБС болон Алтай, Сагсай сумын ЕБС-ын сурагчид маань өргөнөөр ирж аймгийн төв номын сангаар танилцаж дараах үйлчилгээнүүдийг авч байна. Бие даалтын 7 хоногт нийт 3200 гаруй сурагчид хамрагдав. Үүнд :

- Ирсэн бүх сурагчид номын сангаар карт нээлгэх
- Номын сангаас зохион явуулдаг дугуйлангуудад хичээллэх
- Бага ангид өдөрт 1-2 цагийн танин мэдэхүйн тоглоом, үлгэрийн чанга уншлага, ярьдаг номоор үлгэр сонсох, нийтээрээ дасгал хөдөлгөөн хийлгэх
- 6-9-р анги буюу дунд ангийн сурагчдад 1-2 цагийн танин мэдэхүйн, сургалт зөвлөгөөн, ном уншихын ач тусын талаар лекц
- Ахлах ангийн сурагчдад “Номын мэтгэлцээн”, “Аха” зэрэг уралдаанд тэмцээнүүд явуулав.






Номын сангийн сангаас зохион байгуулах СОНА-ын жилийн төлөвлөгөөг боловсруулан ажилласанаар 2023 онд давхардсан тоогоор нийт 32 төрлийн 61 удаа СОНА зохион байгуулагдаж, 25 төрлийн шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнд

1173 ном дэлгэгдэж, 3359 ард иргэдийг соён гэгээрүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулсан.

| № | Зохион байгуулагдсан соёл олон нийтийн ажлын нэр | Оролцсон хүний тоо | Зохион байгуулсан газар | Зориулалт |
|---|---|---|---|---|
| 1 | “ЕРӨӨЛТЭЙ ЦАГААН САР” сэдэвт уралдаан /ЕБС-ийн дунд ангийн сурагчдын дунд/ | 150 | Уншлагын танхимд | Цагаан сарын баяр |
| 2 | “Цагаан сарын баярын онцлог, ёс заншил” сэдэвт уншигчдын уулзалт /Монгол Улсын гавьяат багш, зохиолч Ванчингийн Суранхүү / | 55 | Уншлагын танхимд | |
| 3 | “Номын санд нэг өдөр” /ЕБС-ийн бага ангийн сурагчдын дунд/ | 62 | Хүүхдийн 1-р тахимд | Эмэгтэйчүүдийн баяр |
| 4 | “Эхийн хайр” сэдэвт танхин мэдэхүйн уралдаан /6-р ЕБС-ийн 5”а” анги/ | 35 | Хүүхдийн 2-р танхимд | |
| 5 | Үндэсний өв, урлаг соёл “Жигит султаны-2024”, “Наурыз бике-2024” уралдаан | 85 | ХДТ-д | “Наурыз”-ын баяр |
| 6 | Абай Хунанбайн “Өлең сөздің патшасы, сөз сарасы” сэдэвт уран уншлагын уралдаан | 68 | Уншлагын танхимд | “Дэлхийн номын баяр-2024” |
| 7 | "ТА авч болно, өгч болно" булан | 120 | Номын санд | |
| 8 | “Сайхан бичигтэн” уралдаан /Өлгий сумын ЕБС-ийн сурагчдын дунд / | 25 | Уншлагын танхимд | Үндэсний бичиг үсгийн баяр-2024 |
| 9 | “Тэргүүний уншигч” уралдаан / аймгийн төрийн болон төрийн бус байгууллагуудын албан хаагчид/ / | 25 | ГНОТанхимд | |
| 10 | Бүтээлийн үзэсгэлэн / Өлгий сумын ЕБС-ийн дунд / | 350 | Уншлагын танхимд | |
| 11 | “Номын сангийн өртөөчилсэн аялал” /Цагдаагийн газар, Байгаль орчин, ШША/ | 320 | Номын санд | |
| 12 | АХА тэмцээн /ЕБС-ийн дунд ангийн сурагчдын дунд/ | 35 | Хүүхдийн 2-р танхимд | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 13 | “Үлгэр зохиолын баатаруудын дүр”-ийн тоглолт /цэцэрлэгийн багачуудын дунд/ | 530 | Өлгий сумын нийт 12 цэцэрлэгт | **“Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2024” /хавар, намар/** |
| 14 | “Аав ээжийн мэргэжил миний бахархал” сэдэвт зургийн уралдаан | 40 | Төв талбайд | |
| 15 | Номын клуб, ном сонирхогчдын уулзалт | 32 | Уншлагын танхимд | |
| 16 | “Номтой өглөө” /Төрийн албан хаагчдын дунд/ | 29 | Уншлагын танхимд | |
| 17 | Зохиолын баатаруудын дүрийн тоглолт, үлгэрийн баатаруудын парад | 350 | Төв талбайд | |
| 18 | Номын флошмоб /2 удаа/ | 40 | Төв талбайд, номын сангийн талбайд | |
| 19 | Зохиолч-уншигчдын уулзалт / Алтай академийн захирал, гадаад хэлний багш А.Берикбол | 33 | Уншлагын танимд | |
| 20 | “ЗУНЫ УНШЛАГА” / “Зост” хүүхдийн зуслан/ | 350 | “Зост” хүүхдийн амралтын газар | **“НОМЫН АЯЛАЛД ГАРЦГААЯ” аян** |
| 21 | ЕБС-ийн сурагчдын дунд шинэ номын үзэсгэлэн гаргаж, номын ач тусын талаар зөвлөмж, уулзалт | 260 | Номын санд | **“СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САР-2024”** |
| 22 | "Өв соёлоо хэн сайн мэдэх вэ?” сэдэвт "АХА” тэмцээн /340-р цэргийн анги/ | 135 | Цэргийн 340-р ангийн зааланд | |
| 23 | “Номтой нөхөрлөхгүй” /Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд номын сангийн үйлчилгээ/ | 13 | Уншлагын танхимд | |
| 24 | Зохиолч- уншигчдын уулзалт / Зохиолч, яруу найрагч, хуульч Тумысханы Костёр / | 45 | Уншлагын танхимд | |
| 25 | Монгол бахархалын өдрийг тохиолдуулан “МИНИЙ НУТАГ” сэдэвт зургийн уралдаан | 28 | Уншлагын танхимд | |
| 26 | “Ном хандивлах аян” | 123 | Хүүхдийн1-р танхимд | |
| 27 | Номын санд танилцах аялал Сагсай сумын ЕБС-ийн 6”а” ангийн сурагчид , 15-р цэцэрлэг/ | 65 | Уншлагын танхимд | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 28 | “Номын ач тус” сургалт | 560 | Уншлагын танхимд | **“Бие даалтын 7 хоног”** |
| 29 | АХА тэмцээн | 320 | | |
| 30 | Чанга уншлага | 640 | | |
| 31 | Орон нутгийн зохиолчдын болон хувь хүний номын нээлт /8 удаа/ | 525 | Уншлагын танхимд | |
| | **Нийт** | **5419** | | |

## СЭДЭВЧИЛСЭН НОМЫН ҮЗЭСГЭЛЭН

| Номын үзэсгэлэнгийн нэр | Үзэсгэлэнд дэлгэгдсэн номын тоо | Зориулалт |
|---|---|---|
| “ЕРӨӨЛТЭЙ ЦАГААН САР” | **25** | Цагаан сарын баяр |
| “Үзэсгэлэнт эмэгтэй” | 30 | Эмэгтэйчүүдийн баяр |
| Казахын ёс заншил | 36 | Наурызын баяр |
| Ховор ном | 20 | “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2024” /хавар, намар/ |
| Хүүхдийн ном | 40 | |
| Бабалар сөзи | 120 | |
| Сонин сэтгүүл | 15 | |
| Хамгийн том ба жижиг ном | 14 | |
| Шинэ ном | 70 | |
| Орон нутгийн зохиолчдын номын үзэсгэлэн | 55 | |
| Үндэсний бичгийн сурагчид болон багш нарын бүтээлийн үзэсгэлэн | 45 | |
| Хуучин номын үзэсгэлэн худалдаа | 120 | |
| Тэргүүний уншигч хүүхдийн бүтээлийн үзэсгэлэн | 47 | |
| Зохиолчдын гар бичмэлийн үзэсгэлэн | 12 | |
| Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үзэсгэлэн худалдаа | 15 | |
| Номын макет/ Жангар, Улаан малгайт, Ахтаны түүвэр зохиол/ | 4 | |
| Их зохиолч Абайн Хунанбаев | 45 | Их зохиолч Абайн Хунанбаев “Уран уншлага” уралдаан |
| Шинэ номын цахим үзэсгэлэн /6 удаа/ | 380 | Дэлхийн номын өдөр, хүүхдийн баяр |
| Эх сайхан монгол хэл | 55 | |

| | | |
|---|---|---|
| | | Бичиг үсгийн баяр |
| Багш, сурагчдын бүтээлийн үзэсгэлэн | 48 | |
| Хууль зүйн ном | 45 | Хууль сурталчлах өдөр |
| Орон нутгийн зохиолчдын номын үзэсгэлэн | 375 | Зохиолч-уншигчдын уулзалт, Уран уншлага, номын нээлт |
| “Дэлтэй монгол наадам” арга хэмжээнд “Монгол бахархал” сэдэвт ховор номын үзэсгэлэн | 180 | “Дэлтэй монгол наадам” арга хэмжээ |
| Монголын түүх Монгол бахархал | 55 | Монгол бахархалын өдөр |
| **Нийт** | **1806** | |

## ЦАГААН САРЫН БАЯР

Сар шинийн баярыг угтаж “ЕРӨӨЛТЭЙ ЦАГААН САР” сэдэвт уралдаан зохион явуулав. Уралдаанд аймгийн төвийн ЕБС-ийн дунд ангийн сурагчдаас бүрдсэн нийт 16 баг амжилттай оролцож, шилдэгүүдээ шалгарууллаа. Энэхүү арга хэмжээнд 150 гаруй сурагчид хамрагдав.






Мөн “Зохиолч, уншигчдын уулзалт” явуулж,  хүндэт зочноор Монгол Улсын гавьяат багш, зохиолч Ванчингийн Суранхүү багш оролцов.










## ОЛОН УЛСЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН БАЯР





“Олон Улсын Эмэгтэйчүүдийн Эрхийг Хамгаалах Өдөр”-ийг угтаж Бастама сургуулийн Б.Сайран багштай 2 “А”, Алпысбек багштай 2 «Б» ангийн хамт олны дунд “Номын санд нэг өдөр” арга хэмжээг зохион байгуулав.

Энэхүү арга хэмжээний хүрээнд бяцхан уншигчид маань эмэгтэйчүүддээ, эхчүүддээ зориулан зураг зурах, дуу дуулах, хөгжөөнт асуулт асуух, үлгэрийн чанга уншлага хийх, “Олон Улсын Эмэгтэйчүүдийн Эрхийг Хамгаалах Өдөр”-ийн талаар ойлголт өгөх зэрэг үйл ажиллагааг явуулав.

“Олон Улсын Эмэгтэйчүүдийн Эрхийг Хамгаалах Өдөр”-ийг угтаж “Эхийн хайр” сэдэвт танхин мэдэхүйн уралдааныг 6-р ЕБС-ийн Жадыра багштай 5”а” ангийн сурагчдын дунд 4 баг болж явуулав.











## ДЭЛХИЙН НОМЫН ӨДӨР

“Дэлхийн номын өдөр”-ийг тохиолдуулан соён гэгээрүүлэгч, яруу найрагч Абай Хунанбайн “Өлең сөздің патшасы, сөз сарасы” сэдэвт уран уншлагын уралдааныг аймгийн төв номын сангаас аймгийн хэмжээний ЕБС-ын сурагчдын дунд амжилттай зохион байгуулж уралдааны шилдгүүдээ шалгаруулав.Үүнд:

БАГА, ДУНД АНГИ
1-байр Жайнарбек Мунира Өлгий сумын Бастама ЕБС-ийн 7б ангийн сурагч
2-байр Серик Мария Өлгий сумын 3-р ЕБС-ийн 4в ангийн сурагч
3-байр Женисбек Аружан Баяннуур сумын 1-ЕБС 6в ангийн сурагч
Тусгай байр Берикжан Ахтоты Согог багийн ЕБС-ийн 7а ангийн сурагчид

АХЛАХ АНГИ
1-байр Мухамедбай Саулегүл Согог багийн ЕБС-ийн 11а ангийн сурагч
2-байр Солдатбек Нурали Дэлүүн сумын 1-р ЕБС-ийн 9а ангийн сурагч
3- байр Баймурат Ахтилек Согог багийн ЕБС-ийн 11а ангийн сурагч нар тус тус шалгарлаа.

Наурызын баярыг угтаж мартагдсан үндэсний өв, урлаг соёлоо хойч үедээ өвлүүлэн үлдээх, түгээн дэлгэрүүлэх зорилгоор аймгийн Засаг Даргын Тамгын газартай хамтарч “ЖИГИТ СУЛТАНЫ-2024”, “НАУРЫЗ БИКЕ-2024” уралдаануудыг амжилттай зохион байгуулж шилдэгүүдийг шалгаруулав. Уг уралдаанд сум, аймгийн төвөөс нийт 50 гаруй охид, хөвгүүд идэвхтэй оролцов.







## “ҮНДЭСНИЙ БИЧИГ ҮСГИЙН БАЯР- 2024”

Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар жил бүр уламжлал болгон зохион явагддаг “Үндэсний бичиг үсгийн баяр”-ыг угтаж Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх, үндэсний бичиг соёлоороо бахархах үзэл, ухамсарыг олон түмний оюун санаанд төлөвшүүлэх соёлын давтагдашгүй өв үндэсний монгол бичгийг

нийтэд эзэмшүүлэх, хэрэглэх орчин нөхцөлийг бий болгох, үндэсний хэл бичиг, ёс заншил, уламжлал, өвийг судлах, сурталчлах, өвлүүлэх зорилгоор аймгийн хэмжээний төрийн болон төрийн бус байгууллагуудын албан хаагчдын дунд "**Монгол бичгийн уран уншигч**" шалгаруулах уралдаан зохион байгуулав. Уг уралдааныг аймгийн Соёл, урлагийн газар, Баян-Өлгий аймгийн хэлний бодлогын салбар зөвлөлтэй хамтарч явуулав.

Багийн төрөлд
1-р байр Улсын Бүртгэлийн Хэлтсийн баг
2-р байр Өлгий сумын 4-р сургуулийн баг
3-р байр Өлгий сумын хүүхдийн 14-р цэцэрлэгийн баг
4-р байр Монгол Алтай Хадны Зургийн Цогцолборын Хамгаалалтын Захиргаа

Ганцаарчилсан төрөлд
1-р байр Өлгий сумын Лаборатори 2-р сургуулийн номын санч А.Саруул
2-р байр Баян-Өлгий аймаг дахь Гаалийн газрын Гаалийн улсын байцаагч А.Ариунбаяр нар тус тус шалгарав.





"Үндэсний бичиг соёл" сэдэвт бүтээлийн үзэсгэлэнгийн уралдаан зарлаж, эхний 3 байрыг шагнан урамшуулав. Энэхүү арга хэмжээнд үндэсний бичгийн ном, багш, сурагчдын 400 гаруй бүтээлийн үзэсгэлэн дэлгэгдэж 350 үзэгчид үзэж сонирхов.





ЕБС-ийн сурагчид болон номын сангийн ажилтан албан хаагчдад ЕБС-ийн 5 дугаар сургуулийн хэл уран зохиолын багш Х.Несибелтэй хамтран ажиллаж, Үндэсний бичгийн хичээлийн дугуйлан ажиллуулж, номын сангийн нийт 16 ажилтан албан хаагчид "Батламж" гардан авч ажиллаа.



## "ДЭЭЛТЭЙ МОНГОЛ" НААДАМ

Монголчуудын уламжлалт өв соёлын нэг болох үндэсний хувцас, түүний язгуур хэв шинж, угсаатны дээл хувцас эд хэрэглэл, соёлын биет бус өвийг сурталчлан таниулах зорилгоор "Дээлтэй Монгол" наадам арга хэмжээнд "Ховор номын үзэсгэлэн" гаргаж, номын сангийн хамт олноороо идэвхтэй оролцсон.






Үндэсний Их Баяр Наадамын нээлтийн үйл ажиллагаанд үндэсний хувцастай оролцсон.



## “ҮНДЭСНИЙ БИЧИГ СОЁЛ, НОМЫН ӨДРҮҮД-2024”

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль, “Алсын хараа-2050”, Монгол улсын урт хугацааны бодлого, Монгол улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлигийг хэрэгжүүлэх, бүх нийтийн уншлагыг дэмжих, номын сангийн өв санг арвижуулах, үндэсний бичиг соёлыг сурталчлах, хүүхэд залууст ном эрдмийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор **“Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2024”** 35,36 дахь удаагийн арга хэмжээг 2024 оны 5-р сарын 08 -17, 2024 оны 09-р 15-21 ны өдрүүдэд зохион байгуулан ажиллаа. Номын баярын 2 удаагийн арга хэмжээнд 15 төрлийн СОНА ажил зохион байгуулж, нийт 4800 гаруй уншигч, хүүхэд багачууд ард иргэд хамрагдав.

**“Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2024**” 35 дахь удаагийн арга хэмжээний нээлтийн үйл ажиллагаа

**“Номын баяр-2024”** 35 дахь удаагийн арга хэмжээний нээлтийн үйл ажиллагаа 05-р сарын 15 ны өдөр 10 цагт БНМАУ-ын баатар М.Икейн нэрэмжит төв талбайд тэмдэглэн өнгөрүүлэв. Нээлтийн үйл ажиллагаанд ЗДТГ-ын дарга Б.Мухамед, аймгийн Нийгмийн даатгалын газрын дарга М.Армия, Монголын зохиолчдын эвлэлийн Баян-Өлгий дахь салбарын захирал Б.Зархум, номын сангийн захирал Д.Алтынгүл нар мэндчилгээ дэвшүүлэв. Номын баяраар номонд дуртай, номыг шимтгэн уншдаг уншигч, бичигч иргэд, хүүхэд, багачууд, номын хорхойтнуудын дунд “Тэргүүний уншигч-Нацагдорж тэмдэгтэн”, Шилдэг “Гэр номын сан”, “Уншигч-зохиолчдын уулзалт”, “Үлгэрийн баатаруудын дүрийн” парад, “Үлгэрлээс үлгэрлэе” аян, “Номтой нөхөрлөе”, ном цуглуулья” аян, “Аав, ээжийн ажил миний бахархал” сэдэвт гар зургийн уралдаан, “Монгол бичиг өв соёл” сэдэвт үндэсний бичгийн бүтээлийн үзэсгэлэнгийн уралдаан, сэдэвчилсэн болон шинэ номын үзэсгэлэнгүүд г.м арга хэмжээнүүд зохион байгуулагдав. Үүнд:













**“Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2024”** 35 дахь хаврын арга хэмжээний үеэр

- Зохиолч-уншигчдын уулзалт
- “Номын өргөөний ид шид” номын сангийн танилцуулга

- “Үлгэрээс үлгэрлэе” аян /СӨБ –ийн хүүхдүүдийн дунд/
- Шилдэг “Гэр номын сан” шалгаруулах
- “Номтой нөхөрлөе, ном цуглуулья” аян
- Шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн
- Тэргүүний уншигч хүүхдүүдийн бүтээл, номын тэмдэглэлийн үзэсгэлэн
- Өлгийн зохиолчдын гар бичмэлийн үзэсгэлэн
- Ховор хуучин номын үзэсгэлэн, худалдаа
- Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үзэсгэлэн худалдаа
- “Аав, ээжийн ажил миний бахархал” сэдэвт гар зургийн уралдаан
- Өлгий сумын ЕБС-ийн сурагчдын дунд АХА тэмцээн
- Хүүхдийн үлгэрийн номноос “Чанга уншлага”
- Өлгий сумын ЕБ сургуулиудын “Монгол бичиг өв соёл” сэдэвт үндэсний бичгийн номын болон үндэсний бичгийн бүтээлийн үзэсгэлэн г.м арга хэмжээнүүд зохион байгуулагдав.

**ТЭРГҮҮНИЙ УНШИГЧ-НАЦАГДОРЖ ТЭМДЭГТЭНЭЭР**

1. 2-р ЕБС-ийн 4 “г” ангийн сурагч Жанкөк овогтой Айдана
2. 4-р ЕБС-ийн 12 “б” ангийн сурагч Володя овогтой Нуртолхын
3. Бастама сургуулийн 6 “а” ангийн сурагч Нурбек овогтой Бахадур




1. “Тэргүүний уншигч-Анги хамт олон”- оор 1-р ЕБС-ийн Я.Жанар багштай 6 ”б” анги хамт олон
2. “Тэргүүний уншигч-Анги хамт олон”-оор 6-р ЕБС-ийн Ж.Жадыра багштай 5 ”а” анги хамт олон
3. “Тэргүүний уншигч-Анги хамт олон”-оор Сагсай сумын ЕБС-ийн Б.Сара багштай 6 “б” ангийн хамт олон
4. “Тэргүүний уншигч-Анги хамт олон”- оор Бастама сургуулийн Б.Сайран багштай 2 ”а” анги хамт олон






## ЗОХИОЛЧ, УНШИГЧДЫН УУЛЗАЛТ

Аймаг орон нутгийн зохиолчид ба тэдний зохиолуудыг уншигчдад таниулах, уншигчдад зохиолчдын уран бүтээлээр бахархах сэтгэл төрүүлэх, бүх нийтийн уншлагыг дэмжих, номын сангийн өв санг арвижуулах, үндэсний бичиг соёлыг сурталчлах, хүүхэд залууст ном эрдмийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор “**Зохиолч, уншигчдын уулзалт”** зохион байгуулав.

Энэ удаагийн уулзалтыг Зохиолч, яруу найрагч, хуульч Тумысханы Костёр гуайтай хийж, дараах арга хэмжээнүүд зохион байгуулагдав.

- Зохиолч, яруу найрагч, хуульч Тумысханы Костёрын танилцуулга
- Зохиолч, яруу найрагчийн шүлэг, найраглалаас унших
- Яруу найрагчийн тухай сэтгэгдэл ярих
- Чөлөөт ярилцлага
- Баян-Өлгий аймгийн зохиолчдын уран бүтээлээс үзэсгэлэн гаргах,

Арга хэмжээнд нийт 40 гаруй аймгийн зохиолч, яруу найрагчид, ахмадууд, цагдаагийн газрын төлөөлөл, номын сангийн уншигчид оролцов.









## "НОМЫН ӨРГӨӨНИЙ ИД ШИД" АЯН

“Илүү их уншья” уриан доор зохион явагддаг 35 дахь удаагийн “Номын баяр-2024” хаврын арга хэмжээг тохиолдуулан номын сангаас бүх нийтийн уншлагыг дэмжих, номын сангийн өв санг арвижуулах, үндэсний бичиг соёлыг сурталчлах, бяцхан уншигчдыг номтой нөхөрлүүлэх зорилгоор "Номын өргөөний ид шид" аян зохион явуулж байна.

Энэхүү арга хэмжээнд  аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар  болон Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн Я.Жанар багштай 6 “Б” ангийн хамт, Сагсай сумын 1-р ЕБС-ийн Б.Сараа багштай 6 “а” ангийн хамт Буянт сумын Б.Сайрангүл багштай 6”а” анги хамт  олон оролцлоо.

Тус арга хэмжээний үеэр нийт оролцогчдод:

-Номын сангийн үйл ажиллагааг танилцуулах,

-Номын сангийн каталогийн хэрэглээний тухай ойлголт өгөх,

- Дэлхийн шилдэг уран зохиолын номуудаар үзэсгэлэн гаргаж танилцуулах






## “НОМТОЙ НӨХӨРЛӨЕ, НОМ ЦУГЛУУЛЬЯ” АЯН

“Номын баяр-2024” хаврын арга хэмжээг тохиолдуулан Баня-Өлгий аймгийн Б.Ахтаны нэрэмжит аймгийн төв номын сан болон Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар хамтран “НОМТОЙ НӨХӨРЛӨЕ, НОМ ЦУГЛУУЛЬЯ” аян зохион явуулав. Энэхүү аяны зорилго нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын албан хаагч, хоригдол, хоригдогсдын танин мэдэхүйн мэдлэгийг дээшлүүлэх чөлөөт цагаа үр бүтээлтэй өнгөрүүлэх, номтой нөхөрлүүлэх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын номын буланг ном хэвлэлээр баяжуулах.

Мөн алан хаагч нарын дунд “Арван таван наст капитан-2” номноос 1 сарын хугацаатай уралдаан зарлаж шилдгүүдээ шалгаруулав. Үүнд:

1-р байр Ээлжийн дарга, ахлах дэслэгч Х.Нургалым, 2-р байр шийдвэр гүйцэтгэгч, ахмад С.Ботакөз, 3-р байр Ээлжийн дарга, дэслэгч Ж. Еламан нар тус тус эзлэв.












## “ҮЛГЭРЭЭС ҮЛГЭРЛЭЕ” АЯН

“Номын баяр-2024” хаврын арга хэмжээг тохиолдуулан номын сангаас бүх нийтийн уншлагыг дэмжих, номын сангийн өв санг арвижуулах, үндэсний бичиг соёлыг сурталчлах, бяцхан уншигчдыг номтой нөхөрлүүлэх “Үлгэрээс үлгэрлэе” аян зохион явуулж байна.

“Үлгэрээс үлгэрлэе” аяны хүрээнд Өлгий сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг хүүхдийн цэцэрлэгүүд хуваарийн дагуу номын санд хүрэлцэн ирж, номын сантай танилцаж, үлгэрийн ид шидийн оронгоор аялж, үлгэрийн чанга уншлага хийх, бяцхан уншигчид маань өөрсдийн бэлдэж ирсэн урлагийн үзүүлбэрүүдээ үзүүлэх зэрэг ажлууд зохион явууллаа.











## ШИЛДЭГ “ГЭР НОМЫН САН “ ШАЛГАРУУЛАХ УРАЛДААН

Хүүхэд залуучууд, айл өрхийг номтой нөхөрлүүлэх хөдөлгөөн өрнүүлэх, номын баярын өдөр бүх нийтээр ном эрдмийг сурталчлах, номын өв санг арвижуулах, үндэсний бичиг соёлыг сурталчлах, ном эрдмийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор Шилдэг **“Гэр номын сан “** шалгаруулах уралдаан явуулав.






**“ҮЛГЭРИЙН БААТРУУДЫН ПАРАД”** уралдаан

Хүүхдүүдийг үлгэрийн баатаруудын дүрд хувирч жүжиглэн тоглох чадвартай болгох, үндэсний бичиг соёлыг сурталчлах, ном эрдмийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Үлгэрийн баатруудын парад”-ын уралдааныг аймгийн нийт ЕБС-ийн бага ангийн сурагчдын дунд зохион байгуулав. Уг уралдаанд аймгийн ЕБС бага ангийн 900 гаруй сурагчид идэвхтэй оролцов. Уралдаанд
1-байр Эмпати сургуулийн 2 “а” ангийн хамт олон
2-р байр 6-р сургууль 3 “б” ангийн хамт олон
2-р байр бастама сургуулийн 2 “б” ангийн хамт олон
3-р байр 9-р сургуулийн 3“а” ангийн хамт олон
3-р байр 2-р сургуулийн 3 “б” ангийн хамт олон
Тусгай байр 4-р суруулийн 3 “г” ангийн хамт олон тус тус эзлэв.














М.Икейн нэрэмжит төв талбайд зохион байгуулагдсан “Номын баяр-2024” арга хэмжээний үеэр Өлгий сумын ЕБС-ийн дунд ангийн сурагчдын дунд АХА танин мэдэхүйн тэмцээн зохион байгуулав. Арга хэмжээнд 40 агруй сурагчид оролцов.

1-р байр Бастама сургууль 5а анги А.Күнайым
2-р байр 2-р БДС 6б анги С.Сарангоо
3-р байр 3-р БДС 6а анги С.Айсымбат
Тусгай байр 3-р БДС 5а анги Ж.Али






**“ААВ ЭЭЖИЙН АЖИЛ МИНИЙ БАХАРХАЛ” СЭДЭВТ ГАР ЗУРГИЙН УРАЛДААН**

“Аав ээжийн ажил миний бахархал” сэдэвт гар зургийн уралдааны гол зорилго нь хүүхдүүд нь аав ээжийн ажлыг ойлгон хүндэтгэх, оролцогч өөрийн үзэл бодлоо чөлөөтэй уран зургийн олон янзын аргаар дуртай арга хэлбэр ашиглан, чөлөөтэй сэтгэн, уран дүрсэлж зурахад оршино. Уралдаанд нийт аймгийн ЕБС-ийн дунд ангийн 30 гаруй сурагчид оролцов.

1-р байр 3р ЕБС-ийн 9р сангийн сурагч А.Султан.

2р байр 5р ЕБС-ийн 8 р анги С.Жасмин.
3р байр 2 ЕБС-ийн 8 р сангийн сурагч Ж Билгүүнтөгөлдөр.
Тусгай байр 1р ЕБС-ийн 6 р ангийн сурагч Ж. Асылжан нар тус тус шалгарсан.







Өлгий сумын ЕБ сургуулиудын **“Монгол бичиг өв соёл”** сэдэвт үндэсний бичгийн номын болон үндэсний бичгийн бүтээлийн үзэсгэлэнийн уралдаан зохион байгуулав. Уралдаанд 1-р байр 2-р ЕБС, 2р байр 3-р ЕБС, 3р байр 1-р ЕБС, Тусгай байр 5-р ЕБС тус тус шалгарсан.










**“Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2024**” 36 дахь удаагийн арга хэмжээ

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль, “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлигийг хэрэгжүүлэх, бүх нийтийн уншлагыг дэмжих, номын сан өв санг арвижуулах, үндэсний бичиг соёлыг сурталчлах, хүүхэд залууст ном эрдмийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор "Үндэсний бичиг соёлоо эрхэмлэн дээдэлье" уриатайгаар 2024 оны 09-р сарын 17-23 өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлэв.
“НОМЫН БАЯР-2024” тохиолдуулан аймгийн төв номын сангаас дараах арга хэмжээнүүд зохион явуулав. Үүнд:

Академик, түүхч, зохиолч Аятханы Магыш /Магзум/-ын “Қыдыр қонған Пұшекең” нэртэй түүхэн романы нээлт боллоо.Нээлтийн үйл ажиллгаанд номын зохиогч ном бүтсэн түүх болон номынхоо тухай товч танилцуулж, ирсэн хүндэт зочдод номын дээжээ өгч, үйл ажиллагаанд номын сангийн хамт олон болон тус нутгаас төрөн гарсан алдартнууд, номын зохиогчийн гэр бүл найз нөхөд оролцож баяр хүргэж хүндэтгэл үзүүллээ.








“МИНИЙ НОМЫН ӨРГӨӨ” сэдэвт яруу найргийн уралдаан явуулав. Уг уралдаанд аймгийн хэмжээний ЕБС-аас дунд, ахлах ангийн 30 гаруй сурагчид оролцсон .

Үүнд:

1-р байр Хымбатын Харлыгаш Цэнгэл сумын 12-р ангийн сурагч
2-р байр Айдосын Нурмаганбет 3-р сургуулийн 10-р ангийн сурагч
3-р байр Нурболат Гүлдарига 1-р сургуулийн 7-р ангийн сурагч
Тусгай байр Көшегений Айбота 1-р сургуулийн 11-р ангийн сурагч
Тусгай байр Баяны Жулдыз 3-р сургуулийн 12-р ангийн сурагч нар тус тус байр эзлэв.









Өлгий сумын СӨБ-ийн бэлтгэл бүлгийн ангиудын дунд “ҮЛГЭРЧ АНГИ” уралдаан явуулж, нийт 18 цэцэрлэгийн 350 гаруй хүүхдүүд оролцож, эхний байр эзэлсэн хүүхдүүдийг шагнан урамшуулав.

1-р байр. 9-р цэцэрлэг бэлтгэл бүлэг У.Дина С.Нургүл багштай
2-р байр 1-р цэцэрлэг бэлтгэл бүлэг Х.Амангүл багштай
3-р байр 14-р цэцэрлэг бэлтгэл бүлэг Х.Айтолхын, Г.Мөнгөншагай багштай
Тусгай байр 24-р цэцэрлэг бэлтгэл бүлэг Х.Нургүл багштай








Тусгай байр 21-р цэцэцрлэг бэлтгэл бүлэг Ө.Нурсауле багштай
Тусгай байр 6-р цэцэрлэг бэлтгэл бүлэг Ш.Сабила багштай
Тусгай байр 3-р цэцэрлэг бэлтгэл бүлэг Ш.Алтынгүл багштай
Тусгай байр 12-р цэцэрлэг бэлтгэл бүлэг Т.Хуралай багш нар тус тус байр эзлэв.

Төрийн албан хаагч нарт зориулан “НОМТОЙ ӨГЛӨӨ” арга хэмжээ явуулав. Номын сангийн сан хөмрөгт байгаа бестселлер болон аймаг орон нутгийн зохиолчдын номын үзэсгэлэн гаргаж, номын сангийн талаар товч танилцуулга хийж, мэдээлэл хүргэв. Уншигчдад үнэ төлбөргүй карт нээж, гэрээр ном олгох үйлчилгээ, номын сангийн үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар судалгаа болон номын сангийн тухай асуулт, хариулт, чөлөөт ярилцлага зохион байгуулав.







## “ЗОХИОЛЧ, УНШИГЧДИЙН УУЛЗАЛТ”

Ахлах ангийн сурагчдыг ЭЕШ-ийн шалгалтанд бэлтгэх гадаадын их дээд сургуульд элсэн суралцуулах боломж олгох, үнэ төлбөргүй мэдээлэл зөвлөгөө өгөх, уншигчдад ном эрдмийг түгээн дэлгэрүүлэхэд зорилгоор зохион явагдаж буй уулзалтын зочиноор Алтай академийн захирал, гадаад хэлний багш А.Берикбол багш оролцлоо.

Энэхүү уулзалтаар багш маань хүүхдүүдэд “Гадаад хэл сурахийн ач тус болон гадаадад суралцах боломжууд”-ын талаар чөлөөт ярилцлага өрнүүлэн, TOFEL, IELTS шалгалтууд болон ямар түвшинд, ямар чиглэлээр суралцахаас












шалтгаалан ямар шалгалт өгөх ёстой, яаж бэлдэх талаар заавар, зөвлөмжүүд хүргэлээ.

## “НОМЫН БАЯР-2024 ” 36 дахь удаагийн  нээлтийн арга хэмжээ

Номын баярын нээлтийн үйл ажиллагаа 2024 оны 09-р сарын 22 нд номын сангийн гадна  талбайд зохион байгуулагдав. Нээлтийн арга хэмжээнд аймгийн СУГ-ын хэлтсийн дарга Ч.Өлзийтунгалаг,  номын сангийн захирал Д.Алтынгүл, ахмад багш, яруу найрагч А.Онай нар нээж, уралдаан тэмцээнд амжилттай оролцсон анги хамт олон болон “Тэргүүний  уншигч” -ын  шагналыг гардуулав.  Арга хэмжээний үеэр шинэ болон сэдэвчилсэн үзэсгэлэн, ховор номын үзэсгэлэн, орон нутгийн зохиолчдын номын үзэсгэлэн, хүүхдүүдийн гар зургийн бүтээлүүдийн үзэсгэлэн г.м 6 төрлийн үзэсгэлэнгүүд дэлгэгдэж, номын сангийн дэргэдэх “Номын флашмов” болон авьяаслаг хүүхдүүдийн урлагийн номерийг нийт 280 гаруй ахмад уншигчид, ЕБС-ийн багш, сурагчид, цэцэрлэгийн хүүхдүүд, ард иргэд үзэж сонирхов.











“Тэргүүний уншигч-Д.Нацагдорж тэмдэгтэн"-ээр Айдосын Хымбат
“Тэргүүний уншигч-Өндөр настан”-гаар Өлгий сумын өндөр настан Зейнолда Хонай
“Тэргүүний уншигч-Гэр бүл”-ээр Шалабайн Халаубайн гэр бүл тус тус шалгарлаа










**“ӨВ СОЁЛОО ДЭЭДЭЛЬЕ”** нээлттэй хаалганы өдөрлөгт Соёл Спорт Аялал Жуулчлал, Залуучуудын Яамны харьяа Монгол Алтай Хадны Зургийн Цогцолборын Хамгаалалтын Захиргааны Баян-Өлгий аймгийн Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын харьяа байгууллагууд болох аймгийн Хөгжимт драмын театр, Музей, Номын сан, 13 сумын Соёлын төвийн соёлын салбарын нийт 250 гаруй ажилтан албан хаагчид өөрийн салбарын үйл ажиллагаагаа сурталчлан танилцуулав.

Үүнд: Б.Ахтаны нэрэмжит төв номын сангаас төрөл бүрийн номын үзэсгэлэн гаргаж, зургийн уралдаан, үлгэрийн баатаруудын дүүрийн тоглолт, орон нутгийн зохиолчдын санамж өгөх ном зүйн бүртгэлүүдээс үзэсгэлэн зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж ажиллав.















## "СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САР" АЯН

"Соёлын бүтээлч сар" аяны хүрээнд Зэвсэгт хүчний 340 дүгээр ангитай хамтран үйл ажиллагаа зохион явуулав. Үүнд: 130 ширхэг Ховор ном, шинэ бестселлер, хамгийн том, хамгийн жижиг номын үзэсгэлэнгүүд дэлгэгдэж, уншигчдын хүсэлтийн дагуу зөөврөөр ном олгож ажиллав. Мөн үйл ажиллагааны төгсгөлд тус ангид хугацаат цэргийн алба хааж буй байлдагч нарт аймаг орон нутгийн зохиолчид ба тэдний зохиолуудыг таниулах, бүх нийтийн уншлагыг дэмжих, номын сангийн өв санг арвижуулах, үндэсний өв соёлыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор "Өв соёлоо хэн сайн мэдэх вэ?" сэдэвт "АХА" тэмцээн зохион явуулав.









Өлгий сумын ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад ирээдүйн мэргэжлээ зөв сонгох, уншигчдад ном эрдмийг түгээн дэлгэрүүлэх, зорилгоор “ИРЭЭДҮЙД ЭРЭЛТТЭЙ АЖИЛ, МЭРГЭЖИЛҮҮД” сэдэвт лекц, танилцуулга хийж, бүтээлч хэлэлцүүлэг болж өнгөрлөө. Хэлэлцүүлэгийн зочиноор “Эмпати” сургуулийн захирал А.Естай оролцлоо.






“Номын санд нэг өдөр” өдөрлөгийг төрийн албан хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх ном унших хөдөлгөөн өрнүүлэх зорилгоор Цагдаагийн газар, Байгаль орчны газрын албан хаагчдад номын сангийн уншлагын танхимууд, номын фонд болон номын сангийн үйл ажиллагааг танилцуулж, “Номын ач тусын тухай” чөлөөт ярилцлага явуулав.
















Цэнгэл сумын Соёлын төвийн зохион байгуулсан “Соёлын бүтээлч сар” аяны нээлтийн үйл ажиллагаанд аймгийн номын сангийн хүүхдийн 2-р танхимын номын санч нийт 250ш хүүхдийн номын үзэсгэлэнг сумын уншигчдад болон сургуулийн бага ангийн сурагчдад гаргаж, сурталчлан хамтран ажиллав.






Жюль Верний “Арван таван наст капитан” номноос "АХА" тэмцээнийг Өлгий сумын ЕБ-ын 5-р сургуулийн 9 ”в" ангийн сурагчдын дунд 4 багт хуваагдаж явуулав. Тэмцээнд идэвхтэй оролцсон багуудыг шагнан урамшуулав. Тэмцээнд нийт 32 сурагчид хамрагдав.










**“УТГА ЗОХИОЛЫН 7 ХОНОГ” аян**

**“УРАН УНШЛАГА”-ЫН УРАЛДААН**

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Монголын Зохиолчдын Эвлэлийн удирдах зөвлөлөөс 12 дугаар сарын 16-наас 12 дугаар сарын 23-ны хүртэл утга зохиолын 7 хоногийн аян зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Энэхүү арга хэмжээний хүрээнд дунд болон ахлах ангийн сурагчдын дунд уран уншлагын уралдаан аймгийн хэмжээнд зохион байгуулав. Аймгийн Соёл, Урлаг, Аялал Жуулчлал, Залуучуудын Газар, МЗЭ-ийн Баян-Өлгий аймаг дахь салбар зөвлөлтэй хамтран зохион явуулсан тус уралдаанд аймгийн болон сумуудаас нийт 66 оролцогч авьяас билэг, оюун ухаан, ур чадвараа гарган амжилттай оролцож шилдгүүдээ шалгаруулллаа.Үүнд:

1-р байр. Б.Ахтилек Улаанхус сумын, Согог багийн ЕБС-ийн 12-р ангийн сурагч,
2-р байр. М. Саулегүл Улаанхус сумын, Согог багийн ЕБС-ийн 12-р ангийн сурагч,
3-р байр. Ж.Мунира Өлгий сумын "БАСТАМА" ЕБС-ийн 8-р ангийн сурагч,
Тусгай байр. Ж. Фатиха Улаанхус сумын, Согог багийн ЕБС-ийн 9-р ангийн сурагч,
Тусгай байр. Х.Каусар Улаанхус сумын, Согог багийн ЕБС-ийн 9-р ангийн сурагч, нар тус тус шалгарлаа.
Мөн амжилттай оролцсон зарим сурагчдад МЗЭ-ийн Баян-Өлгий аймаг дахь салбарын тэргүүн, МУСГЗ Б.Зархум хувиасаа мөнгөн шагнал гардуулан баяр хүргэлээ.
Үүнд:
6-р байр. Шепен Инжу Сагсай сумын ЕБС-ийн 10-р ангийн сурагч,
7-р байр. Бекжаны Ахмарал Өлгий сумын, "ЗАЙД" ЕБС-ийн 12-р ангийн сурагч,
8-р байр. Көшегений Айбота Өлгий сумын ЕБ-ын 1-р сургуулийн 11-р ангийн сурагч












## ШИНЭ НОМЫН НЭЭЛТ

| № | Зохиогчийн нэр | Номын нэр |
|---|---|---|
| 1 | Зохиолч, эдийн засагч Х. Бекений | Талимгер |
| 2 | Биологийн шинжлэх ухааны доктор, профессор У.Бекетийн | “Алтай Таван Богдын Байгалийн “Цогцолборт газар“ |
| 3 | Академик, түүхч, зохиолч Аятханы Магыш /Магзум/ | “Қыдыр қонған Пұшекең” |
| 4 | Спортын дэд мастер С. Даурен | “Санлах споршылар” |
| 5 | Хуульч З. Шерханы | “Аулетиимиздин тарихы” |
| 6 | | Баян -Өлгий аймаг орон нутгийн ном зүй |









## ЛАВЛАГАА, НОМ ЗҮЙН АЖИЛ

- Мэдээлэл, ном зүйн үйлчилгээний хүрээнд тайлангийн хугацаанд уншигч үйлчлүүлэгч, иргэдэд «ӨГӨГДСӨН НОМ ЗҮЙН ЛАВЛАГАА»-г бичгээр, утсаар, амаар нийт 456 удаа лавлагаа өгсөн байна.
- Аймгийн нийтийн номын сан үүсэн байгуулагдсаны түүхт 75 жилийн ойг тохиолдуулан тус аймгаас төрөн гарсан зохиолч, яруу найрагч, сэтгүүлч, эрдэмтэн судлаачдын бүтээлийг **“БАЯН ӨЛГИЙ АЙМАГ – ОРОН НУТГИЙН НОМ ЗҮЙ”** ном







зүйн бүртгэлийг гаргасан. Соёлын яамны дэмжлэгээр бүтээсэн уг номд Баян Өлгий аймгийн уугуул 290 хүний 2790 гаруй зохиол, бүтээлийг хамруулсан. Эдгээрийн 2000 орчим нь Өлгийд, 600 гаруй нь Улаанбаатар хотод, 40 гаруй нь Казахстан Улсын Алматы хотод, 20 гаруй нь Астана хотод хэвлэгдсэн бүтээлүүд хамрагдсан.

- Соёлын яамнаас хэрэгжүүлж буй Номын сангийн нэгдсэн системийн сургалтаар ном зүйн «ZOTERO» программыг эзэмшиж, Үндэсний тогтмол хэвлэлийн өгүүллийн нэгдсэн санд бүртгүүлж, орон нутгаас гарах «Монгол Заман» болон, «Алтай news», «Жана өмир» сонинуудад хэвлэгдэн гарсан онцлог мэдээллүүдийг онлайн орчинд хадгалах ажлыг хийсэн.







- Монгол Улсын Гавьяат багш, зохиолч Ванчингийн Суранхүү багшийн «Санамж өгөх номзүйн» бүртгэл, Зохиолч, яруу найрагч, хуульч Тумысханы Костёрийн «Санамж өгөх номзүйн» бүртгэлийг шинэ номын мэдээнүүдийг гаргаж уншигчдын хүртээл болгосон.










- Номын сангаас зохион явуулж байгаа СОНА болон шинэ номын нээлтүүд мөн Номын баярын арга хэмжээнүүдийг ОНОНРадио, Орон нутгийн “Заман”, “Жаңа дәуір” сонинуудад мэдээ, мэдээлэл бэлтгэж ажилласан.



АЙМАҒЫМЫЗДЫҢ АҚЫН, ЖАЗУШЫЛАРЫНЫҢ ШЫҒАРМАШЫЛЫҚ ЕҢБЕКТЕР ТІЗІМІ ЖАРЫҚ КӨРДІ



Монгол ЗАМАН



ӘУЛЕТ ШЕЖІРЕСІ ӘРКІМГЕ ҚАЖЕТ...

- Шинээр бүрдүүлсэн 499ш ном хэвлэлийг LIB-4U программын цахим каталогт бүртгэн нийт 499 ширхэг карт шинээр бичиж, холбогдох каталогуудад байрлуулсан.
- Каталогийн лавлагааг уншигчдад өгч номын сангаар хэрхэн үйлчлүүлэх, каталог ашиглах, захиалгын хуудас бичих, номоо хэрхэн хайх, номоо хэрхэн сонгох талаар мэдээлэл өгч, зарим номын шифрийг тодруулах, олдохгүй байгаа зохиолуудыг электрон каталогоос хайлт хийж өгч байсан.
- “Төрийн мэдээлэл”, “Хууль зүйн мэдээ” сэтгүүлийг тогтмол авч лавлагааны фондоо баяжуулан ажиллаж байна.
- Ном зүйн картын санд шинээр “Зуны мэдээ” сониноос “Соёл гэгээрэл” сэдэвт 150ш, “Хууль зүйн” сэдэвт 60ш картын санг ном зүйн бичилтийн дагуу бичиж, каталогийн шүгээнд байрлуулав.

## 4. МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИ

- Байгууллагын дотоод сүлжээний тогтвортой байдлыг хангахын тулд өдөр тутмын мониторинг, засвар үйлчилгээ хийсэн.






- Серверийн хүчин чадлыг дээшдүүлэхийн тулд “ВОЛВЕС” ХХК-ны Улаанбаатар хот дахь салбарт хүсэлт гаргаж шинэчлэлт хийлгэсэн.
- Мэдээллийн баазын нөөцлөлтийг шинэчлэн хийж, КОХА программд шилжих ажилтай холбогдуулан мэдээллийн баазуудын нөөцлөлт (backup)-ийг МУҮН-гийн нэгдсэн сэрвэрт мэдээллийн баазыг өгч ажиллав.
- Сумдын соёлын төвийн номын сангуудын цахим програмын нэгдсэн тайлангийн мэдээ, нэгдсэн каталогийн мэдээ, Monbiblio цахим програмд оруулсан нэгдсэн тайлан, нэгдсэн каталогийн мэдээ, мэдээллийн сангийн нөөцийг бэлдэж, нийт 5 сумын номын сангийн Monbiblio цахим програмд ажиллах явцад гаргасан алдаа, дутагдалын талаар арга зүйн зөвлөгөө өгч ажиллав. Мөн Толбо, Алтанцөгц, Улаанхус сумын компьютеруудыг форматлаж, хэвийн үйл ажиллагаанд оруулсан.
- Алтанцөгц, Баяннуур, Улаан хус, Сагсай, Ногооннуур, Цагааннуур сумдын соёлын төвийн номын санчдын **OPENBIBLIO** программаас гарсан алдааг тухайн үед засаж өгч ажилласан.
- Номын сангийн бүх уншлагын танхимууд болон каридорд ном алдах эрсдэлээс хамгаалах зорилгоор камержуулалт, хянах дэлгэцийг тогтмол ажиллуулж байна. Камерийн бичлэг хийх төхөөрөмжүүд 7 хоногийн бичлэг хадгалагдан ажиллаж байна. Үүдэнд байрлуулсан соронзон хаалга нь хэвийн ажиллаж байна.
- Байгууллагын мэдээллийн ил тод байдал, иргэдийн мэдээлэл авах эрхийг хангах зорилгоор 2024 онд төлөвлөгөө батлуулан хэрэгжүүлж, Иргэдэд үйл ажиллагаагаа цахимаар хүргэх зорилгоор шинээр Бэв сайт: www.gov.mn/BULibrary нээлгэж, Б.Ахтаны нэрэмжит пейж хуудсыг тогтмол ажиллуулж, номын сангийн үйл ажиллагааны талаар нийт 115 удаа мэдээ, мэдээлэл тавьж сурталчилсан.
- “Дербес” TV, ОНОНРадиотой хамтран гэрээ байгуулж, үйл ажиллагаагаа сурталчлах зорилгоор 36 удаагийн мэдээ, мэдээлэл бэлтгэн олон нийтэд сурталчилсан.

## 5. АРГА ЗҮЙ, СУРГАЛТ

### 6.1. АРГА ЗҮЙ

- Өгөгдсөн арга зүйн бүртгэл хөтөлж төв номын сангийн номын санчид, хөдөө сумдын соёлын төвийн болон сургуулийн номын санчид, өлгий сумын сургуулийн номын санчид нийт 54 номын санчдад 85 удаа арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

- “Номын сангийн тухай хууль” зөвлөмж бэлтгэж, номын санчдын ажлыг дүгнэх аргачлалд нэмэлт өөрчлөлт оруулж, дахин боловсруулав.

- Номын санчдын ажлыг дүгнэх аргачлалын дагуу номын санчдын ажлыг улиралаар дүгнэн арга зүйн зөвлөлгөө өгч ажиллаж байна.





- Номын сангийн шинэчлэл, номын сангийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, номын санчдын мэдлэг, боловсрол, чадавхыг дээшлүүлэх, арга зүйн зөвлөгөө өгөх, зөвлөн туслах зортлгоор Алтай, Буянт, Сагсай, Улаанхус, Цэнгэл сумуудын номын сангуудад СУАЖЗГ-ын мэргэжилтэнүүдтэй хамтарч 10 хоног ажиллав.




- Аймгийн СУГ-тай хамтарч зохион байгуулсан “Номын санчдыг чадавхжуулах” сургалтанд сумдын соёлын төвийн нийт 11 номын санчыг хамруулан «Орон нутгийн ном зүй», “Фондын хадгалалт, хамгаалалт”, “Тайлан бичих арга зүй”, “Цахим номын сан” сэдэвт PPT бэлтгэж, 1 өдрийн цагийн хичээл зааж, чөлөөт ярилцлага зохион байгуулсан.



## 6.2. СУРГАЛТАНД ХАМРАГДСАН БАЙДАЛ

2024 онд Соёлын яам, ҮНС –аас зохион байгуулсан мэргэжлийн болон бусад төрийн болон төрийн бус байгууллагуудын нийт 18 төрлийн сургалтанд 35 удаа оролцож мэдлэг мэргэжлээ дээшлүүлэв. Үүнд:

Монгол Улсын Үндэсний Номын Сангийн шинэ барилгын 2024 оны 5 дугаар сарын 27-ны даваа гаригт зохион байгуулагдсан нээлтийн ёслолд Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх, УИХ, Засгийн газрын гишүүд, Соёлын сайд Ч.Номин, Монгол Улсын Үндэсний Номын Сангийн захирал Б.Ичинхорлоо, гадаад улс орнуудаас Монгол Улсад суугаа Элчин сайдууд, ШУА-ийн харьяа эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирлууд, эрдэмтэн мэргэд, зохиолч, уншигч, олон нийтийн төлөөлөл болон Б. Ахтааны нэрэмжит төв номын сангаас захирал ахлуулсан 8 хүний бүрэлдэхүүнтэй оролцов.












“Коха 22.11” буюу Номын сангийн нэгдсэн систем” сургалт

“Коха 22.11” буюу Номын сангийн нэгдсэн систем” сургалтын нээлтийн үйл ажиллагаанд Баян-Өлгий аймгийн Соёл, урлагийн газрын дарга К.Бекжан, Монгол Улсын Үндэсний Номын Сангийн ном зүйч Г.Баяртуяа, инженер М.Ариунболд, Б.Ахтаны нэрэмжит аймгийн төв номын сангийн захирал Д.Алтынгүл болон номын сангийн номын санч нар оролцлоо. Номын сангийн үйлчилгээг цахим хэлбэрт

шилжүүлж чанарт хүрээмжийг дээшлүүлэх зорилготой энэхүү “Коха 22.11” буюу Номын сангийн нэгдсэн системийн сургалт 2 өдөр үргэлжилж амжилттай зохионбайгуулагдав.












Номын сангийн ажилтан албан хаагчдад зориулан цахим орчны зүй зохистой хэрэглээ, орчин үеийн дэвшилтэт технологи, цахим систем, программ хангамжийг ашиглан Бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх кибер аюулгүй байдлын “Цахимд зөв байя” сургалтанд хамрагдсан.








Ховд аймгийн төвд зохион байгуулагдсан “Баруун бүсийн соёл-утга зохиолын 3-р чуулган” уулзалтанд МЗЭ салбар тэргүүн болон удирдлагагууд, номын сангийн захирал, мэдээллийн ажилтан оролцов.

Аймгийн Онцгой байдлын газраас Гамшгаас хамгаалах ангиллын сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд номын сангийн ажилчдад "Гамшгаас хамгаалах тухай болон Галын аюулгүй байдлын тухай” хууль, “Гал унтраах анхан шатны багаж, зэвсэглэмж”, "Анхны тусламж" сэдвээр сургалт зохион байгуулагдав.





“ДЭЛХИЙН ӨВ-МОНГОЛ АЛТАЙН ХАДНЫ ЗУРАГ-30" олон улсын эрдэм шинжилгээний хуралд номын сангийн ажилтан албан хаагч нар оролцов.





Монголын номын санчдын XV дахь удаагийн спортын их наадам спортын 5 төрлөөр Завхан аймгийн Улиастай хотод 2024 оны 08 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдав.
Энэхүү тэмцээнийг Завхан аймгийн Б.Явуухулангийн нэрэмжит аймгийн төв номын сан зохион байгуулан Улаанбаатар хотоос Монголын номын сангуудын консерциум, Батлан хамгаалах Их сургуулийн номын сан, Дотоод хэргийн Их сургуулийн номын сан болон аймаг орон нутгийн номын сангуудын номын санч, ажилтанууд оролцов.
Баян-Өлгий аймгийн Б.Ахтаны нэрэмжит төв номын сангийн баг тамирчид амжилттай оролцож, эмэгтэй сагсан бөмбөгийн баг хүрэл медаль хүртлээ.





Соёлын ажилтны өдрийг угтаж 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр аймгийн Соёл, урлаг аялал жуулчлал, залуучуудын газраас харьяа байгууллагууд болон Соёлын яамны харьяа Монгол Алтай Хадны Зургийн Цогцолборын Хамгаалалтын Захиргааны байгууллагын дунд биеийн тамирын арга хэмжээнд амжилттай оролцсон.




## 7. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ БОЛОВСРУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ, ДОТООД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭГ ОНОВЧТОЙ ХИЙХ

### 7.1. ДОТООД ХЯНАЛТ

- Дотоод хяналтын 2024 оны төлөвлөгөө боловсруулан хагас, бүтэн жилийн тайланг СУГ-ын соёлын хяналтын улсын байцаагчид хүргүүлэн ажиллаа. Мөн байгууллагад улиралд нэг удаа хийх дотоод хяналтын удирдамж боловсруулан, ажилтан албан хаагчдын өдөр тутмын ажилд хяналт тавьж, гарсан алдаа дутагдалыг хамт олны хуралаар танилцуулан тайлагнав.
- Байгууллагын дотоод хяналтыг сайжруулах зорилгоор Аймгийн СУГ-ын улсын байцаагчид хяналтын хуудасын дагуу 2 удаа шалгуулж, 2023 онд Аймгийн СУГ-ын улсын байцаагчийн хяналтын хуудасын дагуу 2 удаа

шалгуулж, нийт 64 үзүүлтээс 17 үзүүлэлт нь хангалтгүй ба **“Дунд”** эрсдэлтэй гэсэн үнэлгээ авч байсан. Дутагдалыг арилгах зорилгоор тус соёлын хяналтын улсын байцаагчаас ирсэн албан шаардлагын дагуу тусгай төлөвлөгөө гаргаж, захиргааны болон хамт олны хуралаар танилцуулж, нийт 17 дутагдлаас 8 төрлийн дутагдалыг арилгаж ажилласанаар 2024 оны 04-р сарын 17, 09-р сарын 15 ны өдрийн СУГ-ын улсын байцаагчийн номын сангийн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудасны дагуу шалгуулж **“Бага”** эрсдэлтэй гэсэн үнэлгээ авсан.





Монгол Улсын Засгийн газрын 2023 оны "Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай" 420 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Салбарын хяналт шалгалтын 2024 оны төлөвлөгөө”-ний 45 дахь хэсэгт "соёл, урлагийн байгууллагуудад хөдөлмөрийн харилцаа, аюулгүй байдал, нийгмийн хамгааллын асуудлаар урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх"-ээр тусгагдсан.

Энэ тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Соёлын яам болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Салбарын хяналтын газрын улсын ерөнхий байцаагч нарын хамтарсан "05-00-00-001/04, 13-07/13" дугаар удирдамжийг баталсан.
Тус удирдамжийн дагуу номын сангийн орчин нөхцөл, үйлчилгээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан таатай орчин бүрдүүлсэн эсэхэд болон соёл, хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, нийгмийн хамгааллын хяналтын чиглэлээр урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж,





эрсдлийн үнэлгээ гаргаж, гарсан зөрчил дутагдлыг арилгах чиглэлээр зөвлөгөө өгч ажиллав.

## 7.2. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ДОТООД АЖИЛ

- Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг ЗГ-ын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын дагуу боловсруулан аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэсийн даргад хянуулж ажилласан.
- Номын сангийн 2024 оны үйл ажиллагааны мэдээ, ажиллагсадын судалгааны мэдээ, тоног төхөөрөмжийн мэдээг хагас, бүтэн жилийн тайлангуудыг холбогдох газаруудад цаасан болон цахим хэлбэрээр цаг тухайд нь хүргүүлэн ажиллаа.
- Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хагас, бүтэн жилийн биелэлтийг аймгийн ЗДТГ-д хүргүүлэн 95.8 үнэлгээ авч ажилласан
- Аймгийн ЗД-ын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн хагас, жилийн биелэлтийг аймгийн ЗДТГ, СУГ-д тус-тус хүргүүлсэн.
- Соёлын сайдын аймгийн ЗД-тай хийсэн гэрээний хагас, бүтэн жилийн биелэлт
- Номын сангийн 2024 оны үйл ажиллагааны мэдээ /1,2,3,4 улиралаар/
- Үндэсний хөтөлбөрүүд, Дэлхийн номын өдөр, Үндэсний бичиг үсгийн баяр, “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2024” арга хэмжээний хаврын болон намрын төлөвлөгөө, хөтөлбөр тайлангуудыг СУГ-д тус-тус хүргүүлэн ажиллав.
- Аймгийн ЗД-ын 2024 оны 01-р сарын 04 өдрийн А/03 дугаар захирамж, СУГ-ын 2024 оны 01-р сарын 17 ны өдрийн №13 зөвлөмж, ЗДТГ-ын 2024 оны 01-р сарын 26 ны өдрийн албан тоот, ЗДТГ-ын 02-р сарын 09 ны өдрийн 3-02/141 албан тоот г,м нийт 19 төрлийн захирамж, албан даалгавар, албан тоот, зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллаж, холбогдох газруудад хугацаанд нь хүргүүлэв.
- Авилгалтай тэмцэх газраас ирсэн шалгалтын мөрөөр байгууллагын ажилтан албан хаагчдын хавтаст хэргийн бүрдүүлэлтэнд хяналт хийж, дутуу материалыг нь нөхөж, ирсэн шалгалтын комиссийн бүрэлдэхүүнд шалгуулав.
- Аймагт хяналтад авч буй хэрэгжүүлсэн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажилласан.
- Байгууллагын захиралын тушаал, албан бичиг бусад эрхийн актуудыг “Баримт бичгийн бүрдэл, түүнд тавигдах шаардлага MNS5140-2:2021 стандартыг хэрэгжүүлж, байгууллагад ирсэн нийт 60 төрлийн албан тоот, 19 явуулсан бичиг, 5 өргөдөл гомдол бүртгэснээс ирсэн зарим хариутай бичгийг судлан тушаал, удирдамж, төлөвлөгөө боловсруулан, өргөдөл гомдлын хариуг цаг тухайд хариу өгч ажилласан.

## 8. БУСАД

### 8.1. АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАСАН БАЙДАЛ

- Байгууллагын албан хаагчдын жилийн ажлын үр дүнгээр шалгаруулж, "Байгууллагын шилдэг" ажилтан, албан хаагчдыг тодруулан шагнан, урамшуулав. Мөн ажилтан, албан хаагчдаас бүтэн жилийн тайлан авч, ажлын гүйцэтгэлийн үр дүнгээр хангалттай буюу "А" үнэлгээгээр үнэлүүлсэн албан хаагч тус бүрт цалингийн 40%-иар, "В" үнэлгээ авсан албан хаагч тус бүрт 30% -ын урамшуулал олгосон.
- Байгууллагын албан хаагчдын ажлын байран дахь сэтгэл ханамжийг тодорхойлох зорилгоор 10 асуулт бүхий санал асуулгыг боловсруулж, 18 албан хаагчийг судалгаанд хамруулсан. Уг судалгааны дүнг хамт олны хурлаар танилцуулсан ба албан хаагчдын сэтгэл ханамж дунджаар 95 хувьтай байна. Нийт ажиллагсадыг жил бүр нормын хувцасаар хангаж, 3 ээлжийн хувцастай болгосон.

### 8.2 СОЁЛЫН БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛ

Номын сан нь аймгийн уншигчдын онцлог, уншигч зохиолчдын дугуй ширээний уулзалт, нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдэд, шинэ номын нээлтийн үйл ажиллагаа зэрэг ажлуудад тулгуурлан соёлын бүтээлч үйлдвэрлэлээ гаргаж сурталчилан ажиллаж байна.

Үүнд: Номын сангийн хаягтай, эшлэл үгтэй тэмдэглэлийн дэвтэр, уншсан номын тэмдэглэл, цаг тооны бичиг /календарь/, номын хавчуур , бал г.м

### 8.3. ОЛОН УЛСЫН АХМАДЫН БАЯР

- Эх орон, аймаг орон нутгийнхаа хөгжил дэвшил, хойч үеийнхээ сайн сайхны төлөө цуцалтгүй хөдөлмөрлөж, мэдлэг чадвар, халуун залуу насаа харамгүй зориулж ирсэн ахмадууд, азай буурлуудыг "Олон Улсын ахмадын баяр"~ыг тохиолдуулан хүлээн авч, номын сангийн онцлох үйл ажиллагаанууд болон цаашид хэрэгжүүлэх зарим арга хэмжээг танилцуулан хүндэтгэл үзүүллээ.




## 8.4. НОМЫН САНД ХИЙГДСЭН  ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Уншигчдад тав тухтай орчин бүрдүүлэх, номын сангийн орчин нөхцлийг сайжруулах зорилгоор байгууллагын дотоод нөөц бололцоогоор зарим албан өрөөнүүд болон 1 давхрын орох хэсгийн засварын ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд өнгө алдаж хуучирсан будагтай ханыг орчин үеийн хулсан хавтан /өнгөт хавтан/-аар өнгөлөх, шатсан асахгүй байгаа гэрлүүдийг нэг бүрчлэн сольж ажилласан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг: Монгол бичиг бол Монгол үндэстний оюуны соёлын үнэтэй бөгөөд бахархалт өв, монгол хэл, сэтгэлгээ, соёл иргэншлийн аюулгүй байдлыг хадгалан батжуулагч мөн гэж үзэж; Монгол Улсын иргэний үндэсний бичгээ сурч судлах, өвлөх, өвлүүлэх, эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх хуулиар олгогдсон эрх, боломж, нөхцөлийг хангах төрийн үүргийг биелүүлэх, Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх үүднээс; 2025 оноос төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллага албан бичгээ кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулах зарлиг гарсантай холбогдуулан байгууллагын дотор талын хаягыг хос бичгээр гаргаж шинэчлэн ажилласан.












Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар байгууллагын ариун цэврийн өрөөний засварын ажлыг “КӨШЕЛИК” ХХК 16,0 сая төгрөгөөр 2024 оны 10-р сарын 31-ний өдөр ажлаа эхэлж 11-р сарын 03-нд засварын ажлаа бүрэн гүйцэтгэж дууслаа.





## “ЗОХИОЛЧ БА УНШИГЧДЫН КЛУБ” танхимтай болсон

Уншигчдын унших дадлыг хөгжүүлэх, уран зохиолын мэдлэгийг нэмэгдүүлэх, шинэ зохиолчдыг дэмжих, ном унших соёлыг дэмжих, бүтээлээ хуваалцах боломжийг олгох, уншигч, зохиолчдын хооронд харилцан ярилцах орчин бүрдүүлэх зорилгоор байгууллагын дотоод нөөц боломжоогоор зохиолч ба уншигчдын клуб байгуулан тохижуулж ажилласан. Уг өрөөнд клубын зорилго, үйл ажиллагааны төлөвлөгөөг ярилцах, сар бүр тодорхой ном эсвэл зохиолыг уншиж, хэлэлцүүлэг өрнүүлэх, номын солилцоо, зохиолчдын гарын үсэгтэй номын худалдаа, илтгэлүүд зохион байгуулах, санал бодлоо хуваалцсах, алдартай болон шинээр гарч ирж буй зохиолчдыг урьж, туршлага солилцох арга хэмжээ зохион байгуулахад оршино.






## БҮХ НИЙТИЙН ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ ӨДӨР

"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, "Бүх нийтээр мод тарих өдөр"-ийн үйл ажиллагаанд Б.Ахтаны нэрэмжит аймгийн төв номын сангийн хамт олон нэгдэж хуваарьт талбайд бургас мод тарилаа.

Иргэн бүр "🌳"-оо тарья, услая, арчилъя, хамгаалъя.





“Хоггүй Өлгий” аяны хүрээнд байгууллагын хуваарьт газар болон байгууллагад хийх их цэвэрлэгээний календарчилсан төлөвлөгөө гаргаж, байгууллагын өрөө танхимууд болон гадны орчин, хуваарьт газрын (Хотгор явах хар зам дагуу) хог хаягдлыг цэвэрлэж, ажиллав.





Б.Ахтаны нэрэмжит төв номын сангийн 2024 онд хийсэн бүх нийтийн соёлын боловсролын хүрээнд хийгдсэн ажилд дүн шинжилгээ хийхэд:

Номын сангаас зохион байгуулагдсан “Дэлхийн номын өдөр-2024”, “Бичиг үсгийн баяр-2024”, “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2024” хавар, намрын арга хэмжээнүүд, “Номын сайн нөхөр”, “Зуны уншлага”, “Соёлын бүтээлч сар”, Зохиолч-уншигчдын уулзалт, “Уран уншлага” “Номын мэтгэлцээн”, “Соёлын өөртөөчилсөн аялал”, ЕБС-ийн бага ангийн сурагчид, Цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд “Үлгэрийн баатарын дүрийн тоглолт”, “Үлгэрч анги” г.м бүх нийтийн соёлын боловсролыг хөгжүүлэх соёлын олон талт үйл ажиллагааг танхим болон цахим орчинд зохион байгуулж, Өлгий сумын ЕБС-ийн сурагчид болон цэцэрлэгийн хүүхдүүдийг номын санд хамруулах 5 өдрийн график, сурагчдын “Бие даалтын 7 хоног” г.м арга хэмжээнүүдийг зохин байгуулж ажилласанаар номын сангийн уншигчдын тоо жилээс жилд нэмэгдэж, ард иргэдийг соён гэгээрүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулсан гэсэн дүгнэлтэнд хүрсэн.

# БАЯНХОНГОР АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

**Эрхэм зорилго.** Соёлын бодлогын хүрээнд шинэ ном хэвлэл мэдээллээр сан хөмрөгийг шинэчлэн баяжуулж, өнөөгийн нөхцөл, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн сургалт танин мэдэхүйн төв болон, хүн амын боловсрол, соёл, чөлөөт цагийн эрэлт хэрэгцээг хангахад чиглэсэн үйлчилгээг үзүүлэх.
**Номын сангийн товч танилцуулга.** Баянхонгор аймгийн Нийтийн номын сан нь 2024 онд 11 орон тоотой, Нийтийн уншлагын танхим, хүүхдийн уншлагын танхим, лавлагаа арга зүйн танхим, чөлөөт уншлагын танхим, гэрээр ном олгох тасаг, монгол, гадаад номын сан хөмрөг, тогтмол хэвлэлийн танхим гэсэн тасаг нэгжтэйгээр үйл ажиллагаа явуулж ирлээ.

**Нэг. Номын сангийн үйлчилгээ**

**1.1. Лавлагаа, ном зүй, арга зүйн ажил**

<u>Лавлагаа.</u> Уншигчдад лавлагаа өгөх ажлыг стандартын түвшинд зохион байгуулж, 148 уншигчдад аман лавлагаа, 36 уншигчдад бичгээр, 216 уншигчдад утсаар, нийт 400 лавлагааг өгөн, электрон болон цаасан каталогийг ашиглан, ном хайх заавар зөвлөгөөг 3083 уншигчдад өглөө. түр шилжүүлгээр 1414 уншигчдад үйлчилсэн.
Тогтмол хэвлэлийн "Zotero" программд "Өнөөгийн Баянхонгор" сонины 2024 оны 120 мэдээллийг шивж оруулан, Монголын үндэсний номын сангийн мэдээллийн санд илгээж, 10796 материалын сантай боллоо.
Уншигчдаас хэрэгцээтэй байгаа 23 номыг татгалзлаар бүртгэн, шинэ ном худалдан авах захиалгад оруулсан.
<u>Ном зүй:</u> Хэвлэмэл болон хэвлэмэл бус материалын санг баяжуулж, уншигчдад зориулсан "Өнөөгийн Баянхонгор" сонины 2008-2024 оны материалуудаар ном зүйн бүртгэл хийх бэлтгэл ажил хийгдэж байна. "Угийн бичиг хөтлөх үлгэрчилсэн загвар" санамж ном зүйн гарын авлага хийж Баянхонгор сумын 20 албан хаагчдад тараасан. Баянхонгор аймгийн сан хөмрөгийн "Бүртгэн мэдээлэх ном зүй", Ардын аман зохиол, уран зохиолоор сэдэвчилсэн ном зүйн бүртгэл, Номын санч нарт зориулсан санамж ном зүй, гарын авлага зэргийг хийсэн.
*<u>Арга зүйн ажил:</u>* Аймгийн төвийн ерөнхий боловсролын Номундалай, Номгон, Эрдэнмандал, Эрдэм, Соого Сейкео, Баян-Ойт, Алгоритм, Гэгээн сумади, 5-сургууль, Политехникийн коллеж, Хөдөө аж ахуйн их сургуулийн номын сангуудад, мөн орон нутгийн номын сангийн Lib4u программын ашиглалтыг сайжруулах, хяналт тавьх, арга зүйн зөвлөгөөг 19 сумын номын санчдад өгч ажилласан.

**1.2. Сан хөмрөгийн ажил, баяжилт, хадгалалт хамгаалалт**

Үндсэн фондоос ном, хэвлэлийг уншлагын танхимууд, гэрээр ном олгох тасгаар олгож, буцаан авч байрлуулан, шинэ номын мэдээг 4 удаа уншигчдад сурталчлан ажиллаа.
*<u>Фонд баяжилт</u>:*

| Ямар журмаар | Нэр төрөл | Тоо ширхэг | Үнийн дүн |
|---|---|---|---|
| Хандив | 179 | 204 | 4,914,700 |
| Худалдаа | 231 | 242 | 5,430,699 |
| Нийт | 410 | 446 | 10,345,399 |

Өдөр тутмын хэвлэл "Зууны мэдээ", "Өдрийн сонин", "Хүмүүн бичиг", "Утга зохиол урлаг", "Өнөөгийн Баянхонгор", "Баянхонгор таймс" сонин, "Төрийн мэдээлэл", "Улирал ба зохиолч" сэтгүүлийг 464,000 төгрөгөөр захиалан авч, нийт 69 уншигчдад үйлчиллээ.
Урагдаж, гэмтсэн 141 ширхэг номыг сэргээн засварлан, уншлагад гаргажээ.
Сан хөмрөгийн эргэлтийн судалгаагаар 28291 ном буюу фондын номын 57,2 хувийг уншигчид ашигласан байгаа нь өмнөх оноос 31 хувиар өссөн үзүүлэлттэй байна.
"Алдагдсан ном хэвлэлийг төлүүлэх журам"-г хэрэгжүүлэн Цойлогсод, Д.Норовын "Тэжээвэр", Л.Түдэвийн түүвэр зохиолыг номоор нь төлүүлэв.
Зөөврийн номын сангийн үйлчилгээг Зөөврийн номын сангийн гэрээг Бууцагаан, Галуут, Жаргалант, Заг, Гурванбулаг, Бөмбөгөр, Өлзийт, Баянбулаг, Баян-Өндөр, Баянлиг, Баян-Овоо зэрэг 11 сум, 3 байгууллагатай байгуулж, 21 удаа 547 ном олгож үйлчилжээ.
Номын үзэсгэлэн: Шинэ номын үзэсгэлэнг 8 удаа 256 номоор, сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 28 удаа 719 номоор тус тус үзэсгэлэн гаргаж, уншигчдад сурталчлан таниулсан.

**1.3. Уншлага үйлчилгээ.**

| Шинээр уншигч | Ирцээр уншигч | Ном олголт |
|---|---|---|
| 2645 | 13503 | 28242 |

**1.4. Уншигчдыг соён гэгээрүүлэх соёл, танин мэдэхүйн ажил.** 2024 онд уншигчдад зориулсан соёл танин мэдэхүйн 47 төрлийн ажлыг 94 удаагийн давтамжтайгаар зохион байгуулж, 18431 хүн хамрагджээ. Өмнөх онтой харьцуулбал, олон нийтэд чиглэсэн ажлын тоо 46 хувиар, хамрагдсан хүний тоо 100 хувиар өссөн үзүүлэлттэй байна.
Зарим ажлыг дурдвал:

**1."Монгол бичгийн хурдан уншлагын уралдаан"**-ыг байгууллагын дэргэдэх уран бичлэгийн дугуйлангийн багш Ч.Бямбадолгор санаачлан зохион байгуулж, Монгол бичгийн хурдан уншлагын уралдаанд сурагчид, сонирхогчид гэсэн ангиллаар 20 гаруй хүн оролцлоо. Энэ үеэр тус дугуйлангийн сурагчид үзэсгэлэн гаргаж, үндэсний бичиг соёлоо дээдлэгч С.Үнэнбуян, аймгийн Зохиолчдын холбооны гишүүд зэрэг 50 гаруй хүн хамрагдсан.
Сурагчдын ангилалд Номундалай сургуулийн сурагч Л.Номундарь 164 үг, сонирхогчдын ангилалд Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтэн Б.Батцэнгэл 173 үг уншиж тус тус тэргүүн байр эзэлж, дурсгалын зүйлээр шагнуулав.

**2."Номын тухай амттай яриа"** зохиолч уншигчдын уулзалтыг 3 удаа зохион байгуулж, Монголын Зохиолчдын эвлэлийн гишүүн, Г.Сэр-Одын нэрэмжит шагналт, 2013 оны "Хүрэн морь" яруу найргийн наадмын цомын эзэн, Монгол Улсын Соёлын тэргүүний ажилтан А.Батжаргал, Гандантэгчилэн хийдийн хамба лам Б.Баянжаргал, зохиолч Т.Мягмартогтох буюу Тодко Самсон нар уригдан оролцов. Шүлэг, яруу найраг сонирхогч хүүхэд, иргэд хүрэлцэн ирж, номын тухай халуун дотно яриа өрнүүлж, нийт 145 хүн оролцсон.

**3.**Сар шинийн баярыг угтан ЕБС-ийн сурагчдын дунд **"Ардын аман зохиолыг хэн сайн мэдэх вэ"** уралдааныг зохион байгууллаа. Багуудыг мэндчилгээ, хэлц үг, ертөнцийн гурав, оньсого, зурган хэлц тайлах, зүйр

үг, лан бодох гэсэн 7 төрлөөр уралдуулж, “Алаг шаазгай” баг тэргүүн байр, “Найрамдал” баг дэд байр, “Гарын таван хуруу” баг гутгаар байр эзлэн, өргөмжлөл дурсгалын зүйлээр тус тус шагнагдлаа. Уралдаанд 45 хүн оролцсон. Төсөвт 127,500 төгрөг зарцуусан.

**4.**Байгууллагын залуучуудын зөвлөлөөс санаачлан хамт олны дунд **“Эрүүл агаар эм”** өдөрлөг, тэмцээнийг зохион байгуулав. Багуудын дунд мэндчилгээ, мөс мөргөлдүүлэх, мөсөн сумо, чаргатай уралдаан, мөсөн дээрх олс таталт гэсэн 5 төрлийн тэмцээн явуулж, Г.Батдалай ахлагчтай баг тэргүүлж 50,000 төгрөгийн мөнгөн шагналаар шагнууллаа. Нийт 11 албан хаагч оролцсон.

**5.**Цагаан сарыг тохиолдуулан хамт олны дунд монгол үндэсний уламжлалт зан үйлийн ач холбогдлыг таниулах, эв эеийг эрхэмлэн, өв соёлоо дээдлэх, өвлүүлэн хөгжүүлэх зорилгоор **“Монгол ёс заншил”** уралдааныг байгууллагын залуучуудын зөвлөлтэй хамтран зохион байгуулсан. 11 ажилтан оролцов.

**6.**Уншигч хүүхдүүдэд ардын уламжлалт ёс заншил, мэндлэн хүндлэх, зочлох ёсны үг хэллэгийг ойлгуулах, зөв хандлагатай иргэн болгон төлөвшүүлэх зорилгоор Баян-Ойт, Соого сейкео, 5-р сургууль, Гэгээн сумади сургуулийн сурагчдад “Мэндлэх хүндлэх ёс”, “Монголчуудын уламжлалт ёс заншил” сэдвүүдээр Соого сейкео сургуулийн багш Н.Наранжаргал илтгэл тавьж, нийт 113 хүүхдүүд хамрагдлаа.

**7.**Иргэд, хүүхэд багачуудыг ном уншихад уриалан, хэл ярианы баялгийг хөгжүүлэх, хүнтэй харилцан ярих чадварыг нь дээшлүүлж, номоос өөрт хэрэгтэй мэдээллийг авч, дүгнэлт хийх чадвартай болгох зорилгоор Сурган хүмүүжүүлэх ухааны доктор, гавьяат багш Ш.Чимгээ “Амьдрал хурд уу, чиглэл үү” сэдвээр ЕБС-ийн номын санчид, нийгмийн ажилтан, багш, эцэг эхний төлөөллүүдийг оролцуулан номын хэлэлцүүлгийг зохион байгууллаа. 5 сургуулийн 26 төлөөлөл оролцсон.

**8.**Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг угтан **"Ээжтэйгээ хамтдаа"** өдөрлөгийг зохион байгууллаа. Өдөрлөгт хонгор нутагтаа ихийг хийж бүтээж яваа бизнесмэн, багш, өмгөөлөгч, оёдолчин, эмч, тогооч, сэтгүүлч, нийгмийн ажилтан зэрэг салбар салбарын төлөөлөл болсон эмэгтэйчүүд, охидын хамт оролцож, хүүхдээ номтой нөхөрлүүлэх арга туршлага, хүүхдийн хүмүүжил төлөвшил, монгол өв соёлоо дээдлэх талаар халуун дотно яриа өрнүүлж, ая дуугаа өргөлөө. Үйл ажиллагаанд оролцсон ээжүүдийг баярлуулах гарын бэлгээр ивээн тэтгэж Sondor home shop дэлгүүр Ц.Сарантуяа, Маникурч Г.Мөнхцэцэг, Ш.Сэдэд захиралтай "Мандал" фитнесс клуб, "Fohow-Тулга" салбар А.Гантулга, "Гоо хатан" үсчин гоо сайхны салоны үсчин Цэээхүү, "Брэйн повер" англи хэлний сургалтын төв Н.Алтанзул, "Энари" гоо сайхны дэлгүүр Т.Раднаабямба, "Шижир учиг" урлан Б.Батчимэг, "Эрдэнэс" дэлгүүр Б.Лхагвасүрэн нар хамтран ажиллаа. Бэлтгэл ажилд байгууллагаас **151,600** төгрөг зарцуулсан. Нийт 99 хүн хамрагдлаа.

**9.**Монгол Улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүссэний 103 жил, Монгол цэргийн өдрийг угтан **“Миний аав-Миний бахархал”** өдөрлөгийг зохион байгууллаа. Өдөрлөгт салбар салбарын төлөөлөл аавууд, хүүгийн хамт оролцож, амьдралын замнал, хүүхдийн хүмүүжил, уран бүтээлийнхээ талаар ярилцлаа. Үйл ажиллагааг ивээн тэтгэж, "Их Халбаганат" ХХК, "Содон" косметикс гоо сайхны дэлгүүр, GS фитнесс клуб, "Саятан" үсчин гоо сайхны салон, "Аморе" гоо сайхны дэлгүүр, "Шижир учиг" урлан, "Эрхэт" зоогийн газар, "Smyle" үсчин, "Дэвжих ундрам" машин

угаалгын газар, FOHOW MNU-03 төлөөлөгчийн "Титэм" дэх салбарын хамт олон хамтран ажиллаа. Нийт 53 хүн оролцов. Төсөвт байгууллагаас 59,000 төгрөг зарцуулла.
**10.** Дэлхийн яруу найргийн өдрийг тохиолдуулан зохион байгуулсан **“Урин цагийн анир”** яруу найргийн өдөрлөгт Баянхонгор аймгийн зохиолчдын холбооны тэргүүн, МУСТА Б.Жавзандулам, МЗЭ-ийн гишүүн МУСТА А.Батжаргал, МЗЭ-ийн гишүүн Баянхонгор аймгийн зохиолчдын холбооны удирдах зөвлөлийн дарга С.Мөнхтогтох, МУСТА, ган үзэгт, сэтгүүлч яруу найрагч Д.Батдамба, МУСТА дуучин Л.Жанцанхорол, МЗЭ-ийн шагналт зохиолч Д.Рагчаа, залуу дуучин Б.Банзрагч, яруу найрагч Ч.Бямбадолгор, Г.Дүүрэнбилэг, Ж.Дуламбазар, М.Санжнамжил, Х.Дамбажав, номын санч, багш нарын 50 орчим хүн оролцлоо. Энэ үеэр аймгийн зохиолчдын 23 номоор үзэсгэлэн гаргаж, урлагийн номер, чөлөөт ярилцлага, шинэ шүлгийн уншлага хийлээ.
**11.**Дэлхийн усны өдрийг угтан **“Ус ба энхтайван”** сэдэвт эсээ бичлэгийн уралдааныг ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд зохион байгуулж, нийт 4 сургуулийн 32 сурагчийн эсээ ирснээс Эрдэм сургуулийн 11в ангийн сурагч Б.Энхтуяа тэргүүн байр, Соого сейкео сургуулийн 12а ангийн сурагч Г.Гүрбазар дэд байр, Эрдэм сургуулийн 11б ангийн сурагч Ө.Ганцэцэг гутгаар байр, Соого сейкео сургуулийн 11в ангийн сурагч Т.Лхам-Янжин тусгай байр тус тус эзэлж өргөмжлөл мөнгөн шагналаар шагнагдсан. Төсөвт 100,000 төгрөг зарцуулав.
**12.**Их зохиолч Д.Нацагдоржийн нэрэмжит өсвөрийн яруу найрагчдын **“Хүрэл тулга-2024”** аймгийн уралдааныг  Баянхонгор аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газартай хамтран ерөнхий боловсролын сургуулийн VI-XII ангийн сурагчдын дунд зохион байгуулав. Уралдаанд Жаргалант, Баянлиг, Баацагаан, Баянцагаан, Галуут, Бууцагаан, Жинст, Баянхонгор сумын 40 гаруй өсвөр насны сурагчид өөрсдийн зохиосон шүлгээр оролцож, хоёр насны ангилал тус бүрийн тэргүүн байрт шалгарсан 2 сурагч “Хүрэл тулга-2024” улсын уралдаанд оролцох эрхтэй боллоо. 6-9 дүгээр ангийн ангилалд нэгдүгээр байрт Гэгээн сумади цогцолборын 7А ангийн сурагч Ч.Гандалай, хоёрдугаар байрт Баянцагаан сумын 6Б ангийн сурагч Я.Нанжид, гуравдугаар байрт 5-р сургуулийн 9А ангийн сурагч С.Энхмэнд, тусгай байрт Номундалай сургуулийн 9Г ангийн сурагч М.Цэлмүүн, Ахлах насны ангилалд нэгдүгээр байрт Баянцагаан сумын 12а ангийн сурагч Ш.Ганцоож, хоёрдугаар байрт Номгон ахлах сургуулийн 12-4-ийн сурагч Д.Даваасүрэн, гуравдугаар байрт Баянлиг сумын 12а ангийн сурагч Б.Азжаргал, тусгай байрт Гэгээн сумади сургууль цэцэрлэгийн цогцолборын 10а ангийн сурагч Ц.Батзаяа нар шалгарлаа. Тэмцээний шагналын санд таван хүүхдэд зусланд амрах эрхийн бичиг олгож, бусад зардалд 28800 төгрөг зарцуулсан.
**13.Үндэсний бичиг үсгийн баярыг** тохиолдуулан аймгийн Хэлний бодлогын салбар зөвлөлтэй хамтран “Босоо бичгийн гайхамшиг” хичээнгүй бичгийн уралдаан Уран бичлэгийг уралдаан, Монгол бичгийн тэргүүний уншигч уралдааныг тус тус зохион байгуулж, 1-4 байр шалгаруулан шагнаж урамшууллаа. Нийт 415 хүн оролцов.
**14.** “Үндэсний бичиг үсэг-Номын баяр”-ыг 5, 9 дүгээр саруудад зохион байгуулж, Улаанбаатар хотод зохиогдсон “Гэр” эвент үйл ажиллагаа, аймаг дахь “Гэр” эвент үйл ажиллагаа, “Миний дуртай үлгэрийн баатар” гар зургийн уралдаан, цэцэрлэгийн хүүхдүүдэд зориулан үлгэр унших “Чанга уншлага” ажиллагаа, танин мэдэхүйн АХА,

Алтан хонх, “50 номын хожил” уралдаан, “Үсэглэлийн хаад” уралдаан, уншигчдад зориулсан сургалт, номын үзэсгэлэн гэх мэт 9 төрлийн ажлыг 50 удаагийн давтамжтайгаар тус тус зохион байгуулж, нийт 12084 хүн хамрагджээ.

Номын баярын хүрээнд зохион байгуулагдсан ажлуудаас заримыг нь дурдвал, Монгол Улсын Соёлын Яам, Засгийн Газрын Хэрэгжүүлэгч Агентлаг Соёл, урлагийн газраас зохион байгуулж буй “Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл” өвийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор Баянхонгор аймгаас бэлтгэн очсон “Хос хүрэл” өргөөг улсын нийслэлийн төв талбайд барьж, өргөөг тохижуулах ажлыг Баянхонгор аймгийн Соёл, урлагийн газар, аймгийн Музей, Чингис хааны өв соёлын хүрээлэнгийн хамт олонтой хамтран зохион байгууллаа. Нийслэлийн ард иргэд, хүүхэд залуус, бүх насныханд зориулсан “Цагаан агуй”, “Хонгор нутгаа танин мэдье”, “Монгол гэрийн уяа зангилаа” хөтөлбөрүүдийг бэлтгэн танилцуулж, аймаг орон нутгаа сурталчлан, өдөртөө 700-800 хүнд 10 хоногийн хугацаанд давхардсан тоогоор 7500 гаруй хүнд боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэн мэдээ мэдээллийг хүргэж ажиллаа.

Аймгийн Хөдөө аж ахуйн их сургуулийн багш, оюутнууд, Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдад “Угийн бичиг”-ийн сургалтыг 2 удаа зохион байгуулж, 110 хүн хамрагдсан.

Бүх нийтийн уншлагыг дэмжих, номтой нөхөрлүүлэх, үлгэрийн дүрийн талаар ярилцаж сургах зорилогоор “Гурван тоорой”, “Маша баавгай 2”, Бонго, Можухын дүрээр “Чанга уншлага” үйл ажиллагааг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн төвд 1 удаа 38 хүүхдэд, Баян-Ойт, 3, 4, 5, 9, 10, 14, 15, 16 дугаар цэцэрлэгийн ахлах, бэлтгэл бүлгийн 700 орчим хүүхдэд хүргэж ажиллаа.

Уншигчдын дунд танин мэдэхүйн АХА, Алтан хонх, “50 номын хожил” тэмцээнийг 37 удаагийн давтамжтайгаар зохион байгуулж, 800 гаруй хүн хамрагдсан.

“Миний дуртай үлгэрийн баатар” гар зургийн уралдааныг Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газартай хамтран зохион байгуулж, 174 хүүхэд оролцож, 2 насны ангиллаар 8 хүүхдийг шалгаруулан, шагнаж урамшууллаа.

Монгол хэл, бичиг соёлоо зөв бичих, ярих, түгээн дэлгэрүүлэх, журамласан үгсийн тайлбар толийг судлах, эргэлзээтэй бичигддэг үгсийг нүдлүүлэх зорилготой “Үсэглэлийн хаад” тэмцээнийг ЕБС-ийн 7 сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд 3 үе шаттайгаар зохион байгууллаа. Тэмцээнд 55 сурагч оролцов.

**15.** Зуны амралтаар нь хүүхдүүдийг номтой нөхөрлүүлэх зорилготой **“Номтой зун”** үйл ажиллагааг Өвгөнжаргалант хүүхдийн зуслан дээр зохион байгуулж, 11-12 дугаар ангийн амрагч хүүхдүүдийн дунд “Номын сангийн хөгжлийн чиг хандлага, Номын санч мэргэжил” сэдвээр хэлэлцүүлэг, 6-9 дүгээр ангийн амрагч хүүхдүүдэд “Номын өргөөний ид шид” лекц, 2-5 дугаар ангийн амрагч хүүхдүүдэд “Номтой нөхөрлөх аргууд” сургалт, гэх мэт нийт 4 бүлгийн 209 амрагчдын дунд танин мэдэхүйн АХА, Алтан хонх, хөгжөөнт буухиа тэмцээнүүдийг тус тус зохион байгууллаа.

**16.**Ламын гэгээний 385 жилийн ойн даншиг наадам 2024 оны 07 дугаар сарын 26-28-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, аймгийн Музейн танхимд наадамчин олонд зориулсан номын үзэсгэлэн, ардын оньсон тоглоом, шагайн наадгай, “Цагаан агуй”-н талаар танилцуулах зэргээр ажиллаа.

**17.**Соёлын биет бус өвийг сурталчлан таниулж, түгээн дэлгэрүүлэх, үр, хойч үедээ өвлүүлэн үлдээх зорилготой “Нүүдэлчин” соёлын фестиваль Улаанбаатар хотын

“Тэрэлж” амралтад 8 дугаар сарын 16-18-ны өдрүүдэд зохион байгуулагдав. Манай байгууллагын зүгээс ард иргэдэд зориулан түүхэн дурсгалт газар болох 750 мянган жилийн өмнө хүмүүс амьдарч байсныг гэрчлэх ул мөрүүд үлдсэн байдаг Баянлиг сум дахь “Цагаан агуй”, Байнхонгор аймгийн сумдын танилцуулга бүхий “Хонгор нутгаа танин мэдье”, Төрийн соёрхолт зохиолч, яруу найрагч, Чойжилжавын Лхамсүрэнгийн нэрэмжит "Хүрэн морь" яруу найргийн наадам сэдвээр гурван боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэн таниулж 3194 хүүхэд, 2438 том, Гадаадын иргэн 421 нийт 6053 хүнд сурталчлан ажиллалаа.

**18.** “Соёлын бүтээлч сар” аяны хүрээнд “Монгол ёс заншил” өдөрлөг, Чила лекторын зохион байгуулсан Эерэг” лекц, яруу найрагч Т.Батжаргалын “Үзүүргүй цэнхэр говь” номын нээлт, сэтгэл зүйн лекц, “Цагаан агуйн ид шид” номын танилцуулга, хамт олноороо Үндэсний номын сантай танилцах туршлага судлах, “Хүрэн морь” яруу найргийн наадам, “Өсвөрийн яруу найрагч бид” яруу найргийн уралдаан, “Нийтийн соёлд суралцахуй” сэдэвт сургалт, “Бидний мэдэх найраглал” уран уншлагын уралдаан, номын санчдын дунд ажил мэргэжлийн уралдаан зарлах, “50 номын хожил” уралдаан гэх мэт 12 төрлийн ажлыг иргэд, уншигчдад зориулан зохион байгууллаа.

**“Хүрэн морь-2024”** яруу найргийн наадмыг Улаанбаатар хотод Үндэсний номын санд зохион байгуулж, нийт 99 найрагч оролцлоо. Тус 34 дэх удаагийн наадамд Баянхонгор аймгийн уугуул, залуу яруу найрагч Б.Лувсанпэрэнлэй тэргүүн байрыг эзэлж “Хүрэн морь” цом, 500,000 төгрөгөөр шагнуулав. Дэд байрт Г.Лхагвадорж 500,000, гутгаар байрт Т.Батхүрэл, дөтгөөр байрт Б.Мөнхзул, тавдугаар байрт Д.Энхжаргал нар тус тус шалгарлаа.

Наадмын шүүгчээр Монголын Зохиолчдын эвлэлийн гишүүн, судлаач шүүмжлэгч Б.Батсуурь, “Болор цом” наадмын эзэн Б.Жамбалдорж, утга зохиол судлаач Х.Чойдогжамц, хөтлөгчөөр “Болор цом”-н эзэн, яруу найрагч, сэтгүүлж Н.Гантулга ажиллаа. Наадмын үеэр 2024 онд шинэ номоо хэвлүүлж гаргасан зохиолч, яруу найрагчдын номын нээлт, ахмад номын санч Б.Байгалмаагийн фото зургийн үзэсгэсэн, “Хүрэн морь” сийлбэр цомын 10 жилийн ойд зориулсан үзэсгэлэн зэрэг олон үйл ажиллагаа зохион байгуулагдаж, нийт 130 гаруй хүн оролцлоо. Сийлбэр цом, шагналын зардлын 3,500,000 төгрөгийг аймгийн Засаг даргын ивээн тэтгэлгээр бүрдүүлсэн.

Шинэ үеийн яруу найрагчдыг дэмжих зорилготой **“Өсвөрийн яруу найрагчид** бид”-2024 яруу найргийн уралдааныг 12 дахь жилдээ зохион байгуулж, 2 насны ангилалд нийт 28 сурагч оролцлоо. Ахлах ангийн төрөлд тэргүүн байр, “Шилжин явах цом”-ыг Номундалай сургуулийн 12Б ангийн сурагч У.Мөнх-Очир, дунд ангийн төрөлд тэргүүн байр “Шилжин явах цом”-ыг Номундалай сургуулийн 9в ангийн сурагч Б.Лхагвадулам нар тус тус хүртлээ.

Монголын шилдэг найраглалуудыг хүүхэд залууст таниулах, уран унших чадвар, авьяасыг хөгжүүлэх зорилготой **“Бидний унших дуртай найраглал**” уран уншлагын уралдааныг зохион байгуулж, нийт 15 сурагч оролцлоо. Тэргүүн байрт Баянцагаан сумын ЕБС-ийн 10а ангийн сурагч Э.Шүрэнчимэг шалгарлаа.

Жилийн эцсийн байдлаар зохион байгуулсан сургалт, соёл, олон нийтийн ажлуудыг хүснэгтээр харуулбал:

| № | Соёл, олон нийтийн ажлын нэр | Зохион байгуулсан огноо | Хамрагдсан хүний тоо | Байгууллага-аас зарцуулсан төсөв | Хамтарч ажилласан байгууллагаас ивээн тэтгэсэн төсөв |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 1 | “Сэтгэлийн боловсрол” уншигчдад зориулсан лекц /Ш.Чимгээ багш/ | I/19 | 109 | 40,000 | - |
| 2 | “Эцэг эхийн ёс суртахуун сургалт /Насан туршийн суралцахуйн төв/ | II/25 | 25 | - | - |
| 3 | “Сурагчийн ёс зүй” сургалт /Насан туршийн суралцахуйн төв/ | II/20 | 62 | - | - |
| 4 | “Амьдрал хурд уу, чиглэл үү” лекц /Ш.Чимгээ багш/ | III/04 | 26 | - | - |
| 5 | “Монгол бичгийн хурдан уншлагын уралдаан” | I/26 | 88 | 150,000 | - |
| 6 | “Номын тухай амттай яриа” зохиолч уншигчдын уулзалт /2 удаа/ | II/01, V/21 | 75 | 60,000 | 390,000 |
| 7 | Ардын аман зохиолыг хэн сайн мэдэх вэ” уралдаан | II/02 | 45 | 127,500 | - |
| 8 | Эрүүл агаар эм” өдөрлөг | II/ | 11 | - | - |
| 9 | “Монгол ёс заншил” уралдаан | II/20 | 11 | - | - |
| 10 | “Мэндлэх хүндлэх ёс” уншигчидтай хийсэн уулзалт | II/20 | 117 | - | - |
| 11 | Номын тухай хэлэлцүүлэг | III/01 | 28 | - | - |
| 12 | “Ээжтэйгээ хамтдаа” өдөрлөг | III/07 | 83 | 151,600 | - |
| 13 | “Миний аав миний бахархал” өдөрлөг | III/18 | 53 | 59,000 | 880,000 |
| 14 | “Урин цагийн анир” яруу найргийн өдөрлөг | III/21 | 55 | - | 390,000 |
| 15 | 50 номын хожил /2 удаа/ | III/25, XI/13 | 74 | - | - |
| 16 | “Ус ба энх тайван” эсээ бичлэгийн уралдаан | III/22 | 32 | 100,000 | - |
| 17 | АХА 2 удаа | IV/12,15, V/19 | 95 | - | - |
| 18 | “Хүрэл тулга” яруу найргийн уралдаан | IV/05 | 46 | 28,000 | - |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 19 | Зохиолч уншигчдын кофетой уулзалт /Тодко Самсон/ | IV/16 | 70 | - | 187,000 |
| 20 | Алтан хонх 2 удаа /ШШГГ, | IV/19 | 85 | 30,000 | - |
| 21 | **ҮБҮБ хүрээнд** Монгол бичгийн тэргүүний уншигч шалгаруулах уралдаан | IV/25 | 129 | - | 800,000 |
| 22 | **ҮБҮБ хүрээнд** Босоо бичгийн гайхамшиг сайхан бичиг, бийрийн бичгийн уралдаан | IV/26 | 286 | - | 700,000 |
| 23 | **Номын баяр хүрээнд** Улаанбаатар хотод зохион байгуулагдсан “Гэр” эвент үйл ажиллагаа | IV/20 | 7500 | 130,000 | - |
| 24 | **Номын баяр хүрээнд** аймагт зохион байгуулагдсан “Гэр” эвент үйл ажиллагаанд | IV/26 | 560 | 80,000 | |
| 25 | **Номын баяр хүрээнд** “Миний дуртай үлгэрийн баатар” гар зургийн уралдаан | V/21 | 174 | - | 435,000 |
| 26 | **Номын баяр хүрээнд** “Чанга уншлага” 6 удаа | V/20 | 310 | - | - |
| 27 | **Номын баяр хүрээнд** АХА 5 удаа | V/21 | 375 | 90,000 | |
| 28 | **Номын баяр хүрээнд** Алтан хонх 10 удаа | V/22 | 350 | 100,000 | |
| 29 | **Номын баяр хүрээнд** 50 номын хожил 22 удаа | V/23 | 66 | 20,000 | |
| 30 | “Номтой зун” үйл ажиллагаа /Өвгөнжаргалант зуслан дээр/ | VI/14 | 209 | - | - |
| 31 | Наадмаар Музей дээр үзэсгэлэн, ардын тоглоом 3 удаа | VII/26-28 | 169 | - | - |
| 32 | Хоцрогдол арилгах багштай хамтран ажиллах арга хэмжээ | VIII/04-15 | 15 | - | - |
| 33 | Нүүдэлчин монгол” соёлын фестиваль /Цагаан агуйн талаар танилцуулах, “Хонгор нутгаа танин мэдье-ном, пазл эвлүүлэх, | VIII/16-18 | 6000 | - | - |
| 34 | “Амралтын өдөр уншигчидтайгаа” ном уншлага | IX/28 | 121 | - | - |
| 35 | **Номын баяр -36** хүрээнд “Үсэглэлийн хаад” эх хэлний өдөрт зориулсан уралдаан | IX/12 | 63 | | |
| 36 | **Номын баяр-36дахь** Чанга уншлага 4 удаа | IX/16-18 | 360 | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 37 | **Соёлын бүтээлч сарын хүрээнд 1** “Монгол ёс заншил” өдөрлөг 2 удаа | XI/04-05 | 93 | | |
| 38 | **Соёлын бүтээлч сарын хүрээнд 2** Чила лекторын “Эерэг” лекц | XI/06 | 200 | | |
| 39 | **Соёлын бүтээлч сарын хүрээнд 3** Яруу найрагч Т.Батжаргалын “Үзүүргүй цэнхэр говь” номын нээлт | XI/09 | 20 | | |
| 40 | **Соёлын бүтээлч сарын хүрээнд 4** Сэтгэл зүйн лекц | XI/11 | 15 | | |
| 41 | **Соёлын бүтээлч сарын хүрээнд 5** “Цагаан агуйн ид шид” номын танилцуулга | XI/13 | 57 | | |
| 42 | **Соёлын бүтээлч сарын хүрээнд 6** Үндэсний номын сантай танилцах, туршлага судлах | XI/18 | 11 | | |
| 43 | **Соёлын бүтээлч сарын хүрээнд 7** “Хүрэн морь” яруу найргийн наадам | XI/20 | 99 | | 3,5 сая |
| 44 | **Соёлын бүтээлч сарын хүрээнд 8** “Өсвөрийн яруу найрагч-бид” яруу найргийн уралдаан | XI/25 | 28 | | |
| 45 | **Соёлын бүтээлч сарын хүрээнд 9** “Нийтийн соёлд суралцахуй” сургалт | XI/25 | 10 | | |
| 46 | **Соёлын бүтээлч сарын хүрээнд 10 “Бидний мэдэх найраглал”** Уран уншлагын уралдаан | XI/29 | 10 | | |
| 47 | **Соёлын бүтээлч сарын хүрээнд** 11 номын санчдын ажил мэргэжлийн уралдаан | XI/11-25 | 11 | | |
| Нийт 47 ажил 94 удаагийн давтамжтайгаар | | | 18431 хүн | 1,166,100 | 3,782,000 |

**<u>1.5. Сургалт, семинар.</u>**

*Номын санчдад зориулсан сургалт:*

1.Мэргэжлийн бус номын санчдад номын сангийн анхан шатны мэдлэг олгох сургалтыг зохион байгуулж, Өлзийт, Жаргалант, Эрдэнэмандал ахлах сургууль, Өлзийт, Жинст, Баацагаан орон нутгийн номын санчид хамрагдлаа. Нийт 6 номын санчид хамрагдаж сертификат гардууллаа.

2.Орон нутгийн номын санчдад Lib4u программын цахим сургалтыг Волвес ХХК-ний мэргэжилтэн С.Гантулгатай хамтран 1 удаа зохион байгуулсан.

3.Номын сангийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, чанар хүртээмжийг дээшлүүлэх зорилготой “Koha 22.11” буюу номын сангийн нэгдсэн системийн сургалт зохион байгуулагдлаа. Сургалтыг Монгол Улсын Үндэсний номын сангийн

Мэдээлэл, арга зүй, эрдэм шинжилгээний хэлтсийн ном зүйч Г.Баяртуяа, инженер М.Ариунболд нар ирж, 6 дугаар сарын 17-18-ны өдрүүдэд зохион байгуулсан.

***Уншигчдад зориулсан сургалт:***

1.Иргэдийн зөв амьдрах, эрүүл хооллолт, дасгал хөдөлгөөний ач тусыг мэдрүүлэх, зүрх сэтгэлээ удирдаж сурахад туслах, нөлөөлөх зорилгоор Монгол Улсын Гавьяат багш Сурган хүмүүжүүлэх ухааны доктор Ш.Чимгээгийн санаачилсан "Сэтгэлийн боловсрол", "Амьдрал хурд уу, чиглэл үү" лекцийг уншигчдад зохион байгууллаа. Лекцэнд Шүүхийн шийдвэрийн газрын хамт олон, Номундалай, Эрдэм, 5-р сургууль, Гэгээн сумади, Баян-Ойт, Номгон, Соого сейко, Эрдэнэмандал ахлах сургуулийн сурагчид, Хүүхдийн Тэмүжин театр, Номын сангийн хамт олон нийт 135 хүн хамрагдаж, мэдээлэл сонслоо.

2. "Эцэг эхийн ёс суртахуун", "Сурагчийн ёс зүй" сэдэвт сургалтыг Насан туршийн суралцахуйн төвтэй хамтран зохион байгуулж, албан хаагчид, уншигчид, эцэг эхийн төлөөлөл нийт 87 хүн хамрагдлаа.

3. Аймгийн Архивын тасгийн дэргэхэд Угийн бичиг судлах танхимын мэргэжилтэн С.Гантуяатай хамтран "Угийн бичиг хөтлөх арга зүй" сургалтыг ХААИС-ийн багш, албан хаагч, оюутнуудад явууллаа. Сургалтад 40 хүн оролцсон.

***Албан хаагчдын хамрагдсан сургалт:***

1.АЗДТГ, Хууль, эрх зүйн хэлтэс, Төрийн архивын тасгаас хамтран зохион байгуулсан "Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн шинэчлэлт-өөрчлөлт" зөвлөгөөн, "Архив, албан хэрэг хөтлөлтийн эрх зүйн шинэчлэл" нэгдсэн сургалт, "Монгол бичгийн цахим бичвэр боловсруулах арга зүй", ""Өргөдөл гомдлын систем хөтлөлт", "Егр, e-docx", "Хүний нөөцийн системд албан тушаалын тодорхойлолтыг оруулах арга зүй" цахим сургалтад архив, бичиг хэргийн ажилтан О.Байгал тус тус оролцов.

2.Насан туршийн суралцахуйн төвөөс зохион байгуулсан "Монгол бичгийн цахим бичвэр", "Хүнсний бүтээгдэхүүний шошго унших арга", "Биеийн жингийн индекс хянах", "Хүн хоорондын харилцаа", "Дипломат ёслол, ажил хэрэгч соёл", "Ажлын байрны стресс менежмент", "Хүүхдийн хүмүүжилд эцэг эхийн оролцоо", "Статистик мэдээний сургалт", Онцгой байдлын газрын мэргэжилтэн, дэслэгч Г.Энхбаярын зохион байгуулсан "Галын аюулгүй байдал" гэх мэт 12 төрлийн сургалтад хамт олноороо тухай бүр хамрагдаж, мэдлэгээ дээшлүүлэв.

Нийт 19 төрлийн сургалт явагдаж, 306 хүн давтагдсан тоогоор оролцжээ.

**<u>1.6.Дугуйлан:</u>**

Монгол бичгийн уран бичлэгийн дугуйланг багш Ч.Бямбадолгор удирдаж явуулж, 6 хүүхэд суралцаж байна.

"Номын зууч" клубт ахлах ангийн 15 сурагч хамрагдаж байна.

**Хоёр. Удирдлагын ажил.**

**2.1.Хууль эрх зүйн хүрээнд.** Төрөөс баримтлах соёлын бодлого Соёлын тухай хууль, Номын сангийн тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, номын сангийн стандарт, холбогдох дүрэм, журмыг хэрэгжүүлэн, Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2021 оны 100 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу албан хаагчдын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, ажлын гүйцэтгэлээр үр дүнг хагас, бүтэн жилээр үнэлэн, урамшууллыг олгож ажиллаа.

-Аймгийн Соёл, урлагийн газрын дарга Д.Мөнхцэцэгтэй 2024 онд хамтран ажиллах гэрээ байгууллаа. Гэрээний нэгдүгээр хавсралтаар “Соёлын сайд, аймгийн Засаг дарга нарын хооронд 2024 онд хамтран ажиллах гэрээ”, аймгийн 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөө, орон нутгаас баримталж буй бодлого, стратегийн төлөвлөгөөний холбогдох зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Гэрээний хоёрдугаар хавсралтаар болох тухайн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тухайн байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх зорилт, арга хэмжээг тусгасан байна.

-Соёлын сайдын 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/27 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Соёлын салбарын 2024 оны хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалт"-д заасны дагуу төлөвлөгөөт шалгалт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, илэрсэн зөрчлийг таслан зогсоох, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр соёлын хяналтын улсын ахлах байцаагч С.Урантөгс, соёлын хяналтын улсын ахлах байцаагч Д.Отгонбаяр, соёлын хяналтын улсын ахлах байцаагч Б.Оюунзул нар Баянхонгорт ажиллалаа.

Тус хяналт шалгалтаар үйл ажиллагаатай холбогдох баримт бичгийг хянан үзэх, үйл ажиллагаа явуулдаг байр, барилга байгууламж, өрөө тасалгаа, тоног төхөөрөмж, бусад объектод үзлэг хийх, эрсдэлийн шалгуур, үзүүлэлтээр үнэлгээ өгөх, илэрсэн зөрчил, дутагдал, нөхцөл байдал, үр дүнг баталгаажуулан фото зураг авах, дүрс бичлэг хийх, иргэн, хуулийн этгээд, ашиглагч (эзэмшигч, өмчлөгч)-аас тайлбар, тодорхойлолт, шаардлагатай баримт бичгийг гаргуулан авах, хяналтын хуудсаар шалгалт хийж, эрсдэлийг үнэлгээг хийлгэлээ. Дүнг Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газарт танилцуулагдсан.

Байгууллагын түүхт 80 жилийн ойг 2024 оны 10 дугаар сарын 17-18-ны өдрүүдэд зохион байгууллаа. Ойн хүрээнд “Наян жилийн түүхтэй номун гэгээн өргөө минь” номыг бүтээж, “Битпресс” ХХК-д 300 хувийг хэвлүүлэв. Номын нийт төсөвт 5.910.000 төгрөг зарцуулсан. Мөн сум, сургуулийн номын санчид, зочид төлөөлөгчдийн дунд волейбол, ширээний теннис, дартс, олс таталтын тэмцээнийг зохион байгуулж, 6 багийн 70 гаруй хүн оролцсон. Баярын хурал, Хүндэтгэлийн тоглолт, “Номын санч миний бахархал” бүтээлийн үзэсгэлэн, дурсгалын зураг татуулах, үдийн зоог, Шинэ номын нээлт, Хүндэтгэлийн хүлээн авалтыг хамт олноороо амжилттай зохион байгууллаа. .

**2.2.<u>Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд:</u>**
Байгууллагын зүгээс ахмаддаа сар шинийн баяраар хүндэтгэл үзүүлж нийт **350,000** төгрөг, Баянхонгор сумын “Хөдөлмөрийн аварга” шагналаар шагнагдсан сүлжээний инженер М.Дондовжамцад **30,000** төгрөг, Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр албан хаагчдын 27 хүүхдийг баярлуулахад **387,000** төгрөг, эрүүл мэндийг тэтгэх витамин олгож **2,864,000** төгрөг, хамт олны аялалд **848,600** төгрөг, Үндэсний номын сантай танилцах, туршлага судлахад **3,000,000** төгрөг, албан хаагчдад тамирын хослол захиалан авахад 495,000 /50%/ төгрөг, хүүхдийн танхимын номын санч Б.Янжмаад Соёл, урлагийн их сургуулийн Номын сангийн эчнээ ангид элсэн суралцахад цалинтай чөлөө олгож сурах боломжоор хангасан, байгууллагын тохижилт, засвар, ая тухайтай орчин бүрдүүлэх зардалд **3,000,000** төгрөг, спорт заалтай гэрээ байгуулахад 200,000 төгрөгийг зарцуулсан зэргээр нийгмийн баталгааг дэмжих, ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлж ажилласан.

**2.3.<u>Хүний нөөцийн ажил</u>**: Албан хаагчдийн төрийн албанд ажилласан хугацааны, хоол унааны, орон нутагт ажилласны нэмэгдлийг, мөн Засгийн газрын 2024 оны 84, 128 дугаар тогтоолоор өөрчлөгдсөн цалингийн өөрчлөлт, ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчийн (Ном зүйч, нярав Б.Должин) мэдээллийг системд тус тус бүртгэв.

**2.4.Шагнал:**

Байгууллагын аварга ажилтнаар ном зүйч Б.Должин, Баянхонгор сумын “Хөдөлмөрийн аварга” ажилтнаар сүлжээний инженер М.Дондовжамц, Монгол Улсын Засгийн газрын шагнал “Соёлын тэргүүний ажилтан” цол, тэмдгээр сан хөмрөгч Б.Бүжидмаа, сүлжээний инженер М.Дондовжамц нар, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны “Жуух бичиг”-ээр номын санч Ц.Болорчимэг, Архивын ерөнхий газрын “Хүндэт жуух бичиг”-ээр архив, бичиг хэргийн ажилтан О.Байгал, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дээд шагнал “Соёрхол” одонгоор архив, бичиг хэргийн ажилтан О.Байгал, номын санч Ц.Дэлгэрмаа нар, аймгийн “Тэргүүний ажилтан” цол тэмдгээр номын санч Б.Янжмаа, үйлчлэгч А.Уранчимэг нэр, аймгийн Засаг даргын “Жуух” бичгээр нягтлан бодогч Г.Батдалай, харуул Ж.Оргилболд нар тус тус шагнагдлаа.

**Гурав. Архив, албан хэрэг хөтлөлтийн ажил**: Архив, албан хэрэг хөтлөлтийн ажлыг шинэчлэгдсэн хууль, холбогдох журам, баримт бичгийн MNS5140:2021 стандартын дагуу хөтлөн, хууль, журмыг ажилтнуудад дотоод сүлжээгээр тарааж, сурталчлан таниулж, арга зүйн зөвлөгөөг тухай бүр өгч ажилласан.

Тайлангийн хугацаанд тушаал 37, хамт олны хурал 15 удаа, захиргааны зөвлөл 2 удаа, өмч хамгаалах байнгын зөвлөл 3 удаа, баримт нягтлан шалгах комиссын хурал 3, ирсэн бичиг 132, үүнээс хариутай бичиг 77, явсан бичиг 99, ирсэн захирамж, тогтоол 4, өргөдөл 3, түр олгосон баримт 32 байна.

i-office программыг албан бичиг солилцооны DOCX.gov.mn дундын системтэй холбож, байгууллага хооронд харилцаж байна.

Мөн Өргөдөл гомдлын EOFFICE цахим системийг хариуцан ажиллаж, нийт ирсэн 3 өргөдөлийг бүртгэн, хугацаанд нь шийдвэрлэж, мэдээг улирал тутамд Соёл, урлагийн газарт мэдээллэв.

<u>Архивын ажил:</u> Албан хаагчдаас ирүүлсэн санал болон өмнөх оны хөтлөх хэргийн жагсаалт, байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг үндэслэн 2024 оны хөтлөх хэрэгт 168 нэгж баримтыг тусган жагсаалтыг боловсруулж, Төрийн архивын тасагт хугацаанд нь хүргэв.

Албан хаагчдаас 2023 оны баримтыг бүртгэлээр авч, байнга хадгалах 46, түр 94, түр 70 жилийн 4 нэгж баримт бүртгэв.

<u>Цахимжуулалт:</u> Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр, “Цахим архив-Баянхонгор” дэд хөтөлбөрийн хүрээнд Төрийн архивын үндсэн санд 2021 оны байнга хадгалах 519 хуудас бүхий 53 нэгж баримтыг цаасаар болон цахим хувиар дансны хамт шилжүүлэв.

Байгууллагын 2024 оны гэрэл зургийн цомог 1ш (40 ширхэг зурагтай), “Байгууллагын түүхт 80 жилийн ойн зургийн цомог” -1ш (40 ширхэг зурагтай), “Наян жилийн түүхтэй Номун гэгээн өргөө минь” ном 1ш тус тус Төрийн архивд шилжүүлэв.

<u>БНШК-ын ажил</u>: Байгууллагад хэрэглэгддэг 7 төрлийн тэмдэг, дардас, 13 төрлийн хэвлэмэл хуудсыг захирлын тушаалаар томилогдсон комиссын дарга, гишүүд нүдээр үзэн тоолов. Тэмдэг, хэвлэмэл хуудасны ямар нэг зөрчилгүй, тооллогыг цаг

хугацаанд нь гүйцэтгэж, Архивын тасагт тайланг хүргэлээ. Устгасан 16 ширхэг хэвлэмэл хуудсыг бүртгэн, 9540 төгрөгийн төлбөрийг байгууллагын дансанд тушаасан.

**Үндэсний бичиг сурах, албан хэргийг үндэсний бичгээр хослон бичих ажлын хүрээнд:** "Монгол бичгийн цахим бичвэр, дадлага" сэдэвт 5 цагийн сургалтад хамрагдсан. Монгол бичгийн албан бичгийн А-5, А-4, тушаал, хурлын тэмдэглэлийн хэвлэмэл хуудас тус тус захиалан авч, 35 албан бичгийн хослон гаргав. Уран бичлэгийн дугуйлангийн багш Ч.Бямбадолгорын санаачлан зохион байгуулсан Монгол бичгийн хурдан уншлагын уралдаанд оролцож, 79 үг уншиж, дэд байрт шалгарав. Аймгийн Төрийн архиваас зохион байгуулсан Монгол бичгийн цахим бичвэр шалгах ажил мэргэжлийн уралдаанд архив, бичиг хэргийн ажилтан О.Байгал амжилттай оролцсон.

**Дөрөв.Мэдээллийн үйлчилгээ:** Байгууллагын 15 компьютерын дотоод сүлжээ, LIB4U программ, тогтмол хэвлэлийн Zotero программын хэвийн ажиллагааг хангаж, вирустсэн компьютерийг форматлах, компьютер, техник хэрэгслүүд, сүлжээ эвдрэл гэмтэл гарсан тухай бүрд нь засаж хэвийн ажиллагааг хангаж ажилласан. Компьютерт 6 удаа систем суулган, hp-1102, Epson-I 850 принтерийн хорыг 4 удаа цэнэглэж, сүлжээний кабелийг шинээр сольсон. "Номын сан Баянхонгор" facebook цахим хуудсанд уншигчид, хүүхэд багачуудад зориулан мэдээ мэдээллийг байршуулж, нийтлэлийн хүртээмж 74323, нийтлэлтэй харьцах 3230, хуваалцсан тоо 1320, шинээр дагаж нэгдсэн 572 хэрэглэгч, нийт дагагч 1454 байна.

**Тав. Санхүү, бүртгэлийн ажил**: Нийт батлагдсан төсөв 400,530,106.06 төгрөг, үүнээс үндсэн цалин 263,948,792 төгрөг, Нийгмийн даатгалын шимтгэлд 33,151,024 төгрөг, урсгал зардал 3,099,000 төгрөг, ном хэвлэл худалдан авахад 5,398,999 төгрөг байлаа. Үр дүнд суурилсан санхүүжилт 19,096,500 төгрөгийн санхүүжилтийг авч холбогдох зардлуудыг эдийн засгийн ангиллын дагуу захиран зарцуулж, Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Монгол Улсын Засгийн газрын холбогдох тогтоол, шийдвэр, Соёлын яам, Санхүү төрийн сангийн хэлтсээс гаргасан журам, шийдвэрийг хэрэгжүүлэн, санхүү бүртгэлийн тайланг цаг тухайд нь гаргаж, шилэн данс, төсвийн мэдээллийн самбараар дамжуулж иргэд, уншигчдад санхүүгийн ил тод байдлыг мэдээлж ажилласан.
Шилэн дансны мэдээллийг цаг хугацаанд нь үнэн зөв байршуулан, Сангийн сайдын 347 дугаар тушаалаар батлагдсан анхан шатны баримтын маягтын дагуу 13 нэр төрлийн баримтыг шинэчлэн хөтөлж, байгууллагын хагас, бүтэн жилийн эд хөрөнгийн тооллогыг цаг хугацаанд нь зохион байгуулан ажиллаж байна.

**Зургаа. Орон тооны бус зөвлөлүүдийн ажил:**

**6.1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй:** Байгууллагын ХАБЭА-н жилийн төлөвлөгөөг гарган, хэрэгжүүлэн ажиллаа. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчийн зохион байгуулсан төлөвлөгөөт бус хяналт шалгалтаар "Эрсдэл бага" үнэлэгдэж, албан шаардлагын хариуг хугацаанд нь хүргэлээ. Эрүүл мэнд үзлэг, витаминжуулалтад хамрагдав.
Гаднах шатны хажуугийн тэргэнцэртэй иргэний замын бариул хугарсныг гагнах, үүдний шилэн хаалга шиллэж, шилний наалт наах зэрэг ажлууд хийгдсэн.

**6.2.Залуучуудын зөвлөл:** Албан хаагчдын дунд "Эрүүл агаар эм", Сар "Монгол ёс тэмцээн" тэмцээнийг зохион байгуулсан. Эрүүл мэнддээ анхаарч, спортоор

хичээллэх, хамт олны нийтэч уур амьсгалыг бий болгох зорилгоор долоо хоногт нэг удаа 2 цаг зааланд тогтмол тоглож, улирал бүр хөгжөөнт тоглоом явуулж хэвшсэн.
**6.3.Дотоод хяналт шалгалт**: Жилийн ажлын төлөвлөгөө, Дотоод хяналтын ажиллах журам, дотоод хяналт шалгалт хийх удирдамж тус тус боловсруулан, төлөвлөсөн ажлуудыг хийж хэрэгжүүлж ажиллаа.
**6.4.Ёс зүйн зөвлөл**: Захиралын 2024 оны 09 дүгээр саын 13-ны өдрийн А/13 тушаалаар байгууллагын дэргэдэх “Ёс зүйн дэд хороо”-г 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулав. Ёс зүйн дэд хорооны ажлын хэсэг албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүйн талаар сургалт мэдээлэл өгч, багийн бүрэлдэхүүнийг танилцуулж, холбогдох дүрэм журмыг мөрдөн ажиллах, ёс зүйн зөрчлийн талаарх гомдол мэдээллийг хэлэлцэх, хүлээн авах, хянан шалгах, дүгнэлт гаргах тайлан мэдээг гаргаж хуулийн хугацаанд холбогдох газарт хүргүүлэх зэрэг ажлын чиг үүрэгтэйг танилцууллаа.
**6.5.Авлигатай тэмцэх ажил:** Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг хууль, дүрэм журмыг албан хаагчдад танилцуулж, олон нийтийн сүлжээнд сурталчилсан. “Авлигын эсрэг гэрэл түгээе” аяны хүрээнд нийт албан хаагчид фэйсбүүкийн нүүр зургаа дээрх уриа бүхий хүрээгээр сольж нэгдсэн.
**6.6.Эцэг эхийн зөвлөл:** Байгууллага дээр “Хүүхэд хөгжлийн өрөө”-г тохижуулж албан хаагчдын хүүхдүүд байнга үйлчлүүлж байх шинэ орчныг бүрдүүлж, төсөвт 3,000,000 төгрөг зарцуулсан. Албан хаагчдын 18 хүртэлх насны хүүхдүүдийн төрсөн өдрөөр нь ээжүүдэд нь чөлөө олгож, хүүхэдтэйгээ цагийг өнгөрүүлэх нөхцөлийг олгосон. Ханиад, томуу ихтэй үед 0-9 насны хүүхэдтэй эхчүүдийг богиносгосон цагаар ажиллуулав.
**<u>Долоо. Байгууллагын тохижилт, ая тухтай байдал:</u>** Байгууллагын цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол чанартай зохион байгуулж, тогтсон хугацаанд их цэвэрлэгээг хийн, номын сангаар үйлчлүүлж байгаа хүүхдүүдийн аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. Байгууллагын гаднах ногоон байгууламжийг нэмэгдүүлэн, арчилгааг тогтмол хийж хэвшсэн.
Хүүхдийн уншлагын танхим, захирлын өрөө, коридорт их засвар хийх, сантехникийн шугам, цоорсон труба солих зэрэг засварын ажлуудыг хийж, төсөвт 1,260,000 төгрөг зарцуулсан.
**Төлөвлөгөөнөөс бусад ажил:**
Аймаг, орон нутгаас зохион байгуулж буй бүх нийтийг хамарсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, цас цэвэрлэх, нийтийн эзэмшил талбайн хог цэвэрлэх, малчдад хандив тусламж өгөх, Хүмүүнлэгийн ажлуудад хамт олноороо тогтмол оролцож ажиллаа.
Малчдад туслах аянд хамт олноороо нэгдэж, нэмнээ 37 ширхэг, хошуувч 9 ширхэг, 330,000 төгрөг хандивлав.
Ойн зурваст 50 ширхэг модны нүх ухаж, модыг суулгаж, услав.
Хамт олноор Өвөрхангай аймгийн Төвхөн хийх, Орхоны хүрхрээгээр аялав.
**Дүгнэлт:**
2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 24 ажил төлөвлөж, төлөвлөсөн ажлууд 99,4 хувьтай биелэгдсэн.

**Ололттой зүйлүүд:**

- “Монгол гарваль” өв соёлын хүрээлэн ТББ-тай хамтран “Цагаан агуйн ид шид” хүүхдийн номыг бүтээсэн.
- Байгууллагын түүхт 80 жилийн ойг амжилттай зохион байгуулж, “Наян жилийн түүхтэй номун гэгээн өргөө минь” ном бүтээсэн.

**Цаашид анхаарах ажлууд:**

- Уншлага үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх
- Зохион байгуулж буй ажлуудын чанарыг сайжруулах
- Шинэ шинэлэг үйлчилгээ санаачлан зохион байгуулах
- Koha системийг нэвтрүүлэх

## БУЛГАН АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

### 1. АЛСЫН ХАРАА

Чанартай үйлчилгээ
Чадварлаг хамт олон

### ЭРХЭМ ЗОРИЛГО

Мэдээллийг түгээе
Мэдлэгийг цогцлооё

### СТРАТЕГИЙН ЗОРИЛТ

Үндэсний соёлын үнэт өв ном хэвлэлийг хадгалж хамгаалах, сурталчилан таниулах, ард иргэдэд номын сангийн үйлчилгээг хүргэх, ном хэвлэл, соёл олон түмний ажлаар дамжуулан соён гэгээрүүлэх, бүтээлч уншлагыг дэмжин үр өгөөжийг нэмэгдүүлэхэд оршино.

### ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

| Дотоод орчин | |
|---|---|
| Давуу тал<br>Шинэ барилга баригдахаар 2024 оны улсын төсөвт тусгагдсан<br>Мэргэжлийн удирдлагатай<br>Байршил сайтай<br>Соёл олон нийтийн ажлын зохион байгуулалт сайн<br>Ном хэвлэл 100% цахим каталогт орсон<br>Уншигчийн бүртгэл, ном олгох үйлчилгээ 90% цахим болсон<br>Бүх албан хэрэгцээнд ашиглаж байгаа комьпютерууд вирусын хамгаалалт, нэмэлт hard суулгаж багтаамж, хурд сайжруулсан | Сул тал<br>Дохиолол хамгааллын системгүй<br>Агааржуулалт, ариун цэврийн өрөө дотор ОО байхгүй<br>Сантехник, цахилгааны монтаж муу<br>Заал танхимын багтаамж хүрэлцээ бага<br>Цахим сан хөмрөг бага |
| Гадаад орчин | |

| Боломж | Аюул |
|---|---|
| Соёлын яамтай болсон<br>Төсөл хөтөлбөрт хамрагдах<br>Номын сангууд болон төр бус байгууллагууд хамтын ажиллагааг сайжруулах<br>Номын сангууд нэгдсэн каталог, програм ашиглах<br>Нэгдсэн нэг ангилал ашиглах<br>Гадаадын хөрөнгө оруулалт татах | Барилга МХГ, ОБГ зэрэг мэргэжлийн байгууллагуудын дүгнэлтүүд гарсан, ашиглалтын хугацаа дууссан |

## 2.УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:

✓ 2024 онд Аймгийн засаг дарга, Соёл урлагийн газартай гүйцэтгэлийн гэрээ байгуулан 4 зорилтын хүрээнд 43 арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлж 94,1%-тай үнэлэгдлээ.

✓ 2024 онд хийсэн ажлын үр дүнгээр 25.584.400 төгрөгний нэмэлт санхүүжилтийг Соёлын яамнаас авч зориулалтын дагуу зарцууллаа.

✓ Номын сангийн шинэ барилга баригдаж эхэлсэн тул номын сангийн хэвийн үйл ажиллагааг ханган ажиллах боломжийг бүрдүүлж 8 сарын хугацаанд түрээсийн байранд номын сангийн үйлчилгээг явуулж ажилласан.

✓ Номын сангийн шинэ барилга Соёлын яамны захиалгаар 2,9 тэрбум төгрөгийн санхүүжилтээр "Зууны сод хийц" ХХК гүйцэтгэж хугацаанаас нь өмнө буюу 2024 оны 12 сарын 25-ны өдөр улсын комисст хүлээлгэн өгч ашиглалтад орууллаа.

✓ Номын сангийн нэгдсэн систем Коха програмыг ашиглалтыг эхлүүлсэн.

✓ Бүх нийтийн Соёлын боловсрол олгох нийгмийн соён гэгээрүүлэх нөлөөллийн чиглэлээр 24 удаагийн сургалт зохион байгуулж 1325 хүн хамруулсан.

✓ Үндэсний бичиг, соёл номын өдрүүдийг хуулийн хугацаанд нь хавар, намар зохион байгуулж 1750 хүн хамрагдсан.

✓ Өөрийн номын сангийн цахим сан хөмрөгийг нэмэгдүүлэх зорилгоор зохиогчийн эрхийн зөрчилгүй 10 номыг цахим хэлбэрт оруулж нийтдээ 32 ширхэг номыг цахим болгоод байна.

✓ Гадаад хамтын ажиллагааны хүрээнд ОХУ-ын Буриад улсын Закаменск хотын номын сантай 2019 оноос эхлэн хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж 2024 онд Булган аймагт болсон Буриад үндэсний олон улсын "Алтаргана 2024" наадмын "Номын уралдаан", "Буриад яруу найргийн уралдаан"-ыг хамтран зохион байгуулж Буриад яруу найргийн уралдаанд 16 яруу найрагч 2 насны ангилалаар, Номын уралдаанд 54 зохиолчийн 63 бүтээл 4 төрлөөр оролцсон.

✓ Дотоод хамтын ажиллагааны хүрээнд хамт олноороо Улаанбаатар хотын Нийтийн Номын сан, Хүүхдийн төв номын сан, Дорноговь, Орхон, Хөвсгөл сан, Дархан-Уул аймгийн нийтийн номын сан, Хүүхдийн номын сангуудын үйл ажиллагаатай танилцан, харилцан туршлага судлуулж, Дархан хотод хойд болон төвийн бүсийн аймгуудын номын санчдын зөвлөгөөнийг хамтран зохион байгуулсан.

✓ “Хүүхдийн бүтээлч уншлага” аяныг 3 дахь жилдээ үргэжлүүлэн аймгийн хэмжээнд зохион байгуулж 2306 хүүхдийг 657 удаагийн ангийн уншлагад хамруулж жилийн эцэст шилдэгүүдийг шалгаруулж 2.400.000 төгрөгөөр урамшуулж шагнасан.

✓ “Гэр бүлийн уншлага” хөдөлгөөн өрнүүлж уншигч гэр бүлийн шалгаруулсан

✓ Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр “Номын шидтэнгүүд” маскотыг жил бүр сэдвийг өөрчлөн номын санчид өөрсдийн гараар урлаж хийх уламжлал тогтоож цаашид хүүхэд багачуудыг номтой нөхөрлүүлэх номын сангийн нэрийн хуудас болсон ажил болгохоор зорин ажиллаж байна.

✓ Зуны улиралд нүүдэл явуулын номын сангийн үйлчилгээг тогтмолжуулж Булган сумын 5 баг, “Жаргалант” хүүхдийн зусланд номын сангийн үйлчилгээг хүргэж ажилласан.

✓ Байгууллага хамт олныг ном унших дадал хэвшил, тогтмол уншлагын цаг бий болгох зорилгоор “Өглөөний уншлага” аян өрнүүлж 15 байгууллага 142 уншигч 73 удаа 579 ном олгож үйлчилсэн. 300.000 төгрөг зарцуулсан.

✓ Хүний нөөц, боловсон хүчний хангалтыг сайжруулахаар СУИС-ийн Соёлын сургуульд 3 номын санчийг эчнээгээр сургаж мэргэшүүлж байна. Номын санчдын мэргэжлийн чадваржуулах сургалт 11, хууль эрх зүйн 16, бусад 7 нийт 34 сургалтад давхардсан тоогоор 169 хүн хамруулж ажиллагсадыг чадваржуулах, ур чадварыг нэмэгдүүлэх сургалтад нийт 7,140,000 төгрөг зарцуулсан.

✓ Үр дүнд суурилсан санхүүжилтээр 25,584,5 төгрөг авч хөрөнгө оруулалт, үйл ажиллагаа, ажиллагсадын цалин урамшуулал, нийгмийн баталгаанд зарцуулсан.

✓ Ажилтан албан хаагчдын нийгмийн баталгаанд 2024 онд 8 ажил төлөвлөж бүрэн хэрэгжүүлсэн. Ажилтнуудын 28 удаагийн хүсэлтээр эмнэлэгт үзүүлэх, эмчилгээ хийлгэх, хүүхдийнхээ сургууль цэцэрлэгийн олон нийтийн ажилд оролцох, хүүхдээ цэцэрлэг сургуулиас авах өгөх, ар гэрийн хүндэтгэх шалтгаантай ажил гарахад ажлын 731 цаг буюу 91 хоног цалинтай чөлөө олгож нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлсэн. Ажиллагсадын нийгмийн баталгаанд 3,834,000 төгрөг зарцуулсан.

✓ Номын сангийн мэргэжил арга зүйн зөвлөн туслах үйлчилгээг сум сургуулийн номын сангуудад үзүүлж сумын “Жишиг номын сан” бий болгох санаачлагыг гаргаж Баяннуур, Бүрэгхангай, Дашинчилэн, Рашаант сумын номын сангуудад ажилласан.

✓ “Номын санч” мэргэжил сурталчилах ажлыг 4 удаа 3 сургуулийн 8-11-р ангийн 465 хүүхдэд хийсэн. 750.000 төгрөг зарцуулсан.

✓ Ажилтан, албан хаагчдыг чадахижуулах сургалт, хувь хүний хөгжлийн сургалтуудад хамруулж, 3 баг болгож хөгжөөнт тэмцээн зохион байгуулж жилийн ажлаа дүгнэлээ.

## 3.УНШЛАГА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТООН МЭДЭЭ

**Уншигч**: 2995 байнгын 918, шинэ 2077 байна.
**Ирэгсэд:** 19207
**Ном олголт:** Нийт олгосон 17662. Уншлагын танхимаар 9515, гэрээр 1752, зөөврөөр 4800 байна.

**Ном хангамж:** $\dfrac{\text{НФ-35676}}{\text{У-2995}}$ **=119**

**Ном уншилт:** $\dfrac{\text{НО-17662}}{\text{У-2995}}$ **= 5,8**

**Фондын эргэлт:** $\dfrac{\text{НО-17662}}{\text{НФ-35676}}$ **= 2.01%**

**2012-2024 оны уншигч, ирэгсэд, ном олголтын тоон үзүүлэлтийг харуулав**



## 4.ЯВУУЛЫН НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

43 газарт 160 удаа  1184 уншигч, 8395 иргэсдэд 4800 номоор үйлчилсэн.







## 5.САН ХӨМРӨГ БҮРДҮҮЛЭЛТ

2024 онд нийт 248 нэр төрлийн  461 ширхэг, 10,848,679 төгрөгний номоор фонд баяжилт хийсэн.

Үүнээс улсын төсвөөс худалдаагаар 161 нэр төрлийн, 343 ширхэг, 7,444,899 төгрөгний ном бэлэг, хандиваар 74 нэр төрлийн, 99 ширхэг, 3,016,300 төгрөгний ном, 5 нэр төрлийн 19 ширхэг 387,480 төгрөгний тогтмол хэвлэлээр фонд баяжилт хийсэн байна. 2024 онд сан хөмрөг, гэрээр ном олгох танхимаас элэгдэж муудсан уншлагад гаргах боломжгүй эрүүл ахуйн шаардлага хангахгүй хуучин ном хэвлэлийг акталж

цэгцлэх ажлын хүрээнд 191 ширхэг 426,120 төгрөгний үнэ бүхий номыг акталж данс бүртгэлээс хассан.







## 6.САН ХӨМРӨГИЙН ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТ

Мэргэжлийн байгууллагаар 1 удаа ариутгал, 2 удаа шавьж устгал хийж 95,000 төгрөгний төсөв зарцуулсан.

Сан хөмрөгт олон жил хадгалагдан элэгдэж муудсан уншлагад гаргах боломжгүй эрүүл ахуйн шаардлага хангахгүй хуучин ном хэвлэлийг акталж цэгцлэх ажлыг үргэлжилж байна.

Сан хөмрөг, уншлагын танхимуудын ойрын фондын ээлжит бус тооллогыг хийж тооллогоор дутсан ном хэвлэлийг холбогдох ажилтнаар төлүүлэх ажил хийгдэж байна.

Урагдаж элэгдсэн 278 ном сэлбэн засаж уншлагад гаргасан. 179,000 төгрөг зарцуулсан.

## 7. ЛАВЛАГАА, МЭДЭЭЛЭЛ

Нийт 362 лавлагаа өгөгдөж үүнээс тодотгосон 151, сэдэвчилсэн 102, ном зүйн мэдээ тодруулах 49, статистик тоо мэдээ 12 байна. Амаар 185, бичгээр 14, утас, цахимаар 45 байна.

БШСУ-ны сайдын 2005 оны 441 дүгээр тушаалын 11 дүгээр хавсралтаар батлагдсан “Өгөгдсөн номзүйн лавлагааны бүртгэл”-ийн маягтыг орчин цагийн үйлчилгээний стандартад нийцүүлэн шинэчлэх шаардлагатай байна.




## 8. ТАТГАЛЗАЛ:

Нийт 304 ном татгалзалд бүртгэгдсэн. 31 номыг бүрдүүлэлтээр авч уншигч нарт олгосон. Мөн үлдсэн номыг ижил төстэй номуудаар орлуулан ач бүрдүүлэлт хийсэн.

## 9. МЭРГЭЖИЛ АРГАЗҮЙ

13 сум, 4 сургууль, 1 байгууллагын номын санчид 84 удаа, АННС-ийн номын санчид давхардсан тоогоор 250 удаа нийт 334 удаа лавлагаа мэдээлэл өгч зөвлөн тусалсан. Сум, сургуулийн номын санчдад 2 удаа цахим сургалт зохион байгуулсан. 46 номын санч хамрагдсан. Бүрэгхангай, Дашинчилэн, Баяннуур, Орхон сумын номын сангуудад газар дээр очиж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч Рашаант сумын номын сангийн сан хөмрөгийн зохион байгуулалт, анхан шатны бүртгэл хөтлөх ажлыг эхлүүлж АННС-аас 3 хүний бүрэлдэхүүнтэй баг 3 хоног ажиллаж “Жишиг номын сан” болгох ажлыг эхлүүлсэн. 920.000 төгрөг зарцуулсан.

**Дотоодоос болон гаднаас зохион байгуулсан сургалтууд:**

- Улаанбаатар хотын номын сан, ХТНС дээр “Номын санчдыг чадваржуулах сургалт, “Соёлын түүчээ”, “Соёлын бүтээлч үйлдвэрлэл-2024” сургалт зөвлөгөөн, хойд бүсийн номын санчдын сургалт, ТАЗ-с зохион байгуулдаг 4:7:10 сургалтад 12 удаа “Цахимд хэвшье”, ТАЗ-ын ёс зүйн хорооны сургалт, MOWCAP ийн сургалт, Номын санчдын мэргэжлийн чадваржуулах сургалт 11, хууль эрх зүйн 16, бусад 7 нийт 34 сургалтад давхардсан тоогоор 169 хүн хамрагдсан.

Ажиллагсадын чадваржуулах, ур чадварыг нэмэгдүүлэх сургалтад нийт 7,140,000 төгрөг зарцуулсан.

- Соёлын биет бус өвийг хамгаалах чадавхийг бэхжүүлэх, үндэсний сургагч багш бэлтгэх 2 дахь шатны сургалтад захирал Т.Мөнгөнтуяа хамрагдсан.
- "Mongolian library update-2023" Номын санч-Мэдээллийн ажилтнуудын улсын X зөвлөгөөн, сургалт мэдээлэлд арга зүйч Ч.Цэндмаа танхимаар хамрагдсан.

## 10.НОМЗҮЙ

Шинээр нэмэгдсэн 461 ширхэг ном хэвлэлийг анхан шатны бүртгэлд тусган техник ажиллагааг хийж заал танхимуудад хувиарлан уншлаганд гаргасан.

Өөрийн номын сангийн сан хөмрөгт байгаа “Үндэсний бичгийн ном зүйн гарын авлага” 32 номоор, НУТ-ын заалны “Сурган хүмүүжүүлэх ухаан”-ны 34 номоор, “Утга зохиолын 83 ном нийт 3 сэдвийн ном зүйн гарын авлага хийсэн.

## 11. КАТАЛОГ

Манай номын сан Коха нэгдсэн системийн 2 өдрийн танхимын сургалтад хамрагдсан. Өмнөх Lib4U програмд ашиглаж байсан уншигч болон номын баазаа МУҮНС-д илгээж Коха програмд хөрвүүлүүлсэн. Бүх аймгийн бааз Коха нэгдсэн системд төвлөрсөн ачаалал ихтэй байна. Иймээс ашиглалт удаашралтай хүлээлттэй байгаа тул гар бүртгэл дээр ажиллаж байна.

## 12. НОМЫН ҮЗЭСГЭЛЭН, СУРТАЛЧИЛГАА

93 удаа 2776 номоор үзэсгэлэн гаргаж 8146 хүн үзсэн.

| № | Номын үзэсгэлэнгийн нэр | Үзэсгэлэн гаргасан номын тоо | Эхэлсэн Огноо /тоо хооронд ташуу зураас авах/ | Дууссан Огноо /тоо хооронд ташуу зураас | Хаана | Үзсэн хүний тоо танхимаар | Цахимаар | Хариуцсан ажилтан гарын үсэг |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Явуулын номын сан | 55 | 4/18/2024 | 4/19/2024 | Хишиг-Өндөр | 128 | | Ч.Цэндмаа |
| 2 | Явуулын номын сан | 50 | 4/19/2024 | 4/20/2024 | Могод | 100 | | Ч.Цэндмаа |
| 3 | Бидний бичиг соёл монгол бичгийн номын үз | 27 | 5/17/2024 | 5/17/2024 | Соёлын ордон | 300 | | Ц.Одмаа |
| 4 | Шинэ номын үзэсгэлэн | 25 | 5/17/2024 | 5/17/2024 | Соёлын ордон | 300 | | Ц.Одмаа |
| 5 | Шинэ номын үзэсгэлэн | 11 | 1/11/2024 | 1/19/2024 | | 123 | | Б.Ариунжаргал |
| 6 | Охидын тухай | 25 | 2/29/2024 | 3/8/2024 | | 90 | | Б.Ариунжаргал |
| 7 | Уран зохиол | 15 | 5/1/2024 | 5/10/2024 | | 103 | | Б.Ариунжаргал |
| 8 | Лавлагааны ном | 12 | 5/20/2024 | 5/24/2024 | | 75 | | Б.Ариунжаргал |
| 9 | Шинэ номын үзэсгэлэн | 90 | 1/2/2024 | 1/9/2024 | | 28 | | Г.Энхбилэг |
| 10 | Үндсэн хуулийн өдөрт | 64 | 1/10/2024 | 1/14/2024 | | 60 | | Г.Энхбилэг, Д.Отгонцэцэг |
| 11 | Дэлхийн сонгодог зохиолууд | 72 | 1/15/2024 | 1/21/2024 | | 23 | | Г.Энхбилэг |
| 12 | 7 хоногийн хамгийн их уншигдсан ном | 30 | 1/15/2024 | 1/21/2024 | | 23 | | Г.Энхбилэг |
| 13 | Сурагчдын амралтад | 75 | 1/22/2024 | 1/29/2024 | | 43 | | Г.Энхбилэг |
| 14 | жанжин Д.Сүхбаатар | 74 | 1/30/2024 | 2/5/2024 | | 99 | | Г.Энхбилэг |
| 15 | Бидний өв соёл | 58 | 2/6/2024 | 2/29/2024 | | 616 | | Г.Энхбилэг, Д.Отгонцэцэг |
| 16 | Эх орончдын өдөрт | 75 | 3/1/2024 | 3/5/2024 | | 218 | | Г.Энхбилэг, Д.Отгонцэцэг |
| 17 | 7 хоногийн хамгийн их уншигдсан ном | 28 | 3/1/2024 | 3/5/2024 | | 218 | | Г.Энхбилэг |
| 18 | Эмэгтэй танд март | 73 | 3/6/2024 | 3/10/2024 | | 58 | | Г.Энхбилэг |
| 19 | Уран зохиол | 30 | | | | 28 | | Д.Мөнхгэрэл |
| 20 | [illegible] | 45 | 2024/02/28 | 2024/02/28 | | 98 | | М.Ариунбаяр |

## 13. СУРГАЛТ, МЭДЭЭЛЭЛ

Нийт 15 төрлийн сургалтыг 32 удаа 1412 хүнд хүргэн ажиллаа.

1. Бүх нийтийн соёлын боловсрол олгох **“Монгол хүний эрхэмлэх үнэт зүйл”**, **“Номын соёлт ертөнц”** сэдэвт сургалтыг нийт 5 удаа 469 хүүхдэд
2. **“Гэр бүлийн соёл"** боловсролын хөтөлбөрийг 1-р цэцэрлэгийн 3 бүлэгт, 5-р цэцэрлэгийн 2 бүлэгт тус тус явуулсан. Нийт 85 хүүхэд хамрагдсан.
3. **“Гэр бүлийн үнэт зүйл”** боловсролын хөтөлбөрийг ЭМГ, ЭБЦТС, Авто тээвэр, БТСДС гэсэн 4 байгууллагын 61 хүнд хүргэлээ.
4. **"Байгаль эх дэлхийгээ хайрлая"** боловсролын хөтөлбөрт 3, 4, 7-р цэцэрлэгийн 172 хүүхдэд явууллаа.
5. **"Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх"** сургалтыг аймгийн Цагдаагийн газрын Хүүхдийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахлах дэслэгч П.Шинэцэцэгтэй хамтран 3-р сургуулийн бага ангийн 45 сурагчийн дунд явууллаа.
6. **"Монгол хүний эрхэмлэн дээдлэх үнэт зүйл"** боловсролын хөтөлбөрийг Соёл судлаач, доктор, профессор багш Д.Дарьсүрэнтэй хамтран явууллаа. Нийт НЭ, ГХБХБГ гэсэн 2 байгууллагын 29 хүн хамрагдсан.
7. **"Ураг удмаа мэдье Угийн бичгээ хөтөлцгөөе"** боловсролын хөтөлбөрийг МУГБ Ш.Шийтэртэй хамтран дунд ахлах ангийн 165 сурагчдад явуулав.
8. **"Мэндлэх хүндлэх соёл"** боловсролын хөтөлбөрийг 2-р сургуулийн бага ангийн хүүхдүүдийн дунд явууллаа. Нийт 24 хүүхэд хамрагдсан.
9. **"Байгууллагын соёл"** сэдэвт боловсролын хөтөлбөрийг 1, 3, 4-р цэцэрлэг ЭБЦТС-ийн хамт олонд явууллаа. Нийт 48 хүн хамрагдсан.
10. **“Номын хавчуурга”** сургалтад 1, 2-р сургуулийн бага ангийн 60 сурагч хамрагдаж, бүтээлч чадвараа хөгжүүллээ.
11. **"Монгол дээл"** боловсролын хөтөлбөрийг Булган сумын 1,2,4,6-р цэцэрлэгийн ахлах, бэлтгэл бүлгийн багачуудад явууллаа. Нийт оролцогч 198
12. **“Айраг, дэмбээний соёл сурталчлах”** ажлыг ЕБС-ийн 2, 3-р сургуулийн дунд, ахлах ангийн 48 сурагчийн дунд зохион байгууллаа.
13. **Үндэсний өвлөн уламжлагч**, арьс ширээр малын эд хэрэгсэл урлаач, өрхийн үйлдвэрлэгч Дэндэв овогтой Жаргалсайханы хийсэн бүтээлээс танилцуулж байна. Тус эрхэм өөрийн гэр бүлийн хүний хамт өрхийн үйлдвэрлэл эрхэлдэг. Зах зээлийн үеэс одоог хүртэл 20 гаруй жил арьс ширэн эдлэл хийж олон бүтээл урлан хэрэглэгч олонд хүргэсээр байгаа билээ. Нийт оролцогч 3
14. **“Эсгий урлал хийх сургалт”** нүүдлийн ахуй уламжлал, соёлын биет бус өвийг сурталчилах сургалтыг Соёл судлаач, доктор, профессор багш Д.Дарьсүрэнтэй хамтран явууллаа. Булган сумын 3-р багийн 5 иргэнд зохион явууллаа.

## 14. СОЁЛ ОЛОН ТҮМНИЙ АЖИЛ

72 ажилд 8549 хүн хамруулсан. 10,538,300 төгрөг зарцуулсан. Соёл олон түмний ажлын дэлгэрэнгүй хүснэгтийг дор оруууллаа.

| № | Зохион явуулсан ажлын нэр | Хамтран ажилласан байгууллага | Огноо /тоо хооронд ташуу зураас авах/ | Оролцсон хүний тоо | Хариуцсан ажилтан гарын үсэг |
|---|---|---|---|---|---|
| 1 | "МОНГОЛ ӨВ СОЁЛ" сарын аян "Дээлтэй албан хаагч" | | 2/1/2024 | 650 | АННС |
| 2 | "МОНГОЛ ӨВ СОЁЛ" сарын аян "Дээлтэй уншигч" | | 2/1/2024 | | АННС |
| 3 | "МОНГОЛ ӨВ СОЁЛ" сарын аян "Бидний өв соёл" цахим бичлэгийн уралдаан | | 2/1/2024 | | АННС |
| 8 | "Бидний бичиг соёл" уралдаан үндэсний бичгээр "Хурдан уншлага" | | 4/17/2024 | 215 | АННС |
| 9 | "Бидний бичиг соёл" уралдаан Буриадын өв соёл сэдэвт үндэсний бичгээр "ХАНЫН СОНИН" бүтээх | | 4/17/2024 | 16 | АННС |
| 10 | "Бидний бичиг соёл" уралдаан Төр нийгмийн зүтгэлтэн С.Удвалын тухай үндэсний бичгээр "БЯЦХАН НОМ" бүтээх | | 4/17/2024 | 16 | АННС |
| 12 | "Номын нэр таах" хүүхэд гэр бүлийн тэмцээн | | 5/17/2024 | 9 | АННС |
| 13 | "МААЗ", "Монгол тоглоом" тэмцээн | | 5/17/2024 | 33 | АННС |
| 14 | Түргэн хэллэг | | 5/17/2024 | 8 | АННС |
| 15 | Оньсого | | 5/17/2024 | 3 | АННС |
| 16 | Номын хэлэлцүүлэг | | 5/17/2024 | 8 | Б.Ариунжаргал, Ц.Долгор |
| 17 | АХА тэмцээн | ЭӨЦС 6г | 5/18/2024 | 10 | Б.Ариунжаргал |
| 18 | Шагаа тоглоом | ЭӨЦС 2г | 5/19/2024 | 41 | Б.Ариунжаргал |

| № | Зохион явуулсан ажлын нэр | Хамтран ажилласан байгууллага | Огноо /тоо хооронд ташуу зураас авах/ | Оролцсон хүний тоо | Хариуцсан ажилтан гарын үсэг |
|---|---|---|---|---|---|
| 37 | Гэр бүлийн уншлага | 5-р баг, Г.Бат-Оршихын гэр бүлд | 2024/02/05 | 3 | Г.Энхбилэг |
| 38 | Гэр бүлийн уншлага | 3-р баг, Оюунчимэг, Эрдэнэцэцэг, Цогзолмаа, Батдалай | | 28 | Д.Отгонцэцэг |
| 41 | **Алтаргана 2024 "Номын уралдаан"** | | 7/25/2024 | 70 | |
| 42 | **Алтаргана 2024 "Яруу найрагын уралдаан"** | | 7/25/2024 | 25 | |
| 45 | **1-р баг Тоглоом наадгай сурталчлах тэмцээн** | | | 8 | |
| 46 | **2-р баг АХА тэмцээн** | | | 15 | |
| 47 | **3-р баг АХА тэмцээн** | | | 8 | |
| 48 | **4-р баг АХА тэмцээн** | | | 9 | |
| 53 | "Үлгэр домог, хууч яриа" | | | 17 | |
| 55 | "Уран бичлэг" уралдааныг дунд, ахлах ангийн сурагчид, насанд хүрэгчдийн дунд зохион байгууллаа. | | | 135 | |
| 60 | "Монгол хүний эрхэмлэн дээдлэх үнэт зүйл" боловсролын хөтөлбөр | Соёл судлаач, доктор, профессор багш Д.Дарьсүрэнтэ | | 29 | |
| 71 | Бүтээлч уншлага, Өглөөний уншлага хаалтийн үйл ажиллагаа | | | 300 | |
| 72 | "Ном хөж" танин мэдэхүйн тоглоом | | | 12 | |
| 73 | Мэргэжил сурталчилах эвент 4 удаа | 2024.09.16 | | 465 | |

## 15. ШИНЭЛЭГ АЖИЛ:

1. Соёлын орон зай арга хэмжээг угтан **"УХААН ДАЛАЙ НОМООС ЭХТЭЙ"** эвентийг идэвхтэн уншигчдын дунд зохион байгуулсан.
2. **"НОМЫН ШИДТЭНГҮҮД"** маскот: Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр номын санчид үлгэрийн баатруудын дүрд хувирч соёл олон нийтийн ажлаа зохион байгуулсан нь хүүхэд багачуудын сонирхолыг маш их татсан.
3. Соёлын бүтээлч сарын хүрээнд 10 төрлийн боловсролын хөтөлбөр санаачлан явуулсан. Ирэх жилүүдэд улам чанаржуулах шаардлагатай байна.
4. **"МОНГОЛ ӨВ СОЁЛ"** сарын аян "Дээлтэй албан хаагч", "Дээлтэй уншигч", "Бидний өв соёл" цахим бичлэгийн уралдааныг тус тус зохион байгуулсан. Багш сурагчид их идэвхтэй оролцсон.
5. **"БИДНИЙ БИЧИГ СОЁЛ"** уралдаан үндэсний бичгээр "Хурдан уншлага", Буриадын өв соёл сэдэвт үндэсний бичгээр "ХАНЫН СОНИН" бүтээх, Төр нийгмийн зүтгэлтэн С.Удвалын тухай үндэсний бичгээр "БЯЦХАН НОМ" бүтээх уралдаанд багш сурагчид идэвхтэй хамрагдсан.
6. **"НОМЫН ЭЛЧ"** номтой богцийг тусгай хэрэгцээт үйлчлүүлэгч нарт хүргэсэн. Номын элч өмсгөлтэй болж соёл олон нийтийн үйл ажиллагаандаа өмсөж байна.

7. **“УНШИГЧ ГЭР БҮЛ”** аян зохион байгуулсан. Нийт 6 гэр бүл 11 удаа гэр бүлийн уншлагад хамрагдсан.
8. **“АЛТАРГАНА НААДАМ”-ын** 2 төрлийн уралдааны зохион байгуулалтыг хариуцан ажилласан. Буриад яруу найргийн уралдаанд 16 яруу найрагч 2 насны ангилалаар, Номын уралдаанд 54 зохиолчийн 63 бүтээл 4 төрлөөр оролцсон.
9. Нутаг орны холбогдолтой мэдлэгийг нэмэгдүүлэх зорилготой **“Ном хож”** оюуны тоглоомыг албан байгууллага, айл өрхөд явуулж эхэлсэн.

**АМЖИЛТУУД:**

- 2024 оны 12 сарын 25-нд номын сангийн шинэ барилгаа бүрэн хүлээн авч, үйл ажиллагаагаа явуулахад бэлэн болсон.
- Булган аймгийн нийтийн номын сангийн арга зүйч Ч.Цэндмаа 2024 оны аймгийн Соёлын салбарын “Шилдэг номын санч”-аар шалгарсан.
- Аймгийн “Соёлын түүчээ”-ын нэгдсэн арга хэмжээнд Сагсан бөмбөгийн 3*3 төрөлд мөнгөн медаль авсан.

**16. 2024 ОНД ШИНЭЭР ХИЙХ АЖЛУУД:**

- Соёл гэгээрлийн чиглэлээр болосвролын хөтөлбөрүүд боловсруулж, олон нийтэд чанартай хүргэн ажиллах.
- “Үндэсний бичиг, соёлын жил”-ийн хүрээнд соёл гэгээрлийн ажлууд зохион байгуулах

## 17. ХҮНИЙ НӨӨЦ, БОЛОВСОН ХҮЧИН

Булган аймгийн Нийтийн номын сан нь захирал, арга зүйч, сан хөмрөгч, номын санч 5, нягтлан бодогч, үйлчлэгч гэсэн 10 орон тоотой ажиллаа. 2 мэргэжлийн номын санч, 4 мэргэжлийн бус номын санч байна. Номын санч Д.Мөнхгэрэл, Д.Отгонцэцэг, Г.Энхбилэг, Б.Ариунжаргал нар СУИС-ийн Соёлын сургуульд эчнээгээр суралцаж байна.

Булган аймгийн хэмжээнд сумын 17 номын сан, 22 сургуулийн номын санд 39 номын санч ажиллаж байгаагаас 3 сум, 3 сургуулийн 6 буюу 15,3% нь мэргэжлийн номын санч байна.

АННС мэргэжлийн боловсон хүчин 7 ажилтан байхаас 3 мэргэжлийн 4 номын санч эчнээгээр суралцаж, боловсон хүчний хангалт 50%-тай байна.

## 18. ТӨСӨВ, САНХҮҮ

2024 оны эхний үлдэгдэл 7674,5 улсын төсвийн санхүүжилт 342039,3 дээд шатны төсвөөс төсвийн байгууллагын өөрийн орлого 1000,0 орон нутгийн төсвийн санхүүжилт 29610,1 төгрөг нийт 381323,9 төгрөгний төсөвтэй ажиллаа.

1. Улсын төсвийн санхүүжилт орлого: 350714,2, /Гурван зуун тавин сая долоон зуун арван дөрвөн мянган хоёр зуун төгрөг/

Үйл ажиллагааны зардал -80101- 312555,4
Урсгал зардал -80802- 1572,3
Эрдэм шинэжилгээний ажлын зардалд -80215- 10000,0

Нэмэлт дээд шатнаас -83603- 210801 /Бусдаар гүйцэтгүүлэх ажиллагаа- 1000,0

Гүйцэтгэл суурилсан санхүүжилт - 25584,3

2. Орон нутгийн төсвийн санхүүжилт орлого: 29610,1 /Хорин есөн сая зургаан зуун арван мянга нэг зуун төгрөг/
3. Иргэд. Аж ахуй нэгж. ТББ -ын хандив - 3403,8 /Ном/
4. Хөрөнгө оруулалт 17634,9 /Үнэ төлбөргүй үндсэн хөрөнгө/
5. Зарлага: 360275,4/ Гурван зуун жаран сая хоёр зуун наян далан таван мянга дөрвөн зуун төгрөг/

Цалин хөлс,нэмэгдэл, урамшуулал - 245248,8
НДШ - 29445,2
Байр ашиглалтын зардал - 24714,3
Хангамжийн бараа - 16621,2
Дотоод томилолт - 2679,7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ - 12481,0
Бараа үйлчилгээний зардал - 5005,2
Эрдэм шинэжилгээний ажил - 10000,0
Нэг удаагийн тэтгэмж - 1552,7
Улс,Орон нутгийн төвлөрүүлэх шилжүүлэг - 12527,3

2024 онд ажиллагсадын нийгмийн асуудлаар үр дүнгийн урамшуулал давхадсан тоогоор 41 хүнд 25122,5 мян.төг, түлээ, нүүрс, халаалтын зардлын хөнгөлөлт 3834,0 мян.төг олгогдсон байна.

Төсвийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ чухал шаардлагатай байгаа техник хэрэгслэлийг 2023 оны гүйцэтгэлийн санхүүжилтээр 10233.5,0 мян.төгрөгний үнэ бүхий агуулах хийх кантинер 8500,0 мян.төг -1ш, Проектор 1733,5 мян.төг -1ш, 2024 хөрөнгө оруулалт 17634,9 мян.төг /үнэ төлбөргүй үндсэн хөрөнгө/, хандиваар 3403,8 мян.төг үндсэн үйл ажиллагааны зардлаас 7444,4 мян.төг, техник,тоног төхөөрөмж 6630,0 мян.төг,тавилга,эд хогшил 5218,0 мян.төг нийт 29525,9 мян.төгрөгний үндсэн хөрөнгө худалдан авч ННБ тусган бүртгэлжүүлэв.

Цагаан сар, ахмадын баяраар байгууллагын ахмадуудаа хүндэтгэл үзүүлэхэд 646,3 мян.төг төгрөг зарцуулсан байна.

## 19.БУСАД АЖИЛ

- Бүх ажиллагсад эрт илрүүлэг эрүүл мэндийн үзлэгт 100% хамрагдсан.
- Улсын хэмжээний Команд штабын сургуулилтад бэлтгэл ханган, гадаа цуглах аюулгүйн тэмдэглэгээ хийн 1 удаа оролцлоо.
- ОБГ-ын хавар, намрын зарлан мэдээллэх дуут дохиогоор, дадлага сургуулилтад бэлтгэл хангаж 2 удаа хамрагдсан.

- Авто зам дагуух бүх нийтийн хавар намрын цэвэрлэгээнд цагдаагийн постноос цааш 800 м хуваарьт газраа 2 удаа цэвэрлэсэн.
- “Тэр бум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд Сансар-2 цэцэрлэгт хүрээлэнд тарьсан модуудаа хавар, намар хуваарийн дагуу тогтмол усалгаа арчилгааг хийж байна.
- Өвлийн турш байгууллага орчмын нийтийн явган замын цасыг цэвэрлэсэн.
- Хуучин байшин буулгах, шинэ байшингаа цэвэрлэх ажилд бүх ажилтан оролцлоо.
- Хуучин байшигаас түрээсийн байрлуу нүүх, түрээсийн байрнаас шинэ байшинлуу нүүх нүүдлийн ажилд бүх ажилтан оролцлоо.

## 20. СУДАЛГАА

Үйлчилгээний чанар хүртээмж, үйлчлүүлэгчийн эрэлт хүсэлт, ном хэвлэлийн хүрэлцээ хангамжийг тандан судлах зорилгоор улирал бүр 100 буюу нийт 450 уншигчаас сэтгэл ханамжийн судалгааг дараах байдлаар авч ажиллаа. Сэтгэл ханамжийн судалгаа бүрт уншигчдын хамгийн их хүсдэг үйлчилгээний орчин нөхцөл, тохь тухтай байдал 2025 онд шинэ барилгадаа нүүн орж үйл ажиллагаагаа явуулснаар бүрэн хангагдахаар болж байна.

### 1. СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА

Энэхүү судалгааны үр дүнд Нийтийн уншлагын танхим **/НУТ/**-ын үйл ажиллагааг сайжруулах, уншигчдын эрэлт хэрэгцээг хангах, зохион байгуулж байгаа СОНА-ын үр өгөөжийг нэмэгдүүлэх юм. ***Судалгаанд оролцогчийн:***

***Нас:*** а. 18 нас хүртлэх б. 18-24 нас в. 25-36 нас г. 51-ээс дээш

***Хүйс:*** а. эрэгтэй б.эмэгтэй

**1.** Та Нийтийн уншлагын танхимаар үйлчлүүлдэг үү?

а. Тийм б. Үгүй в. Заримдаа

**2.** Таны хэрэгцээт ном, хэвлэл, гарын авлага НУТ-д хүртээмжтэй байдаг уу?

а. Хангалттай б. Хангалтгүй в. Хүртээмжийг нэмэгдүүлэх

**3.** НУТ-аас зохион байгуулж байгаа Соёл олон нийтийн ажил таны сэтгэлд нийцэж байна уу?

а. Маш сайн б. Дунд зэрэг в. Оролцож байгаагүй г. Муу

**4.** НУТ-ын танд үзүүлж байгаа үйлчилгээнд үнэлгээ өгнө үү?

а. Сайн б. Муу в. Үйлчилгээг илүү сайжруулах

**5.** Танхимын номын санчийн харилцаа, хандлага танд ямар санагддаг вэ?

а. Сайн б. Дунд в. Муу

**6.** НУТ уншигчдын үйлчлүүлэх тав тухтай орчин нөхцлийг бүрдүүлж чадсан уу?

а. Сайн б. Дунд зэрэг в. Муу

**7.** НУТ-аас та цаашид ямар үйлчилгээ авахыг хүсэж байна вэ? Саналаа бичээрэй.

........................................................................................................................................
.........................................................................................................................................
........................

**ӨӨРИЙН ҮНЭТЭЙ САНАЛАА БИДЭНД ИЛГЭЭСЭН ТАНД БАЯРЛАЛАА**

## СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ SWOT ШИНЖИЛГЭЭ

Энэхүү судалгааны үр дүнд Нийтийн уншлагын танхим **/НУТ/**-ын үйл ажиллагааг сайжруулах, уншигчдын эрэлт хэрэгцээг хангах, зохион байгуулж байгаа Соёл олон нийтийн ажил /СОНА/-ын үр өгөөжийг нэмэгдүүлэх юм.

Энэхүү судалгааг 30 ширхэг хэвлэж 30 уншигч хамрагдсан. Тус санал асуулгын сэдвийн хүрээнд доорх асуултуудыг асуув. Үүнд:

***Нас:***

- 18 нас хүртлэх – 2 6.6%
- 18-24 нас - 3 10%
- 25-36 нас – 12 40%
- 37-50 нас – 2 6.6%
- 51-ээс дээш – 11 43%

***Хүйс:***

- Эрэгтэй - 11 36.6%
- Эмэгтэй - 19 63.3%

1. Та Нийтийн уншлагын танхимаар үйлчлүүлдэг үү?

- Тийм - 14 46.6%
- Үгүй - 10 33.3%
- Заримдаа - 6 10.8%

2. Таны хэрэгцээт ном, хэвлэл, гарын авлага НУТ-д хүртээмжтэй байдаг уу?

- Хангалттай – 14 46.6%
- Хангалтгүй – 0 0%
- Хүртээмжийг нэмэгдүүлэх – 16 53.3%

3. НУТ-аас зохион байгуулж байгаа Соёл олон нийтийн ажил таны сэтгэлд нийцэж байна уу?

- Маш сайн – 21 70%
- Дунд зэрэг – 9 30%
- Оролцож байгаагүй – 0% 0%
- Муу – 0% 0%

4. НУТ-ын танд үзүүлж байгаа үйлчилгээнд үнэлгээ өгнө үү?

- Сайн – 12 40%
- Муу – 0 0%
- Үйлчилгээг илүү сайжруулах – 18 60%

5. Танхимын номын санчийн харилцаа, хандлага танд ямар санагддаг вэ?

- Сайн – 28 93.3%
- Дунд – 2 6.6%
- Муу – 0 0%

6. НУТ уншигчдын үйлчлүүлэх тав тухтай орчин нөхцлийг бүрдүүлж чадсан уу?

- Сайн – 24 80%
- Дунд зэрэг – 5 16.6%
- Муу – 1 3.3%

6-р сарын 17-21-ныг хүртэлх АЧУУТ 1-р баг дээр ажиллахад явуулын номын сангаар үйлчлүүлсэн уншигчдын судалгаанаас үзэхэд судалгаанд хамрагдсан уншигчдын ихэнхи хувь буюу 46% нь номын сангаар үйлчлүүлдэг, 46.6% нь номын хүррտээмж хангалттай, 70% нь СОНА маш сайн гэсэн байна.. Үүнээс дүгнэхэд явуулын номын сангийн үйлчилгээг багт хүргэсэнээр номын сангаар үйлчлүүлэх ирэгсэдийн тоо чанаржиж, ном олголтын эргэлт нэмэгдэх давуу талтай юм.

***SWOT:*** Санал, хүсэлт асуулгаас үзэхэд:

- ✓ Номын санд уншигч ирэгсэдийг татах шинэлэг ажлыг зохион байгуулах нь номын санд хамрагдах хүмүүсийн тоо чанаржижи нэмэгдэх,
- ✓ Шинээр гарч байгаа уран зохиолын номнуудаар баяжилт хийх,
- ✓ Нэн тэргүүнд шинэ стандартын барилгатай болох шаардлагатай байна гэсэн дүгнэлтэд хүрлээ.

## 21. ДҮГНЭЛТ

Ажилтан албан хаагчдын мэдлэг чадварыг нэмэгдүүлэх тал дээр анхаарч сургалт зөвлөгөөнд оролцуулж бусад аймаг хотын номын сангуудаар туршлага судласан нь өмнөх жилүүдээс илүү хөрөнгө зарцуулсан ажил болсон.

Номын сангийн салбарт шинээр нэвтрүүлж байгаа нэгдсэн системийг бусад аймгуудаас түрүүлж ашиглаж эхэлсэн.

Номын сангийн стандарт шаардлага хангасан, орчин үеийн жишигт нийцсэн нэг удаа 200-250 хүн үйлчлэх хүчин чадалтай шинэ номын сангийн барилга баригдаж 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр улсын комисс хүлээн авсан.

Шинэ барилга баригдах хугацаанд түрээсийн байранд үйл ажиллагаа явуулж үйлчилгээний хүртээмж хязгаарлагдмал байсан ч нүүдэл явуулын номын сангийн үйлчилгээг түлхүү хүргэж ажилласан.

Цаашид шинэ барилгын ашиглалтыг жигдрүүлж уншигч үйлчлүүлэгчдэд үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд хүний нөөц боловсон хүчнийг нэмэгдүүлж ажиллах шаардлага тулгарч байна.

## 22. СОНА-ЫН ИЛТГЭХ ХУУДСУУД

### ХҮҮХДИЙН ЖАРГАЛАНТ ЗУСЛАНД “ЗУНЫ ЗУГААТАЙ УНШЛАГА” ЯВУУЛЫН НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛСЭН ИЛТГЭХ ХУУДАС

Тус зуслан ашиглалтад орсонг тохиолдуулан амрагч хүүхдүүдийн дунд “Зуны зугаатай уншлага” явуулын номын сангийн үйлчилгээг 2024 оны 06 сарын 24-нөөс 07 сарын 05 хүртэл хугацаанд зохион байгууллаа. Хүүхдүүдийг өдрийн 11 цагаас 12 цаг хүртэл хугацаанд төрөл бүрийн шинжлэх ухааны номын үзэсгэлэн гарган сурталчилан таниулж, бүтээлч уншлага зохион байгуулж, хөгжөөнт тэмцээнүүд явуулж чөлөөт цагийг нь үр дүнтэй өнгөрүүлэхэд ХГБХГ-тай хамтран ажиллаа. Үүнд:

- 1, 2-р ээлжний амрагч сурагчид “Одод”, “Мичид”, “Сансар” гэсэн 3 бүлэгт хуваагдсан байсан ба 1-р ээжлний 3 бүлгийн 80 хүүхэд, 2-р ээлжний 95 хүүхдэд давхардсан тоогоор 9 хоногийн турш 780 хүүхдэд, 800 номоор үйлчилсэн.
- Явуулын номын сангийн номын үзэсгэлэнг нийт 150 номоор гаргасан.
- Танин мэдэхүйн “АХА”
- “Үсэглэлийн хаад”
- “Номын хэлэлцүүлэг”
- “Чанга шивнээ”
- “Монгол ардын тоглоом наадгай”
- “Монгол ардын аман зохиол” гэх мэт тэмцээн зохион явуулсан нь амрагч хүүхдүүдэд

зугаатай, үр дүнтэй ажил болсон.




 

**“ҮНДЭСНИЙ БИЧИГ, СОЁЛ, НОМЫН ӨДРҮҮД-2024” НАМРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛСАН ТУХАЙ ИЛТГЭХ ХУУДАС**

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.17 дахь заалт, “Номын баяр тэмдэглэн өнгөрүүлэх тухай” Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлигийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 36 дахь удаагийн “Үндэсний бичиг, соёл, номын өдрүүд”-ийг НОМТОЙ МОНГОЛ уриан дор 2024 оны 09 дугаар сарын 20-нд 1 өдөр Булган Цогт хун тайжийн талбайд зохион байгууллаа.

Номын өдрүүдийн үйл ажиллагааг зохион байгуулах ажлын төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулан баталж, Аймгийн Хөгжимт Жүжгийн театр, Булган сумын Соёлын ордон, Аймгийн Музейтэй хамтран зохион байгуулав. Номын өдрүүдийн үйл ажиллагааны хүрээнд зохион байгуулсан ажлуудад нийтдээ 1000 гаруй хүн оролцлоо. Энэ удаагийн Номын өдрүүдийн үйл ажиллагаанд нийт 2,165,000 төгрөг зарцуулсан.

**Тэргүүний уншигч "Нацагдорж тэмдэг" -ээр**

- 1-р сургуулийн 6а ангийн Ганболдын Энх-Үжин
- 1-р сургуулийн 12а ангийн сурагч Баасандамбын Одмаа
- Идэвхтэн уншигч малчин Адьяагийн Алтанхүү
- Мээж ТӨХК-ийн ажилтан Володягийн Ууганболд

 





**“ҮНДЭСНИЙ БИЧИГ ҮСГИЙН БАЯР”**-ын өдрийг тохиолдуулан дараах ажлыг зохион байгуулав: Үүнд:

- **“Номын санч”** мэргэжил сурталчлах өдөрлөг: Тус өдөрлөгийг 1, 2-р сургуулийн 250 гаруй хүүхдэд явуулж, “Мэргэжлийн онцлог давуу тал”, “Бүх нийтийн Соёлын боловсрол”, “Номын соёлт ертөнц” гэсэн мэдээллийг өгч ажиллаа.










- **“Ухаан далай номоос эхтэй”** эвент арга хэмжээг насанд хүрэгчдийн дунд зохион байгуулж нийт 11 хүн урилгаар оролцож уншлагын соёлын тухай ярилцлаа.
  Тус баярын өдөр дараах үйл ажиллагааг зохион байгуулав. Үүнд:

**Шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн:** Монгол хэл дээрх 60 ширхэг ном, үндэсний бичгээр бичигдсэн 40 номоор тус тус үзэсгэлэн гаргаж, тус үйл ажиллагаанд ирсэн 1000 орчим хүн үзэж сонирхсон.




Хүүхдийн **“Уншсан номын тэмдэглэл”-**ийн үзэсгэлэн: Бага, дунд, ахлах ангийн хүүхдүүдийн 165 дэвтрээр үзэсгэлэн гаргалаа. 300 орчим хүн үзсэн.





**“Гар урлал”-**ын бүтээлийн үзэсгэлэн, худалдаа, бүтээл хийх бодит сургалт, туршилт /номын хавчуурга, эсгий урлал г.м./: 60 хүнд бодитоор зүү ороох, нэхмэл нэхэх, эсгий урлах туршилт хийлгэн зааж өгсөн. 3 төрлийн 21 бүтээлээр үзэсгэлэн гаргасан.

**“Үндэсний бичиг”-**ийн  соёлын боловсролын хөтөлбөр  /үзэсгэлэн, сургалт/: АННС, 2-р сургуулийн багш Ч.Отгонбаяр, 1-р сургуулийн МХУЗ-ын багш Г.Мөнх-Уянга, Т.Туяацэцэг нар үзэсгэлэн дэлгэж уран бичлэгийн сургалт зохион байгууллаа. Нийт 500 орчим хүн үзэж сонирхсон.





“Чингисийн чулууны бичиг”, “Цогтын  хадны чулууны бичээс”-ийг сурталчилсан соёлын боловсролын хөтөлбөр зохион байгууллаа. Нийт 300 гаруй хүүхэд хамрагдлаа.

**“Үл мартагдах түүх”** үзэсгэлэн: 20 бүтээлээр үзэсгэлэн гаргасан. Нийт 200 гаруй хүн үзэж сонирхлоо.

**Номын үзэсгэлэн худалдаа:** 200-аад номоор шинэ номын үзэсгэлэн худалдаа гаргаж, 300 гаруй хүн үзэж, 30 орчим хүн худалдан авалт хийлээ.




**“Англи номын үзэсгэлэн”** Англи хэл дээрх SPELLING BEE үг үсэглэх тэмцээн: 30 гаруй англи номоор үзэсгэлэн гаргаж 10 хүүхдийн дунд үсэглэлийн тэмцээн явуулав.
**“Монгол өв уламжлал”** өртөө, аман зохиол, тоглоом наадгай уралдаан: Нийт 600 орчим хүн үзэж сонирхож, 16 хүүхдийн дунд аман зохиол, тоглоом наадгайн тэмцээн зохион байгуулж 5 хүүхдийг урамшууллаа.





**“Үлгэрээс үлгэрлэе”** сэдэвт жүжигчилсэн тоглолт: Номын сангийн дэргэдэх уран уншлагын дугуйлангийн хүүхдүүд аймгийн Хөгжимт жүжгийн театрын жүжиг ангийн уран бүтээлчидтэй хамтран 12 жил үлгэрийг найруулан тогололоо.



**“Ном амилсан өдөр”** дүрийн уралдаан: Нийт 17 үлгэр оролцлоо.
1-р байр: 1-р сургуулийн Б.Эрхбаяр багштай 12А ангийн "Аманцар эхнэр"
2-р байр: 2-р сургуулийн Б.Жаргалдулам багштай 11В ангийн "7 бор оготно"
3-р байр: 1-р сургуулийн Б.Эрхбаяр багштай 12А ангийн "Үнсгэлжин"
4-р байр: 1-р сургуулийн О.Дүүрэнжаргал багштай 10Б анги "Алиса гайхамшгийн оронд"
4-р байр: 1-р сургуулийн Ш.Энхчимэг багштай 6А анги "Цасан гоо ба 7 одой"
















**Уралдааны шагнал гардуулах:**













**“Open mic” зохион байгуулах:** Нийт 10 хүүхэд оролцож, 3 хүүхдийн ХЖТ-аас урамшууллаа.





## “ҮНДЭСНИЙ БИЧИГ, СОЁЛ, НОМЫН ӨДРҮҮД-2024” ХАВРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛСАН ТУХАЙ ИЛТГЭХ ХУУДАС

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.17 дахь заалт, “Номын баяр тэмдэглэн өнгөрүүлэх тухай” Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлигийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 34 дэхь удаагийн “Үндэсний бичиг, соёл, номын өдрүүд”-ийг НОМТОЙ МОНГОЛ уриан дор 2024 оны 05 дугаар сарын 17-нд 1 өдөр Булган сумын Соёлын ордон /*цаг агаарын байдлаас шалтгаалан*/ дотор зохион байгууллаа.

Номын өдрүүдийн үйл ажиллагааг зохион байгуулах ажлын төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулан баталж, Булган сумын Соёлын ордон, Аймгийн Музейтэй хамтран зохион байгуулав. Номын өдрүүдийн үйл ажиллагааны хүрээнд зохион байгуулсан ажлуудад нийтдээ 750 гаруй хүн оролцлоо. Энэ удаагийн Номын өдрүүдийн үйл ажиллагаанд нийт 1293000 төгрөг зарцуулсан.

**Тэргүүний уншигч "Нацагдорж тэмдэг" -ээр**

- Сүхбаатарын Сэргэлэнбаатар, ЭӨЦС-ийн 10 а анги

- Даваанямх Өнөмөнх, ЭӨЦС-ийн 10 а анги
- Мөнхбат Ган-Эрдэнэ, 1-р сургууль 9а анги
- Баяндэлгэр Сайнжаргал, өндөр настан






Тус баярыг тохиолдуулан **"ҮНДЭСНИЙ БИЧИГ ҮСГИЙН БАЯР"**-ын өдрийг тохиолдуулан 2024 оны 04 сарын 17-ноос 05 сарын 17-н хүртэл хугацаанд зохион байгуулсан **"БИДНИЙ БИЧИГ СОЁЛ"** уралдаанд нийт 247 хүн оролцлоо.

- "Буриадын өв соёл" сэдэвт үндэсний бичгээр **"ХАНЫН СОНИН"** бүтээх уралдаанд нийт 16 бүтээл,
